



СТРАТЕГИ АКАДЕМИ
— 1955 —

СТРАТЕГИЙН СУДАЛГАА

ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ: ХАМТЫН САЙН САЙХАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ: ХАМТЫН САЙН САЙХАН

2022 оны 9 сар №3 (10)

Эрхлэн гаргасан:

А.Хишигтөгс

Хянан тохиолдуулсан:

Б.Болорсайхан

СТРАТЕГИ АКАДЕМИ ТББ

Хаяг: Тусгаар тогтнолын ордон, 5 давхар,
(зүүн жигүүр) 8-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14200-Монгол Улс

E-mail: info@strategy-academy.mn

Facebook: Стратеги Академи

Twitter: [sa_mongolia](https://twitter.com/sa_mongolia)

Суурин утас: +976 77444182

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН

ISSN: 2709-2100

© ЗОХИОГЧИЙН ЭРХ ХАМГААЛСАН БҮТЭЭЛ

2022 он

АГУУЛГА

Боловсрол бараа, бүтээгдэхүүн, арилжаа биш болох нь	4
Боловсролын тэгш бус байдал буюу үндэслэл	5
Зах зээл болон нийгмийн бодлого боловсролыг булаалдах нь.....	10
Боловсрол дахь ашгийн бус ба ашгийн төлөө этгээд.....	13
Хувийн сургуулиудыг төрөөс зохицуулах шаардлага	22
Боловсрол дахь төрийн бус оролцогч талуудын үүрэг	26
Боловсролд өрийн нөлөө	28
Ашгийн төлөөх заалт нь албан боловсролтой нийцэхгүй	34
Боловсролын хуулийн шинэчлэл: иргэний нийгмийн санал	38
Бүх нийтийн боловсрол ба хамтын сайн сайхан.....	42
Ерөнхий асуудал ба шийдэл.....	54
Абижаны зарчмууд	56
Ашигласан материал.....	83

БОЛОВСРОЛ БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮН, АРИЛЖАА БИШ БОЛОХ НЬ

Хураангуйн оронд

Боловсрол бол хүн бүр төрөлх байдлаасаа үл хамааран хөгжиж дэвшин хүн ёсоор амьдарч, аж төрөх боломж, түлхүүр мөн. Боловсрол нь **явцуу утгаараа**, хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх бөгөөд нэр төртэй, эрх чөлөөтэй, хараат бус амьдрах баталгаа билээ. Харин **өргөн утгаараа**, хамтын амьдралын мөн чанарыг тодорхойлогч бөгөөд хүмүүнлэг, ардчилсан, шударга нийгэмд амьдрах суурь хүчин зүйл, хүн бүрийн боломж бололцоо гэлтэй.

Гэтэл хүн бүрийн хүн ёсоор амьдрах энэ боломж, түлхүүр нь хүн бүрийн гарт хүрэхгүй, тэр ч бүү хэл зиндаачлагдан харилцан адилгүй, эрс ялгарал үүсгэж буй явдал нь боловсролоор ашиг олох гэсэн явуургүй тогтолцооноос үүдэлтэй. Энэ нь нийтийн сайн сайхан буюу боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр зэрэг нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах Төрийн ачааллыг хуваалцдаг хувийн хэвшлийг эсэргүүцэж байгаа хэрэг биш. Харин асуудлыг улам бүр хүндрүүлж, нийгмийн тэгш бус байдлыг гааруулж, нэг хүний боломжийг үгүй хийх замаар нөгөө хүний эрх ашигт үйлчлэгч суурь тогтолцоог оронгоор нь өөрчлөх тухай асуудал мөн.

Ашгийн төлөө боловсролын байгууллагын хувьд мөнгө, санхүү зорилго нь болж, түүнд хүрэх арга хэрэгсэл нь боловсрол болж байдаг бол ашгийн төлөө бус боловсролын байгууллагын хувьд боловсрол зорилго нь болж, түүнд хүрэх арга хэрэгсэл нь мөнгө, санхүү байдаг.

Боловсролын салбарт хамаарах аливаа хуулийн этгээд, нэрлэвэл, хувийн байгууллагын сургалт, үйлчилгээ эрхлэгч нь гагцхүү зах зээлийн хуулийн зарчмаар ажиллах бус харин бүх нийтийн сайн сайханд харшлахгүй, цаашилбал тогтвортой хөгжлийн үзэл санаанд нийцэх замаар ажиллах учиртай.

Бизнесийн байгууллагын зорилго ашиг олох явдал хэмээн үзвэл боловсролын байгууллага ашгийн байх нь бизнесийн байгууллагаас ер ялгаагүйг илтгэнэ. Боловсролын ашгийн болон ашгийн бус байдлыг нарийн ялгаж тодорхойлсон зааг хомс тул энэ сэтгүүлд эхлээд тэдгээрийн ялгааг тодотгож, улмаар нийгмийн асуудалд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлсний эцэст шийдэл, санал гаргана.

БОЛОВСРОЛЫН ТЭГШ БУС БАЙДАЛ БУЮУ ҮНДЭСЛЭЛ

Боловсрол нь хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болж байдаг хэдий ч бас нийгмийн тэгш бус байдал үүсгэх дисфункц¹ гүйцэтгэдэг. Энэ утгаараа хүмүүнлэг нийгэм болоод ардчиллын хэрхэхийг шийдвэрлэх нөлөөтэй байдаг. Иймд энэ бүлгийн үндэслэлийг МУИС-ийн социологийн багш, доктор Г.Түмэннастын *Боловсролын тэгш бус байдал ардчиллын хувь заяатай холбоотой асуудал*² хэмээх нийтлэлд суурилан тайлбарлав.

Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд нийслэлд ч, орон нутагт ч ерөнхий боловсролын төрийн өмчий сургуулиудын чанар, хүртээмжид ихээхэн ялгаатай байдал бий болж, эцэг эхчүүд нийгмийн байр байдлаасаа хамаарч хүүхдүүдэд сайн гэгдэх сургуулиудад өгөх хандлага даамжирсан юм. Учир нь бага, дунд боловсролын хувийн сургуулийг улсын сургуулиас илүү чанартай сургалт өгдөг гэх итгэл үнэмшилтэй холбоотой бөгөөд үнэндээ тийм биш. Хүүхдэдээ чанартай боловсрол олгох гэсэн эцэг эхэд буруу үгүй, харин нийгмийн тогтолцоонд гол асуудал бий. Өөрөөр хэлбэл, 1990 оноос хойш манай улсад хэрэгжиж эхэлсэн неолиберал зах зээлийн зарчим болох бүхнийг хувьчилж, өрсөлдөөнд суурилсан зах зээлийн гарт үлдээх замаар хөгжилд хүрнэ гэсэн зарчимтай холбоотой.

Боловсролын хуулийн шинэчлэл: Иргэний нийгмийн санал тайланд, сүүлийн хориод жилд боловсролд неолиберал зах зээлийн зарчим, хандлага илт нэвтэрснээр боловсрол олгодог хувийн хэвшлийн оролцогчдын тоо эрс нэмэгдсэн дэлхийн хөгжлийн чиг хандлагаас Монгол Улс хоцроогүй юм. Анхны хувийн сургуулиуд 1993 онд Улаанбаатар, Дархан хотод байгуулагдаж байсан бол өнөөдөр нийт сургуулийн 19.9 хувийг хувийн хэвшлийн сургууль эзэлж, нийт суралцагчдын 7 хувь нь төрийн бус өмчийн сургуульд суралцаж байна. Тэдний тодорхой хувь нь өөрсдийгөө ашгийн төлөөх байгууллага гэж тодорхойлсон байгааг дараах хүснэгтээс харж болно.³

	Ашгийн	Ашгийн бус
Боловсрол сургалтын байгууллага	26	670

Гэхдээ энэ бол ердөө бүртгэлийн тоо гэдгийг харгалзах хэрэгтэй. Ашгийн бус сургууль гэж бүртгүүлсэн ч үүсгэн байгуулагч эсвэл захиралдаа үлэмж хэмжээний цалин өгсөн байдаг. Өндөр төлбөртэй байх, хөтөлбөрийнхөө

1 А.Х: Disfunction буюу сөрөг үүрэг нь социологич Роберт Мертоныхоор, нийгмийн тогтолцооны бүтцэд тодорхой үүрэг гүйцэтгэхээр зориулсан чиг үүрэгт нь үл нийцэх хүсээгүй үр дагавар.

2 Түмэннаст, Г. Боловсролын тэгш бус байдал ардчиллын хувь заяатай холбоотой, нийтлэл 2020.9.2. Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://gogo.mn/r/x0w6m>

3 “Бүх нийт боловсролын төлөө!” *Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Боловсролын хуулийн шинэчлэл: Иргэний нийгмийн санал*, 2021.

хамгийн зардалтай хэсгүүдийг хасч танан зардлаа багасгасан байх, хамгийн их дэмжлэг хэрэгтэй суралцагчдыг сургуулиасаа хасах, элсүүлэхгүй байх, сургуулийн барилга байшин хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох эрхэд суурилагагүй байх зэрэг нь боловсролоос ашиг олж байгааг харуулах магадлалтай (“Бүх нийтийн боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2021). Эсвэл бүртгэл нь ашгийн бус мөртлөө практик дээр ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэн явуулдаг боловсролын байгууллага байхыг ч үгүйсгэхгүй.

Улсын болон хувийн сургуулиудын хоорондын сургалтын хөтөлбөр, орчин, үйлчилгээний чанарын ялгаа эрс гүнзгийрч, асар өндөр төлбөр бүхий хувийн сургуулиуд ч бий боллоо.

Гэвч хамгийн гол нь хувийн сургуулийн сургалтын чанар улсын сургуулийнхаас илүү биш.⁴ Үүнийг PISA⁵ буюу сурлагын амжилтын олон улсын үнэлгээгээр тогтоосон (Тунгалаг, 2022). Хувийн сургуулиуд чанартай гэдэг нотолгоо дэлхий даяар байхгүй. Байвал маш бага хэмжээний чанарын ялгаа байгаа гэдэг PISA шалгалтаар тодорхой болсон. Өөрөөр хэлбэл, өндөр төлбөртэй хувийн сургууль нь аюулгүй байдал, соёлын капитал, хангамжаар илүү байгаа нь боловсролын чанараар илүү гэсэн иллуз⁶ үүсгэжээ.

Нийгмийн шинжлэх ухаанд дэлхий даяар ардчилсан засаглалын хөгжилд тулгарч буй нэг том сорилт бол тэгш бус байдал гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Хүмүүнлэг онолч, судлаачид ардчиллыг хамгаалж бэхжүүлэхийн тулд тэгш бус байдлыг бууруулах ардчилсан засаглалын өөрийнх нь чадавхыг чухалчлан үзэж байна. Тэгш бус байдалд нөлөөлөгч маш чухал хүчин зүйл бол боловсрол. Боловсролын тэгш бус байдал ардчиллын өөрийнх нь хувь заяатай холбоотой асуудал.

Жишээ нь өндөр төлбөртэй үнэтэй элит хувийн сургуулиуд, чансаа өндөртэй хувийн сургуулиуд, Кембриж хөтөлбөртэй төрийн өмчийн сургуулиуд, нийслэлийн уламжлалт нэр хүндтэй улсын сургуулиуд, тусгайлан хөтөлбөрөөр тордсон орон нутгийн лаборатори сургуулиуд, уламжлалт нэр хүндтэй улсын сургуулиуд, хотын төвийн болон томоохон хүн ам төвлөрсөн орон нутгийн улсын сургуулиуд, гэр хорооллын болон сумын сургуулиуд, хотын захын алслагдсан болон жижиг сумын сургуулиуд гэх мэтээр ангилагджээ.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын (цаашид НҮБ гэх) Хүүхдийн эрхийн конвенц дахь 2-р зүйлд оролцогч улс орнууд хүүхдүүдийн нийгмийн гарал, эд хөрөнгө, төрсөн байршлаас үл хамааран тэдний эрхийг хэрэгжүүлнэ гэсэн, мөн 3-р зүйлээс хууль тогтоогчийн хувьд аливаа шийдвэртээ хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зарчим бий болдог.

4 Тунгалаг, Д. “Өрөг” хэлэлцүүлгийн 2022 оны 5 сарын 24-ны өдрийн дугаар. Тэнгэр телевиз. Хураангуй бичвэр үзэх холбоос: <https://ikon.mn/n/2kww>

5 Олон улсын хэмжээнд чанарыг судлах 15 настнуудын шалгалт (Programme for International Student Assessment)

6 А.Х: Illusion буюу төөрөгдөл, хуурмаг зүйл, буруу итгэл үнэмшил.

Социологи буюу социал утгаар боловсрол нь нийгмийн хөдлөнгө чанарын⁷ чухал хүчин зүйл болдог. Өөрөөр хэлбэл боловсрол хүүхдүүдийг төрөлх байдал, ээж аавынх нь буюу ар гэрийн боломж бололцооноос үл хамаарч, нийгмийн аль ч байр суурьд хүрэх тэгш боломж олгодог. Гэтэл манайх шиг боловсролын тэгш бус байдлыг тогтолцооны хувьд дэмжиж байгаа нийгэмд боловсролын институцийн энэ чиг үүргийн тухай ярих утгагүй болж байна. Хүүхдүүд хэнийд, хаана төрж өсөж байгаагаас хамаарч боловсролын үлэмж ялгаатай орчинд суралцаж байна.

Францын социологич Пиер Бурьеде тэртээ 1970-аад онд Францын нийгэмд янз бүрийн давхаргын хүүхдүүдийн сургуулиас хүртэх үр шим, сурлагын амжилт нь тэдгээрийн эцэг эхийн дундах капиталын хуваарилалттай холбоотой байгааг илчилж, шүүмжилж байв. Ер нь Монголд ерөнхий боловсролоос хүүхдүүдийн хүртэж буй үр шим тэдний эцэг эхийн нийгмийн байдлаас хамаарч хүчтэй ялгаралд орсныг судлаачид дүгнэсээр байна. Улс төрийн ардчилсан дэглэм, зах зээлийн эдийн засаг бүхий оронд нийгмийн тэгш бус байдал жам ёсны үзэгдэл ч, улс орны засгийн газруудын хувьд тэгш бус байдлыг бууруулах эн тэргүүний бодлого нь боловсрол юм.

Ядуурал өндөртэй манай нийгэмд үндэсний бүх нийтийн боловсролоо тэтгэхгүй бол хүмүүнлэг чанараа алдсан боловсролын эрчинд чинээлэг, статус өндөртэй гэр бүлийн хүүхдүүд үлддэг ялгарал бүтцийн хувьд далдуур чимээгүй явагдсаар байна. Бурдьегийн үзсэний адил, манайд өдгөө хүүхдүүдийг эцэг эхийнх нь нийгмийн гарал, давхаргад нь дөнгөлж хаях бүхэл бүтцийг лавшруулахад хүрээд байна.

Боловсрол нь ядууралтай холбоотой асуудал. Ядуурлын тойрог архаг ядуурлыг бий болгодог, архаг ядуурлаас ядуурлын соёл бий болдог, энэ тойргийн эхлэх цэг нь хүүхдүүд хаана, хэнийд төрснөөсөө болж дорой боловсрол авах явдал байдаг. Манайд ядуурлын соёл хэдийнээ ажиглагдаж эхэлсэн. Манайд ядуурлыг бууруулах асуудал дээр амжилт бий болохгүй байгаа нь ч үүнтэй холбоотой бөгөөд цаашид ийм бодлого үргэлжилбэл өнөөгийн суурь боловсролын тогтолцоо ядуурал даамжрахад их хувь нэмэр оруулах болно.

Боловсролын салбар дахь чанар, хүртээмжийн ялгаатай байдал нь ядуурал үе дамжиж бөхлөгдөхөд хувь нэмэр оруулж байгаа юм. Өөрөөр хэлбэл, ядуу, орлого багатай өрхийн хүүхдүүд чанарын хувьд бусдаас доогуур боловсрол эзэмшсэнээр хожмын ядууралд хүрэх бүтцийн шинжтэй шалтгаан оршин байна.

Боловсрол, эрүүл мэнд болон бусад нийгмийн суурь үйлчилгээг арилжааны шинжтэй зүйл болгож болохгүй гэсэн нийгмийн сэтгэгчдийн үзэл баримтлал байдаг. Ерөнхий боловсролын хүрээнд үүнийг институцийн хувьд уламжлал болгоод ирсэн умард болон баруун европын орнууд байна. Энэ

7 А.Х: Social mobility бол нийгмийн статусаа өөрчлөх, тухайлбал нийгмийн нэг давхаргаас нөгөөд шилжих хөдлөнгө чанар.

нь марксизмын уламжлалаас бий болсон декоммодификац⁸ хэмээх ойлголт. Харин боловсролыг чөлөөт арилжааны дэглэмд шилжүүлснээр чинээлэг хэсгийн хүүхдийн боловсрол ядуу хэсгийнхээс үлэмж тасран холдоно.

Тиймээс улс орнууд хувийн сургуулийн төлбөрт хязгаар тавих ба энэ төрлийн үйлчилгээнд ашиг орлогоор хөөцөлдөх явдлыг хориглодог. Түүнчлэн, төсвийн ил тод байдлын шаардлага тавьдаг. Боловсрол бол хүний эрх, нийгмийн үндсэн хэрэгцээ бөгөөд энэ арилжаалагдах учиргүй гэдэг нь үүнтэй холбоотой.

Нөгөө талаас улс орнуудад эдгээр сургуулиуд нь төрийн үйлчилгээний дутуу орон зайг нөхөх чиглэлд үүрэг гүйцэтгэж ирсэн байдаг бол манайд нефтийн магнат нь ч оролцдог бизнесийн ашиг орлого олох салбар болох талаас нь илүү хөөцөлдсөн гажуудал болсонд асуудал байна. Түүнчлэн, хамрах тойргоос хальсан замбараагүйдэл, чинээлэг хэсгийнхний зиндаархал болсонд асуудал байна.

Ерөнхий боловсролын хувийн сургуулиудын төлбөрийн дээд тал нь дундаж цалингаас 80 дахин илүү байхад олонх нь 5-10 дахин илүү байна. Авлигаар хөрөнгөжсөн давхарга бий болсон нийгэмд ийм бизнес цэцэглэдэг нь харагдаж байна.

Үүнээс гадна улсын сургуулийг мартаж болохгүй. Илүү нэр хүндтэй, чансаатай улсын сургуулиудад авлига, шан харамжийн схем бий болж, тэдгээрт илүү байр суурь эсвэл бэл бэнчин бүхий гэр бүлийн хүүхдүүд шавах болж, түүний авлигын ханшийг ард түмэн ч мэдэх болжээ. Цаашлаад Кембриж хөтөлбөртэй нийтийн сургуулиуд бий болсон нь авлигын уут үүсэх нөхцөлийг бий болгож байна.

Хувийн сургуулиудыг бодлогоор дэмжиж ирсэн нь улс төрчид энэ төрлийн бизнест хамааралтай байгаад оршино. Энэ нь дээд боловсролд илүү хамаарах боловч ерөнхий боловсролд огт хамаагүй зүйл бишээ.

Боловсролын тэгш бус байдал нь хүүхдийн хүмүүжилд хор хөнөөлтэй бөгөөд ирээдүйн нийгэмд бусдыг хүндэтгэх, эрх тэгш байх, эв санаагаар нэгдсэн байх үзэл санааг доройтуулж байна. Дунд сургуулийн фокус бүлгийн ярилцлагын үеэр өндөр үнэтэй элит сургуулиудад сурч буй хүүхдүүдийн дунд “ирээдүйд бидэнд үйлчлэх хүмүүсийг хаана бэлддэг вэ?” гэсэн яриа болсон байдаг.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Боловсролын яам 2025 оны тавдугаар сараас эхлэн тус улсын өндөр төлбөртэй, элит дунд сургуулиудын үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргажээ.⁹ Боловсролын сайд Ёо Юн Хэ “Боловсролын систем дэх тэгш бус байдал цаашдаа нийгмийн ялгаатай

8 А.Х: Decommmodification буюу хөдөлмөр, хайр, хоногийн 24 цаг, эрүүл мэнд, боловсрол гэх мэт хүний өөрийн мэдлийн зүйлс бараа таваар мэт арилжигдаж болохгүй гэсэн хүмүүнлэг ойлголт.

9 The Strait Times, Өмнөд Солонгос нийгмийн тэгш бус байдлыг бий болгож буй боловсролын ялгааг арилгахын тулд 2025 онд элит ахлах сургуулиудыг татан буулгана, мэдээ, 2019.11.8. Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://www.straitstimes.com/asia/east-asia/south-korea-to-abolish-elite-high-schools-in-2025-to-fix-education-disparity-that>

анги давхарга үүсгэх нөхцөл бүрдүүлэхээс олон нийт болгоомжилж байна”.¹⁰ Хувийн элит сургуулиудын төлбөр энгийн сургуулиудынхтай харьцуулахад дунджаар гурав дахин өндөр байдаг нь нийгэмд ялгаатай байдал үүсгэх нөхцөл болж байгаа (Yonhap News Agency, 2019).¹¹

Манай улсын хувьд сургуулийн системд өмчийн холимог хэлбэрийн хөгжлийн замнал нэгэнт явсан тул хувийн сургуулийн хүрээнд ашиг хөөцөлдөхгүй, хамрах тойрогтоо байх, зиндаархах өвчнөөс ангид байх зохицуулалт хэрэгтэй (Түмэннаст, 2020). Энэ зохицуулалт нь засгийн газраас хэрэгжүүлэх нийгмийн бодлого, түүнчлэн хууль тогтоомж, эрх зүйн өөрчлөлт шинэчлэлт, тогтоомж зэрэг төрийн үр нөлөөтэй, бүх нийтийн эрх ашгийг хангасан үйлдлээс эхлэх учиртай.



10 Korea JoongAng Daily, 2025 онд 79 тусгай ахлах сургуулийг ердийн сургууль болгоно, мэдээ, 2019.11.7. Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://koreajoongangdaily.joins.com/2019/11/07/socialAffairs/79-special-high-schools-to-become-regular-in-2025/3069980.html>

11 The Korea Bizwire, Өмнөд Солонгос 2025 он гэхэд Элит сургуулиудыг Ерөнхий сургууль болгоно, мэдээ, 2019.11.7. Дэлгэрэнгүй үзэх холбоос: <http://koreabizwire.com/s-korea-to-turn-key-elite-schools-into-general-ones-by-2025/147369>

ЗАХ ЗЭЭЛ БОЛОН НИЙГМИЙН БОДЛОГО БОЛОВСРОЛЫГ БУЛААЛДАХ НЬ

Боловсролын асуудлыг тодорхойлсон энэ бүлэг нь социологич А.Хишигтөгсийн *Хүнийсэл*¹² ном болон Хүүхдийг Ивээх Сангийн *Хүүхдийн эрхийн нөхцөл байдал*¹³ тайланд үндэслэсэн болно.

Боловсрол хүртэж чадах эсэх нь шууд л ар гэрийн хөрөнгө мөнгөний асуудал болж хувирчээ. Ингэж хүний авьяас чадвар болоод сурах хүсэл тэмүүлэл мөнгөнийхөө хэмжээнд хүлэгдэж унтарна. Ерөнхий боловсролын сургуулиуд хүртэл үнэ өртгөөр ялгарч давхаргаас хамааралтай ухамсрыг бүрэлдүүлсээр байна. Социологич Бурдыегийн үзсэнээр, нийгмийн янз бүрийн ангиас гаралтай хүүхдүүдийн тэгш бус сурлагын амжилт болон янз бүрийн давхаргуудаас гаралтай хүүхдүүдийн боловсролын зах зээл дээрээс олж хүртэж чадах ялгамж бүхий үр ашгууд нь тэдгээр анги болон давхаргуудын дундах соёлын капиталын хуваарилалттай холбоотой. Ядуурал хувь хүнээс хамаардаггүй, харин тогтолцооноос хамаардаг. Боловсрол нь соёлын капитал болоод нийгмийн капитал болдог байсан бол ар гэрийн санхүүгийн чадамжаас улбаалж эдийн засгийн капиталтай эн зэрэгцэн холбогдов. Соёлын капитал нь ирээдүйд хуримтлагдаж, худалдагдаж, хэрэглэгдэж болох юмс ба социал давхраажлаас үүдэлтэй.

Неолиберал нэрийн дор ерөнхий боловсролын сургуулийн жинхэнэ утгыг үгүй хийдэг хэт өндөр төлбөртэй хувийн сургуулиуд хүүхдийг багаас нь нийгмээс тусдаа мэт соёлын капиталын мэдрэмжээр дүүргэсээр. Хүүхдүүд боловсролын суурь болох эрдэм, ёс суртахуун, хамтрал, харилцааг өөртөө бий болгох байтал эсрэгээр уралдсан, хувиа хичээсэн, шалгалтын хариултын төлөө хуулсан ёс суртахуунгүйгээр бүтэцлэгджээ. Боловсролоор бизнес хийх явдал энд тэнд олшров.

Нийгмийн хандлага Улаанбаатар хотыг хоёр гүүрний наана, цаана гэж 2 давхаргад хуваах болжээ. Гүүрний цаана суурьшигчид нь хүүхдээ захын буюу гэр хорооллын дундах сургуульд хэзээ ч өгөхгүй гэсэн байр суурьтай байхад гүүрний наана суурьшигчид нь хувийн буюу өндөр төлбөртэй сургуульд хүүхдээ суралцуулах хүсэлтэй. Ерөнхий боловсролын сургуулиуд хувийн байна гэдэг мөнгөтэй айлын хүүхдийн урдах зам гэрлээр зурайж, мөнгөгүй боломж тааруу айлын хүүхдийн урдах зам гудамтайгаа адил харанхуйгаар бүгнэ. Хэнийг ч ялгаварлалгүй эдийн засгийн капиталаараа хувь заяагаа дурандахгүй байхын тулд төрийн хар хайрцагны бодлогодоо ерөнхий боловсролын сургуулиудыг (цаашид ЕБС гэх) ялгаагүй болгохыг тусгах хэрэгтэй.

Түүнчлэн сургалт эх хэл дээр явагдах ёстой. Гадаадын хувь эзэмшигчтэй хувийн сургуулиуд даяаршилд уусгаж, ялангуяа англи хэлт ертөнцийнхөн

¹² Хишигтөгс, А. Хүнийсэл: Өөртөө хөөгдсөн хүн, Улаанбаатар, 2020.

¹³ Хүүхдийг Ивээх Сан, Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ, Улаанбаатар, 2020.

хежемоничлох¹⁴ гэдэг. ЕБС-ийн сургалт нь зөвхөн эх хэл дээр болоод нийтийнх байх ёстой. Төр, иргэний нийгмийн оролцоогүй үед боловсролын институцийн гажуудал улам лавширдаг.

Санхүүгийн чадамжаас хамаарч сургуулиуд ялгавартай болж ерөнхий боловсролыг алдагдуулахгүйн тулд нийгмийн бодлого шаардлагатай. Өндөр төлбөртэй хувийн сургуульд суралцагчид болон захын сургуулийн суралцагчид төгсөн нийгэмд тааралдах үед соёлын капиталын асар том ангал үүсэж, ялгаварлал үүсгэхгүйн тулд боловсролын институцийг зах зээлд зөнд нь үлдээж болохгүй (Жишигтөгс, 2020).

Социологич Луис Алтүссер *Үзэл суртал ба төрийн аппаратууд* бүтээлдээ сургууль, боловсролын байгууллагууд нь ажилчин ангийн сурагч хүүхдүүдийг мөлжлөгийн амьдралаар хүлээж авахад нь бэлтгэх байдлаар хөрөнгөтөн ангийн ашиг сонирхолд үйлчилдэг гэжээ (Althusser, 2014).¹⁵ Харин өндөр төлбөртэй хувийн сургууль нь ХХ зуунаас өмнө зөвхөн язгууртан, лам, ноёдын хүүхэд л бичиг үсэгтэй байсан шиг боловсролын тэгш бус байдлыг бататган бэхжүүлэхэд зүтгэж байгаагаа ухаарахгүй байна.

Нийт ЕБС-ийн 18 хувийг эзэлж буй хувийн сургуулиуд боловсролын зах зээлийн ачааллыг хуваалцаж, өрсөлдөөнийг бий болгож буй боловч бүх хүүхдэд амьдралын гарааны тэгш боломжийг бий болгох учиртай боловсролын гол үүргийг эргэн харахыг сануулж, нийгэмд ялгаатай байдлыг үүсгэж байгаа талаар иргэний нийгмийн байгууллагууд тэмдэглэж байна.

Ядуурлын дүр төрх судалгааны тайланд амьжиргаа сайтай өрхийн хүүхдүүд бага наснаасаа хувийн сургуульд илүү хамрагдах хандлагатай байна хэмээн дүгнэжээ (Үндэсний Статистикийн Хороо; Дэлхийн Банк, 2020).¹⁶ Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээс үзэхэд хүүхдүүд орлогын ядууралд өртсөөр байгаа бөгөөд нийт хүүхдийн 28.9 хувь нь ядуу өрхөд амьдарч байгаа бөгөөд эдгээр хүүхэд нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа хүмүүсийн 46 хувийг бүрдүүлж байна.¹⁷ Монгол Улсад хамгийн өндөр төлбөртэй хувийн ЕБС-ийн нэг жилийн сургалтын дээд төлбөр 130 сая төгрөг байна.¹⁸

Өндөр төлбөр бүхий хувийн сургуулиудад төр хувьсах зардал олгож буюу төрийн бус өмчит сургуулиуд ашигтай ажиллахынхаа сацуу төсвийн дэмжлэг авч байгаа нь татвар төлөгчдийн ийтэд хүртээлгүй зарцуулж буй хэрэг болж байна. Энэ асуудлыг 2014 оноос эхлэн улсын парламентэд хөндсөөр байгаа боловч дорвитой хэлэлцсэн удаагүй юм. Жил бүр төсвийн зардал нь

14 А.Х. Негемону нь ноёрхол, жанжлал, давамгайлал гэсэн утгыг илэрхийлнэ. Карл Марксынхаар материаллаг капиталыг гартаа атгаж буй ноёлогч анги идей болон оюуныг ч бас гартаа атгадаг. Философич Антони Грамши үүнээс санаа авч, хежемониг тодорхойлохдоо, соёлыг гартаа атгаж буй хэсэг нь нийгмийн ангийг тодорхойлдог гэж үзсэн.

15 Althusser, On the Reproduction of Capitalism: Ideology and Ideological State Apparatuses, 2014.

16 Үндэсний Статистикийн Хороо; Дэлхийн Банк, Ядуурлын дүр төрх 2018, Улаанбаатар, 2020.

17 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

18 2022 оны 8 сарын 1-ний өдрийн байдлаар Монгол Улсын өндөр төлбөртэй хувийн сургуулийн жилийн төлбөр 40,900 доллар байна.

Дэлгэрэнгүй холбоос: <https://isumongolia.edu.mn/p/tuition-fees>

орлогоосоо давж алдагдалтай ажилладаг Засгийн газар аль болох төсвийг танах бодлого баримталдаг ч өндөр төлбөртэй хувийн сургуулиудад татаас олгож, хувьсах зардал өгсөөр байгаа нь төсвийн алдагдалтай бодлогыг үүсгэх гол хүчин зүйл болсоор байна.

Эдийн засгийн нийгмийн давхаргын зөрүү нь хүүхдүүдийн боловсролыг тэгш бус байдалд хүргэж байна. Тиймээс сургуулийн өмнөх боловсрол (цаашид СӨБ гэх) болон ЕБС-ийн боловсрол олгох институтууд нийтийн хүртээлд хүрэх ёстой болж харин хувийн цэцэрлэг, сургуульд өндөр төлбөртэй суралцдаг байдлыг Үндсэн хуулийн тэгш эрхийн хүрээнд хязгаарлах хэрэгтэй. Яагаад гэвэл эдийн засгийн капиталын ялгаатай байдал нь соёлын капиталын тэгш бус байдалд хүргэж байна. Тиймээс нийгмийн хуваарилалт болоод өмчийн асуудалд хянуур хандах шаардлага урган гарч байна. Өрхүүд амжиргааны түвшнээсээ хамааран хүүхдийнхээ боловсролд эрс ялгаатай хөрөнгө оруулалт хийж байна.

Боловсролыг хүртээгчид буюу багш нар хувийн хэвшлийг илүүд үзэх хандлагатай байгаа бол боловсролыг хүртэгчид буюу хүүхдүүд, олон нийт (хүүхдүүдийн ар гэрийнхэн) төрийн хэвшлийг илүүд үзэх хандлага ажиглагдаж байна. Энэ нь санхүүгийн нөөц бололцоотой шууд холбоотойн улмаас ийн хандлага үүсч байгаа бөгөөд санхүү, мөнгө бололцоо нь хүүхдийн сурч хөгжих эрхийн хэвийн байдлыг алдагдуулж болохгүй юм. Ялангуяа цэцэрлэг болон их дээд сургууль нь хувийн өмчийнх байх нь хэвийн үзэгдэл ч ерөнхий боловсролыг ерөнхий биш ялгаатайгаар олгож болохгүй.

Яагаад гэвэл хүний эрхтэй холбоотой олон улсын баримт бичгүүдэд дээд боловсролыг заавал эзэмшүүлэх албагүй ч ерөнхий боловсролыг хүн бүрд заавал эзэмшүүлбэл зохино хэмээн ерөнхий боловсролыг төр үнэ төлбөргүй бүх хүнд олгоно гэсэн байдаг. Гэтэл маш өндөр төлбөртэй хувийн ЕБС-ууд нийгэмд өрхийн аж байдлын түвшнээс хамаарч боловсролын харилцан адилгүй байдлыг үүсгэсээр байна. Тиймээс баян, ядуугаас үл хамаараад хүүхэд бүрийн “сайн сайхан байдал”-д бодитой өөрчлөлт хэрэгтэй болж байна (Хүүхдийг Ивээх Сан, 2020).

БОЛОВСРОЛ ДАХЬ АШГИЙН БУС БА АШГИЙН ТӨЛӨӨ ЭТГЭЭД

Ардчилсан засаглалыг иргэний нийгэмгүйгээр төсөөлөх ч боломжгүй ба учир нь тус засаглалын мөн чанар нь зайлшгүй иргэний нийгмийг шаарддаг. Боловсрол нь гагцхүү сургууль, төр, суралцагч хоорондын асуудал биш. Хэрэв тийм гэвэл сургуулийн төлбөр тогтооход эцэг эх ямар ч эрх мэдэлгүй, сургалтын агуулга болоод нарийн төвөгтэй үйл ажиллагаа, нөхцөл байдлыг хянахад иргэний нийгэм ямар ч оролцоогүй болох гэх мэт ихээхэн аюултай. Энэ бүлгийг иргэний нийгмийн *Боловсролын хуулийн шинэчлэл: Иргэний нийгмийн санал* тайланд үндэслэв (“Бүх нийтийн боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2021).¹⁹

Юун түрүүнд ашгийн бус гэх учрыг тодруулах нь зүйтэй. Ашгийн бус зорилготойгоор үйл ажиллагаа явуулах үзэл санаа бол Төрөөс үзүүлэх үйлчилгээг бүрэн хамрагдаж чадахгүй байгаа хэсэгт Төрийн үйлчилгээг нөхөх зорилготойгоор анхлан гарч ирсэн. Төрөөс хамааралтай биш, мөн хувийн ашиг олох зарчимтай үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдээс ашиг хуваарилах, ашиг олох зорилгогүйгээр ажилладаг тул гуравдагч буюу ашгийн бус зорилготой (хуулийн этгээд) гэж нэрлэдэг.

Ашгийн бус хуулийн этгээд (NPO)²⁰ нь удирдлага менежментийн хувьд ашгийн төлөө хуулийн этгээдтэй адил уян хатан, шуурхай, хүнд сурталгүй ажиллах, нөгөө талдаа өмчлөлийн хувд олон нийтийн (public) буюу хэн нэг ашиг хүртэгч эзэн, хувь хүн, хуулийн этгээд гэж байх ёсгүй юм.

Хэдий ашгийн бус боловсролын асуудлыг хөндөж байгаа ч зайлшгүй хувийн хэвшлийн сургуулийг авч үзэх болж байгаа нь манай улсын хууль тогтоомжтой холбоотой юм. Монгол Улсын Боловсролын тухай хуульд (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2002):²¹

- 12.3.Төрийн өмчид түшиглэн байгуулах боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус байна.
- 12.4.Төрийн бус өмчид түшиглэн байгуулах боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус болон ашгийн төлөө байна.

Үүнд төрийн өмчийн хэлбэртэй бол ашгийн бус, төрийн бус өмчийн хэлбэртэй бол ашгийн байж болно гэжээ. Иймд бид зайлшгүй хувийн сургуулийн талаар авч үзэх болдог юм. Үүний сацуу төрийн өмчит атлаа хүүхэд элсүүлэхэд хэдийн өөрийн гэсэн үнэ ханш тогтсон, зиндаачлагдсан, авлигажсан, “нэр хүндтэй” гэгдэх улсын сургуулиудыг ч багтаан авч үзэж байгаа билээ.

19 “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Боловсролын хуулийн шинэчлэл: Иргэний нийгмийн санал, 2021.

20 Nonprofit Organizations

21 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Боловсролын тухай хууль
Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/9020>

Тэгэхээр боловсрол ашгийн төлөө байх нь боловсролын мөн чанартай зөрчилддөг тул ашгийн бус байх нь хүн бүрийн эрхийг хангах болон нийгмийн сайн сайхан байдалд тустай.

Боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ашгийн төлөө бус байгууллагууд салбарын хууль тогтоомжийн хүрээнд харилцан адилгүй зохицуулагдаж, бүртгэл, тайлагналын хувьд ойлгомжгүй байдал үүсгэж, ашгийн болон ашгийн бус үйл ажиллагааг ялгаж салгахад ч хүндрэл учруулж ирлээ.

Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчлөлтэй байж болох бөгөөд ашгийн төлөө болон ашгийн бус зорилготойгоор үйл ажиллагаа явуулж болохоор Иргэний хуульд нээлттэй зохицуулсан байдаг. Гэтэл хуулийн этгээдийг тодорхойлсон Иргэний хуульд “ашгийн төлөө”, “ашгийн төлөө бус” зорилго нь хэрхэн ялгагдах, үүнд үндэслэн холбогдох зохицуулалт ямар байхыг тодорхойгүй орхисон. Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг нарийвчлан зохицуулсан бусад хуульд ч энэхүү ялгаа нь тодорхойгүй, бүдэг заагласан байна.

Иргэний хуулийн 25 дугаар зүйлд хуулийн этгээдийг “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ” гэж тодорхойлоод “хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно” гэж заасан байдаг.

Мөн “хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна” гэсэн байгааг анхаарах хэрэгтэй. Манай нийгэмд хувийн л бол ашгийн төлөө байдаг гэсэн ойлголт түгээмэл. Ялангуяа боловсролын салбарт бусад улс оронд хувийн боловч ашгийн бус боловсрол сургалтын байгууллага дийлэнх байна. Сүм хийд, тосгон, төрийн бус байгууллага (цаашид ТББ гэх) зэрэг этгээдийн зүгээс сургууль байгуулж, төлбөргүй, ашгийн бус ажиллуулах нь түгээмэл.

Боловсролд хүнийг аливаа байдлаар ялгаварлан гадуурхахгүй, хүртээмжийн тэгш байдлыг хангах, нийгмийн шударга ёсонд халгүй байх, эрх тэгш байдлыг гүнзгийрүүлэхгүй байх үүргийг хувийн хэвшлийн оролцогчдод үүрүүлж байнга хянаж нягталж байх үүргээ төр биелүүлнэ.

Боловсрол бол нийтийн сайн сайхан (public good) гэж үздэг улс орнууд боловсрол нийтийн эрх ашигт үйлчлэх ёстой ба хувь хүний болон хэсэг бүлэг этгээдийн ашиг сонирхолд үйлчлэх ёсгүй гэж хуульчилсан байдаг (Эквадорын Үндсэн хууль) бол боловсрол, мэдлэг нь төрөөс баталгаажуулдаг нийтийн сайн сайхан (Аргентины Боловсролын хууль), төрөөс боловсролыг хамтын сайн сайхан гэж хөхиүлэн дэмжинэ (Доминикан Улс), боловсрол бол нийгмийн сайн сайхан (Бразил Улсын Үндсэн хууль) хувийн хэвшлийн олгож байгаа боловсрол төрийн үйлчилгээ байх шаардлага тавьж, ашгийн

төлөө байхыг хориглодог хуультай улс орнууд нэлээдгүй байна.

Сурч боловсрох эрхийн талаар НҮБ-ын Тусгай илтгэгч Кишор Сингх өөрийн тайландаа ашгийн төлөө сургууль байхыг шууд хориглосон хуультай улс орнууд ч (Финлянд, Катар, Бразил, ӨАБНУ, Хятад, Бахам зэрэг) байгааг дурдаад бусад улс орныг ашгийн төлөө боловсролыг бодлогоор хориглож, хуульчлахыг уриалсан байна.

Арилжаанд чиглэсэн боловсролын хувийн байгууллагууд (Commercially-orientated private educational institutions) гэдэгт үйл ажиллагааных нь үндсэн гол зорилгын нэг нь боловсролын үйлчилгээг худалдах/арилжаалах ба нийтийн ашиг сонирхолд үйлчлэхээс илүүтэй өөрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагдсан байгууллагыг хэлэхээр тодорхойлсон байдаг.

Тэд боловсролыг бараа, бүтээгдэхзэн гэж харах тул ижил төрлийн бусад байгууллагуудтай өрсөлдөж, өөрийн загвар, үйл ажиллагааг өргөжүүлэн тэлж, борлуулалтаа нэмэгдүүлж, улмаар ашиг орлогоо өсгөдөг. Ихэнх тохиолдолд тэдгээр байгууллага өөрсдийгөө төрийн (public) үйлчилгээний үүргийг гүйцэтгэдэг байгууллага, төрийн/нийтийн боловсролын тогтолцоонд нэгдэх, нэгдэхээр бэлтгэх ёстой гэдэг ойлголтыг хүлээн зөвшөөрдөггүй.

Арилжаанд чиглэсэн боловсролын байгууллагын шинж чанар:

Арилжаанд чиглэсэн боловсролын байгууллагын гол ялгарах онцлог нь компанийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахын тулд үйл ажиллагаагаа тэлэх зорилгоор маркетингийн үйл ажиллагаа өргөнөөр явуулах багтана. Илүү олон боломжит үйлчлүүлэгчдэд хүрэхийн тулд сургуулийнхаа талаар зар сурталчилгаа хийж, маркетингийн ажилтан ажилд авч, маркетингийн хэлтэс байгуулж, сонин, зарын самбар, радио, телевизээр зар сурталчилгаа цацаж байна. Сургуультайгаа танилцуулах аялал, найзыгаа авчрах оройн сургууль зохион байгуулах зэргээр харагдах байдлаараа (visibility) татах зорилготой тусгай арга хэмжээнүүд зохион байгуулдаг байна. Зээл авах, өндөр төлбөр тогтоох, төлбөрөө байнга нэмэгдүүлэх, олимпиадад дээгүүр байр эзэлсэн хүүхдийг төлбөргүйгээр элсүүлэх, төгсөгчдөө сурталчлах зэргээр боловсролын тохиролцоо хийх зэрэг нь ашгийн төлөөх шинж чанар гэж үзэж болохоор байна.

Боловсролын тухай хуульд ашгийн төлөө бус боловсрол сургалтын байгууллагыг “ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага” гэж сургалтын үйл ажиллагаа явуулах үндсэн зорилготой, үйл ажиллагаанаасаа олсон ашгийг (орлогыг) зөвхөн үндсэн зорилгын дагуу зарцуулдаг, үндсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагддаггүй хуулийн этгээд” гэж нь ашгийн төлөө бус хуулийн этгээдэд тавих үндсэн шалгуурыг тодруулсан.

Ашгийн төлөө боловсролын байгууллагын хувьд мөнгө санхүү зорилго нь болж, түүнд хүрэх арга хэрэгсэл нь боловсрол байдаг бол ашгийн төлөө бус боловсролын байгууллагын хувьд боловсрол зорилго нь болж, түүнд хүрэх арга хэрэгсэл нь мөнгө санхүү байдаг.

БОЛОВСРОЛ АШГИЙН ТӨЛӨӨ БАЙХЫГ ХААХ, ХЯНАХ МЕХАНИЗМ

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлд 2 чухал заалт байдаг:

1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

3.Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

Япон, Сингапур зэрэг орнууд Хувийн боловсролын талаарх хуультай бөгөөд маш нарийн зохицуулалтай байдаг нь хувийн хэвшлийн зүгээс хүний/хүүхдийн эрхийг зөрчихөөс хувь хүнийг хамгаалах үүргээ төр нь олон улсын гэрээний дагуу биелүүлж байгаа гэсэн үг юм. Төрийн зохицуулалт бол төрийн хүний эрхийг хамгаалах үүргийн хүрээнд багтах ба хэд хэдэн улсын шүүх хувийн боловсрол олгогчдыг төрийн болон олон нийтийн өмнө хариуцан тайлагнах үүрэгтэй гэдэг шийдвэрийг гаргасан байдаг (Непалийн Дээд шүүх, Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх, Энэтхэгийн Дээд шүүх, Колумбийн Үндсэн хуулийн шүүх).

АШГИЙН БУС БОЛОВСРОЛЫН ЖИШИГ:

Сургалтын төлбөрийг зохицуулах

Сургалтын төлбөрийг зохицуулахгүй бол хүн амын тодорхой хэсэгт боловсрол эдийн засгийн хувьд хүртээмжгүй болно. Сургалтын төлбөрийн байж болох дээд хэмжээг зааж өгөх, урьдчилан зөвшөөрөл авалгүй сургалтын төлбөр нэмэхийг хориглож болно (Бутан, Камерун).

Ил тод байх

Эцэг эх, багш, иргэний нийгмийн байгууллагуудад өөрийн үйл ажиллагаа, гүйцэтгэл, менежментийн талаарх мэдээллээ нээлттэй хуваалцах ёстой. Нийгэм, багш, сурагч, орон нутгийн иргэдийн өмнө хувийн хэвшлийн оролцогчдын хүлээх үүрэг, хариуцлагыг маш тодорхой тусгасан зохицуулалт хийх шаардлагатай.

Ашгийн төлөө ажиллаагүй гэдгийг нотлохын тулд жил бүр санхүүжилтийн эх үүсвэрээ тайлагнах үүрэг хүлээлгэж, хувийн сургуулиудын санхүүгийн эх үүсвэрийг хянах ёстой.

Хяналт мониторингийн механизм

Хуулийн хэрэгжилтийг хянах үүднээс төрийн зүгээс Хяналт мониторингийн механизм ажиллуулах ёстой. Хувийн хэвшлийн боловсролын байгууллагууд боловсролоос ашиг олох байдлыг хаахын тулд хэд хэдэн чиглэлээр арга хэмжээ авч болохыг хүний эрхийн хуульчид зөвлөдөг: журамласан, хориглосон, шийтгэлийн хэлбэртэй.

Журамласан зохицуулалт:

Хувийн сургууль байгуулагдах, үйл ажиллагаа явуулах, хөтөлбөр, багшийн мэргэжил, дэд бүтцийн стандарт гэх мэт минимум стандарт тогтоох, өөрөөр

хэлбэл тухайн байгууллагад тавигдах үндсэн шаардлагуудыг тодорхойлж өгнө. Тайлан өгөх үүрэг оноох, тухайлбал, гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн тайлан, мониторингийн ба хяналтын байгууллагаас авсан дүгнэлтийг шаардах ёстой.

Хориглосон зохицуулалт:

Ашгийн төлөө ажиллахыг хориглох, нийгэм-эдийн засгийн тэгш бус байдлыг үүсгэж, бэхжүүлж байдаг тул төлбөр дээр үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг хориглох ёстой. Хувийн сургуулиудыг компани гэж бүртгүүлэхийг хориглох, төрийн өмчийн сургуулиас багш ажилд авахыг хориглох, мэргэжлийн бус багш ажилд авахыг хориглох, хичээлийн жилийн үеэр сургуулиа хаахыг, мэдээлэл муутай эцэг эх, сурагчдыг хуурамч зар сурталчилгаагаар урхидах, батлагдсан төлбөр дээр нэмж, эцэг эх, сурагчдаас, аливаа байдлаар төлбөр хураамж авахыг хориглох ёстой. Хүүхдийг чадвар, нийгмийн болон үндэс гарлаар, ямар нэг хэлбэрийн тестээр шалгаж сонгож авахыг хориглох ёстой.

Шийтгэх зохицуулалт:

Аливаа дүрэм журмыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хураах, луйврын залилангийн, авлигын шинжтэй үйлдлүүд гаргах, багш нарт өгсөн цалин хөлс, олсон ашгаа худал тайлагнах, татвараас зайлсхийх зэрэгт шийтгэл оноохоор зохицуулалтууд байх ёстой. Луйврын, залилангийн, авлигын шинжтэй үйлдлүүдийг мөрдөн шалгах, сурагчдын төлбөрийг авч зугтах зэргээр хууль бус үйлдлүүд хийсэн сургуулийн эздийг эрүүгийн хуулиар шийтгэх нь чухал

НҮБ-ын Сурч боловсрох эрхийн Тусгай илтгэгчид хувийн хэвшлийн оролцогчдыг төрөөс зохицуулахдаа “Абижаны зарчмууд” баримт бичгийг ашиглахыг зөвлөдөг.

ТӨРИЙН БУС ӨМЧИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ НЬ

БОЛОВСРОЛЫН ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГЧ БУЙ САНАЛ:

1. Ашгийн төлөө ба ашгийн төлөө бус боловсрол сургалтын байгууллагуудын талаарх зохицуулалтыг нарийвчлах;
2. Бүх сургууль, боловсрол сургалтын байгууллага ашгийн бус байх заалт тусгах;
3. Төлбөртэй төрийн бус өмчийн сургуульд улсын төсвөөс өгдөг дэмжлэгийг зогсоох;
4. Дараах сургалтын байгууллагыг цаашид төрөөс дэмжлэг үзүүлэхгүй байхаар хуульчлах:
 - эдийн засгийн боломж, чадварыг харж сонголт хийдэг;
 - ашгийн төлөө ажилладаг, эсвэл арилжааны чиглэлтэй;
 - ялгаварлан гадуурхал гаргадаг;

- чанарын шаардлага хангаж чадахгүй байгаа зэргээр эрх зүйн хүрээнд хуулиар хүлээсэн үүрэгтэй нь зөрчилдөх.

Боловсролын багц хуулийн заалтууд уг хуульд өөрөөр заагаагүй бол өмчийн бүх хэлбэрийн боловсрол сургалтын байгууллагад үйлчилнэ гэдгийг тодотгосон заалт оруулах. Хуульд төрийн бус өмчийн боловсрол сургалтын байгууллагын талаар дараах зохицуулалтыг оруулах:

- Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хүүхэд элсүүлэх;
- Сургалтын чанарыг тогтмол хангах, сайжруулах;
- Сургалтын төлбөр тогтоох;
- Сургууль, цэцэрлэг дэх авлигатай тэмцэх зохицуулалт, үр дүн бүхий дотоод хяналтын тогтолцоо бий болгох;
- Боловсролын сургалтын байгууллагын зар сурталчилгаанд тавих хязгаарлалт
- Ялгаварлан гадуурхахгүй байх, хүртээмжтэй байдлыг баталгаажуулсан эрх зүйн зохицуулалт хийх;
- Сургалтын хөтөлбөр, сурах бичиг болон сургалтын бусад материалууд, сургалтын үйл ажиллагаанд, үнэлгээний систем, сургалт явагдаж байгаа хэлэнд хяналт тавих;
- Багш нарын мэргэжил, ур чадварын шаардлага, багш сурагчийн харьцаа, багшийн цалингийн шатлал, доод хэмжээг тогтоох, багшийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг зохицуулах;
- Материаллаг дэд бүтэц: анги танхим, бусад өрөө танхим, орчин, хөгжлийн бэхшээлтэй хүүхдийн орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын гэх мэт шаардлага тавих;
- Сургалтын орчин ба хэрэглэгдэхүүн: сурах бичиг, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, номын сан гэх мэт;
- Хүүхэд хамгаалал (бэлгийн дарамт, бие махбодын шийтгэлээс урьдчилан сэргийлэх хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх тодорхой стандарт болон хяналт тавих аргачлал, дүрэм журам гэх мэт).

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА Олон улсын түвшинд хувийн хэвшлийн сургалтын байгууллагуудын талаар дараах зохицуулалтыг хийдэг байна:

№	Зохицуулалт хийх гол асуудал
1	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийг үүсгэн байгуулах болон “тусгай зөвшөөрөл олгох” улсын бүртгэлд бүртгүүлэх дүрэм, журам
2	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуульд тавигдах шалгуур үзүүлэлт, (тусгай зөвшөөрлийн шаардлага) магадлан итгэмжлэлийн шаардлагууд
3	Санхүүжилтын түвшин, механизм (төсвөөс санхүүжилтээ авах, зарцуулах, тайлагнах гэх мэт үйл явцыг шаардсан байдлаар журамласан байх)
4	Татвар болон гаалийн хураамж
5	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийн засаглал, удирдлагатай холбоотой дүрэм журам
6	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуульд элсүүлэх, хамран сургах журам
7	Сургалтын хөтөлбөр
8	Өдөр тутмын үйл ажиллагаа
9	Мэдээллийг нийтэд, эсвэл эцэг эхэд ил тод болгох шаардлагууд
10	Багш, сурган хүмүүжүүлэгчдийн үйл ажиллагааг зохицуулсан зохицуулалт
11	Багшийн ажиллах нөхцөл, статус, багшийн мэргэжил эзэмшсэн байдал, мэргэшүүлэх сургалт, цалин болон мэргэжлийн ур чадварт тавигдах стандартууд
12	Сургалтын чанарыг баталгаажуулах дүрэм, журам, үйл явц
13	Сургалтын төлбөрийг тогтоох аргачлал (хэрхэн тогтоох, хэн хэн оролцох, төрөөс хэрхэн хянах гэх зэргийг зохицуулсан эсэх удирдамж)
14	Эрүүл ахуй, аюулгүй байдал
15	Хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн авлигатай тэмцэх хууль зүйн зохицуулалт эсхүл өндөр үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоо
16	Эцэг эхийн оролцоог дэмжсэн зохицуулалт
17	Багш нарын холбоог дэмжих баталгаа (Үйлдвэрчний эвлэл, эвлэлдэн нэгдэх байгууллага байгуулах эрхийг баталгаажуулсан)
18	Хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн олгож буй боловсролын чанарын талаарх мэргэжлийн хяналт шалгалт
19	Боловсролын зар сурталчилгаанд нийтийн сайн сайхны тусын тулд хяналт тавих эрх зүйн зохицуулалт
20	Ялгаварлан гадуурхахгүй байх болон хүртээмжтэй байдлыг баталгаажуулсан эрх зүйн зохицуулалт (Хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, гэх мэт хүүхдийг элсүүлэн сургах байдлыг баталгаажуулсан эсэх)

БОЛОВСРОЛЫН ЗАСАГЛАЛ, ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

Монгол Улс “Боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгах” зарчим, бодлогыг төрөөс баримталж ирсэн уламжлалтай. Анх 2015 онд баталсан Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгыг хэрэгжүүлэх амлалтыг манай төр засаг өгчээ. Бүх нийтэд хүртээмжтэй, чанартай, тэгш хамруулсан боловсрол олгох зорилтод хүрэх хариуцлагыг хэнтэй тооцох вэ гэдэг асуулт гарна.

Аливаа улсын төр нь сурч боловсрох эрхийг хангахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой хэдий ч боловсролын салбарын өргөн хүрээний зорилтыг биелүүлэхэд талуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо бүхий харилцаа хамгийн чухал билээ. Хэрэв төрөөс хязгаарлагдмал боломжийн хүрээнд хууль эрхзүйн үндэслэлтэй зорилт, биелэхүйц үйл ажиллагаа явуулж чадвал олон нийтийн итгэл, дэмжлэгийг олж авна. Ингэж чадахгүй, боловсролын тогтолцоо чанартай боловсрол олгохгүй бол ашгийн төлөөх хувийн хэвшлийнхэн энэ орон зайг нөхөж, улмаар зарим үйл ажиллагаа зохицуулалтгүй явагдаж, эмзэг бүлгийн иргэд улам хохирсоор байна.

ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨХ САНХҮҮЖИЛТ

Боловсролд эрх тэгш байдлыг баталгаажуулах нь боловсролын салбарын санхүүжилттэй нягт холбоотой. Хэрэв нөөцийг зөвхөн аль нэг бүлэгт чиглүүлбэл энэ нь бусад бүлэгт ноогдох нөөцөөс авч байна гэсэн үг. Тэгэхээр эрх тэгш байдал гэдэг нь хэсэг бүлэг хүний, хэсэг бүлэг хүүхдийн тухай асуудал биш энэ бол бүх хүүхдийн тухай асуудал юм.

Өмнө нь 2013 онд хийсэн Боловсролын салбарын тойм судалгаанд санхүүжилтээр дамжуулан ялгаварлан гадуурхахгүй байх мөн санхүүжилт нь тэгш бус байдлыг гүнзгийрүүлэхгүй байх ёстой юм гэдгийг сануулжээ. Үүний тодорхой жишээ болох ЕБС-ийн түвшинд лаборатори сургууль, Кембрижийн хөтөлбөртэй, хос хэлний сургууль байгуулах болон бусад санхүүжилтийн сувгаар дамжуулаад тэгш бус байдлыг гүнзгийрүүлэх алхмыг хэрхэвч хийж болохгүй юм.

Санхүүжилтийг эрх тэгш байдлын төлөө болгож хувиргахын тулд дараах гурван асуудлыг анхаарах нь зүйтэй. Үүнд:

1. Боловсролын салбар улс орны хөгжлийн тэргүүлэх салбар гэдгийг (санхүүжилтийн түвшинд) баталгаажуулах: Ослогийн тунхаглал (2008)-аар анх дэвшүүлж Инчоны тунхаглал (2015)-аар баталгаажуулан зөвлөсөн хэмжээ бол улсын төсвийн зардлын 15-20 хувь, эсвэл ДНБ-ний 4-6 хувийг боловсролын салбарт зарцуулах зөвлөмж байдаг. Манай улсын хувьд тодорхой хугацаанд яг энэ чиглэлээр тэргүүн туршлага болон нэрлэгдэж байсан. Боловсролын тухай хуульд төсвийн 20 хувиас доошгүйг боловсролын салбарт зарцуулна гэсэн заалт 2012 он хүртэл тусгасан байв. Энэ заалтыг хуулиас авснаар ухралт хийсэн гэж болно; Боловсролын санхүүжилт хомсдох нь эмзэг бүлэгт чиглэсэн

санхүүжилт ххсагдах эрсдлийг дагуулдаг.

2. Монгол Улсад боловсрол олгох үйл ажиллагаа зардал ихээр шаарддагийг тооцож үзэх. Үүнийг өмнө дурдсан Боловсролын салбарын тойм судалгаанд дараах гурван шалтгаанаар тайлбарласан байдаг. Үүнд:
 - Газар нутаг уудам бөгөөд хүн ам нь тархай суурьшдаг;
 - Удаан үргэлжлэх өвлийн хүйтэн улирлаас хамааран дулаан, халаалтын зардал өндөр гардаг;
 - Боловсролын салбар нь хөдөлмөр багтаамж болон орц ихтэй салбар учраас бусад салбартай харьцуулахад цалингийн зардал өндөр гардаг нь хөдөө орон нутагт боловсролын үйлчилгээг хүргэх зардлыг ихээр нэмэгдүүлж байна.

Хөдөөгийн боловсролыг эсвэл хотынг захын хороодын шилжин суурьшигч хүүхдийн боловсролыг өндөр зардалтай хэмээн орхигдуулах эрсдлийг байнга дагуулна.

3. Улс орны эдийн засгийн нөхцөл болон дэлхий нийтийг хамарсан цар тахлаас улбаатай эрсдэлд анхаарал хандуулах. Үүнд:
 - КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор боловсролын зардалд цахим шилжилтийн зэрэг зардлууд шинээр түрэн орж ирснээр нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн төсөв буурахад нөлөөлөх эрсдэл гарах магадлал байна;
 - Улсын хэмжээнд өнгөрсөн хугацаанд авсан олон өрийн эргэн төлөлт хийгдэх хугацаа ойртон зарим нь төлөгдөж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор тус салбарын төсөвт, ялангуяа эрх тэгш байдалд чиглэсэн санхүүжилтэд сөрөг нөлөө үзүүлэх вий гэсэн болгоомжлол байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХУВИЙН СУРГУУЛИУДЫГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ ШААРДЛАГА

Ашгийн төлөө боловсролын байгууллага нь хувийн сургуулиар илрэн гардаг тухай дээр дурдсан. Иймд төр өөрийн үүргийн хувьд хувийн сургуулиудад стандарт тогтоож бүх нийтийн эрх ашгийг хангах шаардлага үүссэн. Энэ бүлэг нь *Хувийн сургуулиудыг төрөөс зохицуулах шаардлага* тайланд үндэслэв Хувийн сургуулиудыг төрөөс зохицуулах шаардлага (“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2018).²²

Боловсрол дахь хувьчлал болон боловсролыг бизнес гэж үзэх хандлага өсөн нэмэгдэж буй нь олон улсын хэмжээнд сэтгэл зовоосон асуудал болж байна. Энэ нь дан ганц хувийн нэг (сайн, муу) сургуулийн асуудал биш харин хүүхэд бүрт үнэ төлбөргүй, чанартай боловсрол олгох төрийн үйл хэрэгт түүний үзүүлэх нөлөө, хувь нэмрийн тухай асуудал юм. Ялангуяа ашгийн төлөө болон төлбөр төлдөг боловсролыг өргөжүүлэх нь улс орон хүлээсэн үүргийнхээ дагуу нийтлэг чанар, тэгш байдал, чанартай боловсрол олгоход зориулах нэн хэрэгцээтэй санхүүжилт өөр тийш чиглэхийн зэрэгцээгээр боловсролын тогтолцоонд гадуурхал, тэгш бус байдал улам нэмэгдэх асуудлыг үүсгэж байна.

ЯАГААД ХУВИЙН СУРГУУЛИЙГ ЗАХ ЗЭЭЛД ДААТГАХЫГ ЭСЭРГҮҮЦЭХ БОЛОВ?

Улс орнууд 1970-аад онд боловсролын үйлчилгээг хүргэхдээ өөр өөр арга замыг судлан сонгож, хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Жишээ нь, Чили улсад боловсролын хувьчлалын неолиберал туршилтыг батлан хэрэгжүүлж эхэлсэн бол Финланд улс боловсрол дахь тэгш байдалд гол анхаарлаа төвлөрүүлж эхэлжээ. Ингээд 2000 он гарснаас хойших байдлаар хүрсэн ялгаатай үр дүнгүүдийг Олон улсын сурагчийн үнэлгээний хөтөлбөрт (PISA) оролцдог улс орнуудын жагсаалтаас харж болно. Чили Улсад 2011 он гэхэд олон зуун мянган хүн боловсролын тогтолцоогоо эсэргүүцэж, тэмцэл өрнүүлж байсан бол 2000-аад онуудад Финланд улс PISA-д тогтмол дээгүүр байранд жагссаар байна.

Хувийн өмчийн ЕБС голдуу ажил олгогчдынхоо өмнө хариуцлага хүлээдэг бол төрийн өмчийн ЕБС болоод ер нь аливаа боловсролын үйл ажиллагаа эрхлэгч нь бүх нийтийн өмнө хариуцлага хүлээдэг.

Хувийн хэвшлийн ЕБС-ийн суралцагчид төрийн өмчийн ЕБС-ийн сурагчдаас илүү үр дүнтэй суралцдаг хэдий ч тухайн хувийн хэвшлийн ЕБС-ийн шууд нөлөө гэж үзэх хангалттай нотолгоогүй ажээ. Өөрөөр хэлбэл тухайн суралцагчийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг тооцоолж хийсэн судалгаа бараг байхгүй байна.

²² “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, *Хувийн сургуулиудыг төрөөс зохицуулах шаардлага*, 2018.

Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг хувийн сургуулиудын чанар, тэгш байдал, тогтвортой байдлыг сайжруулдаггүй нь харагдсан байна. Төрийн өмчийн ЕБС-тай зах зээлийн түвшинд өрсөлдсөнөөр боловсролын тогтолцооны хүрээнд чанарыг нийтэд нь дээшлүүлнэ гэсэн таамаглалыг баталсан нотолгоо сул байжээ (Department for International Development, 2014).²³

2000 оноос хойш сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарт төрийн бус өмчийн цэцэрлэг, сургууль болон түүнд хамрагдах сурагчдын тоо улам бүр өсөн нэмэгдсээр ирсэн, нэмэгдэх хандлага ч хэвээр байна. Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн тоог Улаанбаатар хотын хувьд дүүргээр ангилан харвал зарим нэг дүүрэгт хувийн сургууль төрийн өмчийн сургуулиас тооны хувьд олон байгаа нь сонирхол татна. 2016-2017 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн 500 цэцэрлэг¹⁴ ажиллаж байсныг 2018 онд 559 болгож, 133 сургууль ажиллаж байсныг 15,815 болгож тус тус нэмэгдүүлэхээр төсөөлсөн байна. Ийнхүү хувийн цэцэрлэг, сургуулиудын үүрэг оролцоо улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь төрийн зүгээс ачааллаа дийлэхгүй байгаа өнөөгийн нөхцөлд дэмжлэг болж буйг сайшаахын зэрэгцээ цаашид үүсч болзошгүй асуудлуудад олон улсын нэгэн адилаар анхаарал хандуулахын чухлыг тэмдэглэх нь зүйтэй.

Ялангуяа, ашгийн төлөө болон төлбөр төлдөг боловсролыг өргөжүүлэх нь төрөөс нийтлэг чанар, тэгш байдал, чанартай боловсрол олгоход бүрэн дүүрэн хангалттай байж чадахгүй байгаа төсвийн нэлээд хэсэг нь өөр тийш чиглэхээс гадна боловсролын тогтолцоонд гадуурхал, тэгш бус байдал улам нэмэгдэх магадлалтай. Уг нь төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулиудын хувьд өөрийн хүсэл зориг, сэдэл тэмүүлээр үүсгэн байгуулагдаж, эцэг эхчүүдийн сонголтод суурилсан төлбөрөөр санхүүжиж, дээрээс нь төрөөс үнэ төлбөргүй боловсрол олгох үүргийнхээ хүрээнд олгодог нэг сурагчид ногдох хувьсах зардал болон бусад дэмжлэг туслалцааг авч байгаа утгаараа ямар ч тохиолдолд тэгш хамран сургалт, тэгш боломжийг хангасан, чанартай боловсрол олгох учиртай! Гэтэл бодит байдалд ялгаварлах, гадуурхах хандлага болон сөрөг асуудлууд хувийн сургуулиудын түвшинд нэмэгдсээр байна.

ЦААШИД ЯАХ ЁСТОЙ ВЭ?

Төр:

- Олон улсын хүний эрхийн гэрээ, баримт бичгүүдээр хүлээсэн үүргүүдтэй нь зөрчилдөхгүй байх;
- Ялангуяа нийгмийн бүлгүүдийн хувьд боловсрол эзэмших боломж хэт ялгаатай болоход хүргэхгүй байх;
- Бүх нийтийн үнэ төлбөргүй, чанартай боловсрол олгох улс орны хүчин чадавхийг сулруулахгүй байх;

²³ Олон улсын хөгжлийн газар, Хөгжиж буй улсуудын хувийн сургуулийн үүрэг, нөлөө, 2014 оны 4 дүгээр сар. Дэлгэрэнгүйг: https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/439702/private-schools-full-report.pdf

- Зар сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагаагаар боловсролын тогтолцоог арилжааны хэлбэрт оруулахгүй байх явдлыг хангаж ажиллахын тулд юуны түрүүнд зохицуулалт бий болгох онцгой үүрэгтэй.²⁴

Улмаар, цуглуулсан мэдээлэлд хяналт шинжилгээ хийж, асуудалтай, дутагдалтай талуудыг илрүүлсний үндсэн дээр нийгмийн бүхий л талуудын оролцоог хангасан, ил тод үйл явцаар зөвшилцөж хэлэлцэж байж цаашид хэрэгжүүлэх бодлогын зорилтуудыг тодорхойлох ёстой. Ингэхдээ улс орнуудын туршлага, сургамж, сайн жишээнээс суралцаж өөрийн онцлог, нөхцөл байдалд тохируулан авч үзэх нь зүйтэй. Ихэвчлэн дэлхийн өмнөд бүс нутгийн бага болон дунд орлоготой орнуудын нөхцөл байдалд түлхүү суурилсан ч дэлхийн өнцөг булан бүрээс хуримтлагдсан туршлага, жишээн дээр тулгуурлаж боловсруулсан гарын авлагуудад²⁵ танилцуулсан нийтлэг зөвлөмжөөс энд хуваалцаж байна (Global Campaign for Education, 2017).

ЕРӨНХИЙ ЗОРИЛТ: ХУВИЙН СУРГУУЛИУДЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН МЕХАНИЗМ БИЙ БОЛГОХ

Дэд зорилт 1. Нийгмийн сайн сайхан, үндэсний эв эе, иргэн төлөвшүүлэх:

- Сургалтын хөтөлбөр, сурах бичиг болон сургалтын бусад материалууд, сургалтын үйл ажиллагаанд, сургалт явагдаж байгаа хэлэнд хяналт тавих;
- Хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх тодорхой стандарт болон хяналт тавих аргачлал, дүрэм журам гаргах.

Дэд зорилт 2. Сургуулийн чанарыг дээшлүүлэх, зах зээлийн алдаа гажгийг нөхөх, чанарыг баталгаажуулах наад захын стандартуудыг дараах чиглэлээр мөрдүүлэх:

- Багш нар: багш нарын мэргэжил, ур чадварын шаардлага, багш сурагчийн харьцаа, багшийн цалингийн шатлал, доод хэмжээг тогтоох, багшийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцлийг зохицуулах;
- Материаллаг дэд бүтэц: анги танхим, бусад өрөө танхим, орчин, хөгжлийн бэхшээлтэй хүүхдийн орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын гэх мэт шаардлага тавих;
- Сургалтын орчин ба хэрэглэгдэхүүн: сурах бичиг, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, номын сан гэх мэт;
- Үндэсний цөм хөтөлбөр, стандарттай нийцсэн сургуулийн сургалтын хөтөлбөр, үнэлгээний систем;
- Хүүхэд хамгаалал (бэлгийн дарамт, бие махбодын шийтгэлээс

24 Төрийн болон төрийн бус сургалтын байгууллагуудаар дамжуулан боловсролын үйлчилгээг хүргэхэд улс орнуудын баримтлах хүний эрхийн зарчмууд. Удирдамж баримт бичиг.

25 Дэлхий дахины Боловсролын төлөөх Олон улсын хөдөлгөөн (GCE), Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан гарын авлага. 2017.

урьдчилан сэргийлэх гэх мэт).

Дэд зорилт 3. Ил тод байдлыг дэмжих, сургуулиудын талаар мэдээлэл дутуу дулимаг байгааг нөхөх, хуурч мэхэлдэг сургуулиудыг илрүүлэн үйл ажиллагааг зогсоох:

- Төрийн яамны цахим хуудас зэрэг олон нийтийн мэдээллийн орон зайд сургуулиудын талаар нээлттэй, тогтмол хугацаанд шинэчлэгддэг мэдээллийг тавих (төсөв, төгсөлтийн хувь, олсон ашиг гэх мэт);
- Санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын механизм бий болгох, үр дүн, тайлангийн товъёог олон нийтийн орон зайд нээлттэй тавих;
- Хувийн сургуулиудыг хянах, зохицуулах, журамлах орон тоо, санхүүжилттэй механизм бий болгох;
- Хууль, дүрэм журмыг зөрчсөн сургуулиудад үе шаттай торгууль ногдуулах, эцсийн арга хэмжээ нь хаах хүртэлх тогтолцоог бий болгох, хаах тохиолдолд хүүхдүүдийг өөр сургуульд шилжүүлэх зэргээр завсрын арга хэмжээг авах;
- Хувийн сургуулиудад тавих олон нийтийн хяналтыг бэхжүүлэх, эцэг эхэд сургуулийн захиргаатай, өмчлөгч талтай хэлэлцээ хийх бүтэц бий болгох, сургууль дээр эцэг эх-багшийн холбоо байгуулахыг хуульчлах;
- Сурагч болон эцэг эхийн дуу хоолойг сонсох орон зайг бий болгохын тулд санал гомдол хүлээн авч шийдвэрлэх маш тодорхой тогтолцоог хуульчлах.

Дэд зорилт 4. Бүх хүүхдэд хүртээмжтэй байх боломжийг тэгшитгэх, боловсролын тэгш бус байдал, тусгаарлагдсан байдлыг арилгах:

- Сургалтын төлбөрт “тааз” тавих;
- Хувийн сургуулийн элсэлтийг зохицуулах тодорхой механизм байх, элсэлтийн далд төлбөрийг үгүй хийх, ил тод шалгаруулалт явуулах гэх мэт;
- Сургалтын төлбөрөө төлж чадахгүй эцэг эхчүүдийн хүүхдийг, ядуу айлын элсэн орсон хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх, эмзэг бүлгийн, ядуу айлын хүүхдүүдэд дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх тогтолцоотой байх;
- Хөрөнгө чинээтэй хэсэг хувийн сургуульд, ядуу айлын хүүхдүүд улсын сургуульд гэсэн тусгаарласан байдал бий болсон улс орнуудад хувийн сургуульд заавал элсүүлэх квот тогтоож өгсөн байдаг гэх мэт.

БОЛОВСРОЛ ДАХЬ ТӨРИЙН БУС ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ

Боловсрол гэх нийгмийн институци нь нарийн төвөгтэй асуудал бөгөөд төрийн гол үүргийн нэг нь боловсрол байдаг. Түүнчлэн боловсрол нь хүний эрх тул хүн бүрийн асуудал бөгөөд өөрөөр хэлбэл, төрийн бус оролцогчдын асуудал тул мөн тэдний үүрэг гэсэн үг. Энэ бүлгийг “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн Ерөнхий зохицуулагч Д.Тунгалагийн Боловсрол дахь төрийн бус оролцогч талуудын үүрэг: Онцлох асуудлууд үзүүлэнд үндэслэв.

Ашгийн төлөөх сургуулиудын сүлжээ нь сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх байдлыг гажуудуулах төдийгүй ардчилал, нийгмийн эв эе, хөгжиж буй орнуудын тогтвортой байдал зэрэгт хор хохирол учруулж байна (Human Rights Council, 2015).²⁶

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН БАЙР СУУРЬ:

- Европын парламент хувийн бөгөөд ашгийн төлөөх сургууль боловсролын байгууллагыг олон улсын хөгжлийн тусламжийн мөнгөнөөсөө санхүүжүүлэхгүй байх шийдвэр 2018 онд гаргасан;
- Боловсролын төлөөх дэлхийн хамгийн том сан (GPE) өөрсдийн санхүүжилтээ хувийн хэвшлийн боловсрол сургалтын байгууллагыг санхүүжүүлэхэд зориулахгүй байх шийдвэр 2019 онд гаргасан;
- Олон улсын санхүүгийн корпораци, Дэлхийн банк ашгийн төлөөх сургуулийн хамгийн том сүлжээнд хийж байсан хөрөнгө оруулалтаа 2022 онд зогсоох шийдвэр гаргасан;
- Улс орнууд тухайлбал, Япон болон Сингапур Улс Хувийн сургуулийн тусдаа хуультай бусдад хувийн сургуулиудын талаарх үлгэр жишээ болохуйц зохицуулалттай гэдгийг НҮБ-ын Сурч боловсрох эрхийн Тусгай илтгэгч 2015 оны Хүний эрхийн хороонд өгсөн тайландаа дурдсан.

Мэрилэндийн Их сургуулийн Олон улсын боловсролын бодлогын профессор, алдарт эрдэмтэн Стивен Ж.Клис 2022 онд ингэж хэлжээ:

*Миний хувьд боловсролыг хувийн хэвшил хувийн ашиг сонирхолд дөрлүүлэн ашиг олохоор менежмент хийж болохгүй, иргэд ардчилсан ёсоор засаглаж, төрийн үзүүлэх үйлчилгээ-нийтийн салбар байх ёстой гэдгийг түүхэн, эрх зүйн, хүний эрх, философийн, боловсролын аргууд дэмждэг.*²⁷

Төрийн бус байгууллагуудын талаарх Дэлхийн Боловсролын мониторингийн

²⁶ Human Rights Council, Report of the Special Rapporteur on the right to education, Kishore Singh: Protecting the right to education against commercialization, (A/HRC/29/30, para. 39) 2015.

²⁷ Steven J.Klees, Distinguished Scholar, Professor of International Education Policy at the University of Maryland, 2022

тайлан-д, ашиг хийх нь үнэ төлбөргүй ерөнхий боловсрол олгох үүрэгтэй нийцэхгүй, зохицуулах эсвэл хориглох хэрэгтэй гэжээ (Global Education Monitoring Report (GEMR), 2021/2). Иймд дараах зөвлөмжийг санал болгож байна.²⁸

- Хувийн сургуулиуд хүүхдийг шилж сонгож элсүүлэх ёсгүй;
- Төсвөөс санхүүжилт авдаг хувийн сургуулиуд төлбөр нэмж авах ёсгүй;
- Сургалтын төлбөр авдаг бол төлбөрийн тааз тавих, нэмэлт төлбөр хураамж авахыг хориглох ёстой.

Үүний зэрэгцээ Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл тойм судалгаанд тус санал, зөвлөмжийг илэрхийлснээр асуудлыг шийдэх шаардлагатайг харуулж байна:

- Төрөөс төрийн бус боловсролын талаар баримтлах бодлогыг батлах;
- Төрийн бус өмчийн сургуульд төрөөс санхүүжилт олгож байгаа зорилгыг бодлогын хувьд тодорхой болгох;
- Боловсролын тэгш бус байдлыг хангах зорилгоор хуулиар хүлээсэн үүргээ зөрчиж байгаа ямар ч сургалтын байгууллагад төрөөс санхүүжилт, дэмжлэг олгохгүй байх зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ тайланд, дараах хүчин зүйлс боловсролын салбарыг ахин **хямралд оруулах** боломжтой гэж дүгнэжээ.²⁹ Үүнд: хувийн өмчийн боловсролын үйлчилгээг ашгийн төлөө байхаар хуульчилсан ба бүх түвшний хувийн өмчийн боловсролын байгууллагад ямар нэгэн нэмэлт шаардлага тавиагүй байх явдал аж (ЮНЕСКО-ийн Боловсролын салбар, 2019). Өөрөөр хэлбэл, ашгийн төлөө боловсролыг зах зээлд даатган орхих нь нийгмийн доройтуулах явдал мөн.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

28 GEMR (Global Education Monitoring Report 2021/2022), Global Report: Opportunity Amid Disruption, London, 2022.

29 ЮНЕСКО-ийн Боловсролын салбар, Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ, 2019.

БОЛОВСРОЛД ӨРИЙН НӨЛӨӨ

Боловсролын салбарын хөгжил нь санхүүжилтээс ихэд хамааралтай байдаг онцлогтой. Энд гадаад, дотоодын өр болоод боловсролын салбарын санхүүжилтын талаар авч үзэх ба “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс гаргасан *Боловсролын салбарын төсөв санхүүжилтэд үзүүлэх Монгол Улсын нийт өрийн нөлөө* тайланд үндэслэсэн болно.³⁰

Монгол Улс гурван гол асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Энэ нь:

1. Дампуурлаа зарлахаас зайлсхийх;
2. Өрийн үйлчилгээний төлбөр нэмэгдэхэд боловсролын салбарын санхүүжилтийг бууруулахгүй байх;
3. Ковид 19 цар тахлын дараах сурлагын хоцрогдол, сургуулиар дамжуулан өгдөг хоол тэжээлийн хөтөлбөрүүд, вакцинжуулалт, хүүхэд хамгааллын бусад үйлчилгээг сайжруулах зэрэг юм.

Монгол Улсын хувьд засгийн газрын гадаад зээлийн дийлэнх хэсэг нь өмнөх өрийг барагдуулах, нийгмийн халамжийн зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдаж байгаа бөгөөд хувийн хэвшлийн гадаад өрийн хувьд уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт болон орж байна.

Хөгжиж буй эдийн засагт гадаад өр нэмэгдэх боломжтой юм. Гэсэн хэдий ч 2016 оноос хойших эдийн засгийн өсөлт (дунджаар 2.4 хувь) сүүлийн дөрвөн жил дэх гадаад өрийн өсөлтөөс (7.5 хувь) харьцангуй бага байгаа нь өр нэмэгдэх үндэс болсон байна. Түүнчлэн Монгол Улс гадаадаас зээл авсан хэвээр. Засгийн газрын болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн нийт өр 1997 онд Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ)-ий 50 хувьд хүрэхгүй байсан бол 2019 онд 253 хувьд хүрч, Монгол Улс өрийн өндөр дарамттай орон болон хувирчээ.

Нэг хүнд ногдох ДНБ-ий хувь болон Хүний хөгжлийн индексийн хувьд ижил төстэй орнуудтай Монгол Улсыг харьцуулж үзэхэд боловсролын салбарын санхүүжилт тэдний олонхоос бага, дэлхийн дунджаас доогуур, цаашлаад бага-дунд орлоготой орнуудтай ижил түвшинд буюу ДНБ-ий 4.3 хувийг зарцуулдаг байна.

Эрс тэс цаг уур бүхий өргөн уудам газар нутагт тархан суурьшсан хүн амд боловсролын үйлчилгээг хүргэхэд зардал өндөр гардаг тул сургалтын үйл явцад шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, сургалтын тоног төхөөрөмжөөр хангах, номын сан, лабораторийг тогтвортой ажиллуулах, боловсрол нөхөн олгох ажлыг зохион байгуулахад энэхүү санхүүжилт хүрэлцдэггүй байна.

Боловсролын салбарын санхүүжилт нь үр дүнгийн хувьд алаг цоог. Сургуулийн өмнөх боловсрол, бага ба дунд боловсролын цэвэр хамран

³⁰ “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Боловсролын салбарын төсөв санхүүжилтэд үзүүлэх Монгол Улсын нийт өрийн нөлөө, 2021.

сургалтын хувь хэмжээ хэдий өндөр ч зарим ялгаатай бүлгүүдэд хүрч чадахгүй байгаа нь боловсролын чанар болон хүртээмжийн хувьд сорилт авчирч байна. Сургууль завсардалтын хувь тэр дундаа алслагдмал орон нутагт буурахгүй байгаа нь сургууль, дотуур байрны хүртээмж муу байгаатай холбоотой. Хөдөө орон нутгийн хүн ам, ялангуяа малчин айл өрхүүдийн хувьд үр хүүхдээ сургуульд суралцуулна гэдэг хүндрэлтэй асуудал болон хувирчээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуус, малчдын болон үндэстний цөөнхийн хүүхдүүдийн сургуульд хамрагдалт, бичиг үсэгт тайлагдсан түвшин жил ирэх тусам буурч байна. Иймд боловсролын салбарын санхүүжилт одоо байгаа түвшнээс буурвал бидний өнөөгийн байдлаар хүрсэн бүх амжилт буурч, ядуурал нэмэгдэн, тэгш бус байдал улам гүнзгийрэх үндэс болно.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БА ГАДААД ӨР

Монгол Улсын эдийн засгийн үндсэн салбар нь уул уурхай бөгөөд төсвийн орлогын 25 хувийг бүрдүүлж, нийт экспортын 90 хувийг эзэлдэг. 2020 онд Монгол Улсын Төв Банкны мэдээлснээр нийт гадаад өрийн хэмжээ 31.2 тэрбум ам.долларт хүрсний 25.8 хувь нь Засгийн газрын, 6.9 хувь нь Төв Банкны, 67.2 хувь нь хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн өр байна. Гадаад өрийн хэмжээ аажим нэмэгдсээр 2012 оноос хойш эрс өссөн байна.³¹

Монгол Улсын Засгийн газар 2012 онд анх удаа 1.5 тэрбум ам.долларын бондыг олон улсын зах зээлд гаргаснаар өрийн дарамт нэмэгдэж, дараагийн жилүүдэд нь эдийн засаг уналтад орсон билээ.³² Хувийн хэвшлийн гадаад өр томоохон хэсэг Оюу Толгой ХХК-ийн хөрөнгө оруулагчид хамаарна. Гадаад өрийн өсөлтөөсөө удаан эдийн засгийн өсөлттэй байгаа нь манай улсын өрийг нэмэгдүүлэхэд хүргэж байна.

Монгол Улсын гадаад өрийн өсөлтөд нөлөөлж буй хэд хэдэн шалтгаан байна. Үүнд:

- i. Хуримтлалын хувь бага, хөрөнгө оруулалтын хувь өндөр байгаа нь урсгал дансны ихээхэн алдагдалд хүргэж, улмаар үүнийг гадаад өрөөр санхүүжүүлж байгаа явдал;
- ii. Төсвийн тухай хүчин төгөлдөр хуулиудын хэрэгжилтийг хангах институцуудын чадамжгүй байдал;
- iii. Төсвийн орлогын бодит бус төсөөлөл нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлдэг байдал;
- iv. Эрдэс баялгийн салбарын гэнэтийн өсөлтийг дагасан хувийн хэвшил дэх гадаад зээлээр санхүүжүүлсэн гадаадын хөрөнгө оруулалт зэрэг юм.

31 Монгол Банк, Монгол Улсын нийт гадаад өрийн статистик

Дэлгэрэнгүй үзэх холбоос: https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=4_3

32 Монгол Улс 10 жилийн хугацаатай 1 тэрбум ам.долларын, 5 жилийн хугацаатай 500 сая ам.долларын бонд гаргасан.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын нийт гадаад өрийн дийлэнх хэсэг нь хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдийнх бөгөөд 2/3 нь Оюу Толгой ХХК болон арилжааны банкуудын, 1/3 нь Засгийн газар болон Төв банкны урт хугацааны бондын өр байна.

2014 онд Улсын Их Хурлаас Өрийн удирдлагын тухай хуулийг баталж, Засгийн газрын өр ДНБ-ий 55 хувиас хэтрэхгүй байхаар хуульчилсан байдаг. Гэвч Монгол Улсын ДНБ-тэй харьцах нийт гадаад өрийн харьцаа 253 хувьд хүрээд байна. Монгол Улсын төр, хувийн хэвшлийн нийт гадаад өрийн хэмжээ 1997 онд ДНБ-ий 50 хувиас бага байсан бол 2019 оны байдлаар 253 хувь хүрч, өрийн өндөр дарамт бүхий орон болжээ.

2021 оны байдлаар боловсролын салбарын төсвийн зарлага 1.375 их наяд төгрөг байсан бол гадаад өрийн үйлчилгээний төлбөр 1.33 их наяд төгрөг байв. НҮБ-ын Хүүхдийн сангийн тайланд, 2020 онд Монгол Улсын гадаад өрийн үйлчилгээний төлбөр нийгмийн салбарын зардлаас 1.24 дахин их байв хэмээн мэдээлжээ.

Монгол Улс гадаад өрөө эрүүл мэнд, боловсрол зэрэг хүмүүн капиталыг нэмэгдүүлэх чиглэлээр зарцуулж байгаа гэж үзвэл энэ нь эргээд эдийн засгийн бүтээмжийг дээшлүүлж, зээлийн эргэн төлөлтийг ч сайжруулах боломжтой юм. Гэвч гадаад өрийн дийлэнх нь экспортод чиглэсэн дотоодын бизнес, дэд бүтцийн салбарт хөнгөлттэй зээл хэлбэрээр очиж, үлдсэн хэсэг нь “Хүүхдийн мөнгө” хөтөлбөр гэх мэт нийгмийн халамж, тусламжид зарцуулагдаж байна. Тиймээс өсөн нэмэгдэж буй гадаад өр боловсролын салбарын санхүүжилтэд сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй юм. Эрсдэлийг хаах ямар нэг хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй бол гадаад өрийн өсөлт нь сургуулийн насны сурагчдын тоо өсөж буй тус улсад сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын хүртээмж, чанарыг улам дордуулах болно.

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН САНХҮҮЖИЛТ

Монгол Улсын хүн амыг авч үзвэл, 2019 оны байдлаар нийт хүн амын 68 хувь нь хот суурин газар, 32 хувь нь алслагдмал хөдөө орон нутагт амьдарч байв. Хүн амын өсөлтийн түвшин 2.2 бөгөөд нийт хүн амд 15 хүртэлх насны иргэдийн эзлэх хувь 31.5 хувь болон өсчээ. Ийнхүү хүн ам өсөхийн хэрээр боловсролын систем ч өргөжин тэлэх шаардлагатай болж байна.

Сургуулийн өмнөх, бүрэн дунд боловсрол, техник мэргэжлийн боловсрол, сургалт болон дээд зарим их сургууль улсын төсвөөс санхүүждэг. Монгол Улсын хувьд цаг уурын нөхцөл байдал илүү онцлог буюу хүн ам таруу суурьшсан, хүн амын 28 хувийг малчин өрхүүд эзэлдэг зэргээс үүдэн боловсролын үйлчилгээг хүргэх өртөг өндөр байсаар иржээ. Боловсролын үйлчилгээний өртөг өндөр байгаа нь:

- i. Алслагдсан хөдөө орон нутагт тархан суурьшсан хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг хүргэх;
- ii. Малчдын хүүхдүүдийг сургуулийн дотуур байраар хангах;

- iii. Тэсгэм хүйтэн өвлийн урт саруудад цэцэрлэг, сургууль, сургуулийн дотуур байруудыг халаалтаар тогтмол хангах;
- iv. Цэцэрлэг, сургууль, дотуур байруудын тогтвортой үйл ажиллагааг хангах үүднээс багш бус олон тооны ажиллагсдыг авч ажиллуулах шаардлагатай байдаг зэрэг шалтгаантай юм.

КОВИД-19 цар тахлын үед 2021 онд улсын төсвийн орлого буурсан хэдий ч боловсролын салбарын төсвийн хэмжээ 15.7 хувь болон нэмэгдэж, боловсролын салбарын зардал ДНБ-ий 6.6 хувьд хүрсэн байна. Ингэснээр боловсролын салбарын санхүүжилт наад зах нь ДНБ-ий 4-6 хувь, улсын төсвийн 15-20 хувь байх шаардлагатай хэмээн заасан Боловсролын салбарын 2030 он хүртэл баримтлах үйл ажиллагааны хүрээний түвшинд байна гэсэн үг юм.³³

Боловсролын салбарын санхүүжилт 2012-2019 оны хооронд нэрлэсэн дүнгээрээ дунджаар 14.3 хувиар өссөн. Тус салбарын санхүүжилт бодит утгаараа ч өсөлттэй байна. Гадаад өрийн өсөлтийг үл харгалзан боловсролын салбарын санхүүжилт тогтвортой байна.

Зардлын бүтцийг харвал багшийн цалин, халаалт зэрэг хувьсах зардлууд боловсролын нийт төсвийн 80-85 хувийг эзэлдэг. Иймд боловсролын чанарт нөлөөлдөг сургалтын хэрэглэгдхүүн материал, ном, номын сан, сургалтын тоног төхөөрөмж, дэд бүтэц зэрэгт өчүүхэн хэмжээний төсөв зарцуулагдах болдог ажээ.

Боловсролын байгууллагын шатлал тус бүрээр зардлын задаргаа хийж үзвэл, нийт төсвийн 23 хувь нь сургуулийн өмнөх боловсрол, 46 хувь нь ерөнхий боловсрол, 9 хувь нь дээд боловсрол, 4 хувь нь техник, мэргэжлийн боловсрол сургалт, 18 хувь нь боловсролын салбарын удирдлага, зохион байгуулалтын зардалд зориулагдаж байна.

Тогтвортой хөгжлийн зорилгуудын 4 дэх зорилгод “Хүн бүрд чанартай боловсролыг эрх тэгш, тэгш хамруулан хүргэх, насан туршдаа сурч боловсрох боломжийг бүрдүүлнэ” хэмээн заасан байдаг. Өнөөгийн бидэнд буй тоо, мэдээллээр энэхүү зорилго биелэгдэхэд тун ойрхон байгаа дүр зураг харагдаж байна. Жишээлбэл, есөн жилийн заавал олгох суурь боловсрол үндсэндээ бүх нийтийг хамарч чадаж байна. Гэсэн хэдий ч Монгол Улс чанартай боловсролын үйлчилгээг эрх тэгш хүргэж чадахгүй байна.

Цаашилбал, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж хот суурин газар болон хөдөө орон нутагт харилцан адилгүй байдаг. Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн сургуулиудын боловсролын үйлчилгээний чанар зөрүүтэй. Малчдын хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхдүүд, өсвөр насны охид, өсвөр насандаа хүүхэд төрүүлсэн охидын боловсролын чанар дулимаг, хүртээмж хязгаарлагдмал байгаа нь ирээдүйд бидэнд томоохон сорилт бэрхшээлийг авчрахаар байна.

³³ Боловсролын салбарын 2030 он хүртэл баримтлах үйл ажиллагааны санхүүгийн үзүүлэн. Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://www.education-progress.org/en/articles/finance>

САНХҮҮЖИЛТЭД ГАДААД ӨР ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?

Гадаад өрийн үлдэгдэл, гадаад өрийн үйлчилгээний төлбөр нь боловсролын салбарын санхүүжилтэд гойд нөлөө үзүүлдэггүй, харин бодит ДНБ болон валютын ханш тухайн улсын боловсролын салбарын санхүүжилтэд онцгойлон нөлөөлдөг (Икэйттэ, Ован болон Агбо, 2019). Гадаад өр нь эдийн засгийг агшааж, үнийн түвшинг нэмэгдүүлснээр боловсролын салбарын санхүүжилтэд сөргөөр нөлөөлдөг хэмээн дүгнэж болно.

Гадаад өрийн үзүүлэх нөлөөллийн тухай өөр нэгэн чиглэлээр хийсэн судалгааны ажлуудад гадаад өр санхүүгийн сахилга батыг сулруулдаг гэж үздэг бөгөөд үүнийг “алдагдлын гажуудал” хэмээн нэрийддэг. Учир нь шийдвэр гаргах ардчилсан үйл явц нь оновчтой сангийн бодлогоос хазайх хандлагатай байдаг. Иргэд бага татвар төлөх, их зарцуулалттай байх гэх мэт богино хугацааны тааламжтай байдалд илүүтэй анхаарч сангийн тэлэх бодлогын улсын төсөвт үзүүлэх урт хугацааны сөрөг нөлөөг хэрэгсдэггүй байх тохиолдолд сангийн бодлого үр нөлөөгүй болдог. Энэхүү гажуудал Монгол Улсын хувьд ч мөн ажиглагдаж байна.

Гадаад өрийн өсөлтийн сөрөг үр дагавар нь өрийн үйлчилгээ, эргэн төлөлт зэргийг гадаад валютаар хийдэг учраас үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш аажмаар унахад хүргэдэг. 2012 оны түвшинтэй харьцуулахад 2020 онд монгол төгрөгийн ам.доллартай харьцах ханш 116 хувиар суларсан.³⁴ Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш сулрах нь өрийн үйлчилгээний зардлыг улам нэмэгдүүлдэг.

КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй урт хугацааны хөл хорио нь бидэнд зайны сургалт бол ирээдүйд сургалтын үйл ажиллагааны зайлшгүй нэг хэсэг болно гэдгийг тодорхой болгож өгсөн билээ. Тиймээс цахим холболт, сургалтын технологи, багш нарын цахим хэрэгсэл ашиглах ур чадвар зэрэг маш олон зүйлсийг сайжруулахад улсын төсвийн хөрөнгө оруулалт шаардлагатай. Ирээдүйн өрийг өнөөдрийн хүүхдүүд төлөх учир төр тэдний боловсролд хөрөнгө оруулах нь шударга хэрэг билээ.

КОВИД-19 цар тахалтай холбоотой өр хөнгөвчлөх арга хэмжээнүүдийн нэг нь хугацаат өрийн эргэн төлөгдөх хугацааг сунгах арга хэмжээ юм. Монгол Улсын хувьд Өрийн үйлчилгээг түр зогсоох санаачилга, Гамшгийн нөлөөг бууруулах, дэмжлэг үзүүлэх сан, өрийн өндөр дарамттай буурай орнууд (ӨӨДБО)-д зориулсан санаачилгууд зэрэг өр царцаах зорилготой хөтөлбөрүүдэд оролцохоор хүсэлт гаргах хэрэгтэй. Өрийн хэмжээг бууруулах, тогтвортой байдлыг хангах зорилгоор 2021 онд Дэлхийн Банкаас өгсөн дараах зөвлөмжийг дагах шаардлагатай юм. Энэхүү зөвлөмжид дараах зорилго бүхий өрийн бодлого хэрэгжүүлэхийг зөвлөсөн. Үүнд:

- i. Өрийн хугацаа сунгах, солилцох, хүү тооцох эрсдэлийн параметруудийг тодорхой болгох;
- ii. Тус бодлогыг хэрэгжүүлэх харьцангуй бие даасан, хараат бүс төрийн

³⁴ 2020 онд 1 ам.долларын нэрлэсэн ханш 2,850 төгрөг байсан бол 2012 оны дөрөвдүгээр сард 1 ам.доллар 1,317 төгрөг байв.

сан/өрийн газрыг бий болгох;

- iii. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүдийн мэдээллийг ил тод болгох арга хэмжээг нэрлэсэн байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Өрийн дарамт нэмэгдэж байгаа ч Монгол Улсын Засгийн Газарт боловсролын салбарыг санхүүжүүлэх, хөрөнгө босгох хэд хэдэн суваг байна. Үүнд:

1. Монгол Улс Дэлхийн банкны өр бууруулах, өрийн тогтвортой байдлыг хангах зөвлөмжийг дагах, ялангуяа энэхүү зөвлөмжид багтсан өрийн удирдлагатай холбоотой бодлогыг хэрэгжүүлэх зорилго бүхий бие даасан төрийн сан/өрийн газрыг байгуулах;
2. Хүчин төгөлдөр төсвийн хуулийг ягштал баримтлан хэрэгжүүлэх, ялангуяа ул суурьтай судалгаа шинжилгээнд суурилж төсвийг төлөвлөх, ялангуяа төсвийн орлогыг бодитой төлөвлөх;
3. Өрийн дарамтыг хөнгөвчлөх зорилгоор Гамшгийн нөлөөг бууруулах, дэмжлэг үзүүлэх сан, өрийн өндөр дарамттай буурай орнуудын болон Олон талт өр барагдуулахад туслалцаа үзүүлэх зэрэг санаачилгуудад элсэн орох;
4. БНХАУ-ын Засгийн газартай хэлэлцээрт орж, уур амьсгалын өөрчлөлтөд зориулсан өр солилцох сүүлийн үеийн механизмыг хэрэглэх;
5. Татвар нэмэгдүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн төвөгтэй системийг алга болгох;
6. Хүүхэд харах үйлчилгээ үзүүлж буй хувийн хэвшлийн аж ахуй нэгж, хувь хүнийг санхүүгээр дэмжих, ялангуяа хөдөө орон нутагт дунд хэмжээний компаниудад зайлшгүй хүүхэд харах төвтэй байхыг журамлах;
7. Олон улсын донор байгууллагуудтай үр ашигтай хамтран ажиллах, НҮБын Хүүхдийн Сангийн зөвлөмжийн дагуу өрийн зарцуулалтыг ил тод, хяналттай болгох;
8. Төрийн худалдан авах ажиллагаан дахь авилгатай үргэлжлүүлэн үр дүнтэйгээр тэмцэх, төрийн өмчийн уул уурхайн компаниудыг илүү үр ашигтай, хариуцлагатай ажиллуулж төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг тус тус нэрлэж болно.

Эдгээр арга хэмжээг тууштай, зохион байгуулалттай, ил тод байдлаар авч хэрэгжүүлснээр Засгийн газар өрийг хүүхдийн хөгжлийн хөрөнгө оруулалт болгон хувиргах тогтвортой нөхцөлийг бий болгож болно (“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2021).

АШГИЙН ТӨЛӨӨХ ЗААЛТ НЬ АЛБАН БОЛОВСРОЛТОЙ НИЙЦЭХГҮЙ

Дэлхийн Боловсролын мониторингийн тайлан дахь боловсролын төрийн бус оролцогчдын талаарх зөвлөмжийг бага, дунд боловсролд ашиг олох нь 12 жил үнэ төлбөргүй боловсрол олгох төрийн үүргийн биелэлттэй зөрчилддөг гэсэн байр суурьтай нийцэхгүй байна (Global Education Monitoring Report (GEMR), 2021/2). Тус тайлан нь боловсрол дахь ашгийн төлөөх зорилгод эргэлзэж буй анхны тохиолдол биш юм. Энэ тал дээр маш олон улсууд эсрэг байр суурьтай байдаг. Манай үндэсний журмын дүн шинжилгээний PEER³⁵ сайтад 21 улс сүүлийн 10 жилд ашиг олох тухай журмыг танилцуулсан. Одоогийн тооцоогоор улсуудын 27 хувь нь бага, дунд боловсрол ашгийн төлөө байхыг хориглосон. Энэхүү журам сурагчид болон татвар төлөгчдийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх ашгийг нэмэгдүүлэхээс хамгаалах зорилготой.

Төрийн бус нийлүүлэгчид ашгийг нэмэгдүүлэхийг зорьдог. Боловсролын ашгийг тодорхойлоход хэцүү байдаг. Хувийн сургуулиудын үүсгэн байгуулагч нар өөрсдийнхөө цалингаас ялгаж салгах аргагүй ашиг олж, бизнесээ байгуулснаар ямар эрсдэл хүлээж байгаа, байраа сургууль болгосныхоо төлөө хүлээж буй төлбөрөөс нь ялгаж салгах аргагүй ашиг олж байна. Ялгаа нь мөн бүрхэг байх магадлалтай.

Боловсрол ба ашиг хоорондын зохицлыг улс орнууд хэрхэн авч үзсэнийг дараах зарим жишээнээс харж болно:

Улс	Боловсрол ба ашиг
Их Британи	Сургуулиуд бие даасан байдлыг нэмэгдүүлэх, буяны үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг багасгах зорилгоор “ашгийн төлөө” гэж ангилдаг. Ялангуяа дээд боловсролын хувьд ялгаа ихтэй.
Малайз	Ашгийн төлөө бус байгууллагын эзэмшдэг ашгийн төлөөх компани хоёр байгууллагыг эзэмшдэг. Гэхдээ олон нийтэд арилжаалагддаг болон хувийн өмчит компаниудын тэдний сурагчдад биш хувьцаа эзэмшигчдэд илүү үнэнч шударга байдаг нь санаа зовнилыг нэмэгдүүлэх болсон.
Ирланд	Бага насны хүүхдийн боловсролд ашиг нь боловсролын хөгжилд дахин хөрөнгө оруулж байгаа тохиолдолд ашгийн төлөөх заалтыг зөвшөөрдөг.
Грек	Бага насны хүүхдийн боловсролд чиглэсэн хувийн байгууллагууд ашгийн болон ашгийн бус зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг ч засгийн газар ашгийн бус төвүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

35 Profiles Enhancing Education Reviews (PEER), Тогтвортой Хөгжлийн 4 дэх Зорилгод улс орнуудын мэдээлэл.

Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://education-profiles.org/>

Норвеги	Хүлцэх боломжтой ашигтай хувийн цэцэрлэгүүдийг хүлээн зөвшөөрдөг “Цэцэрлэгийн журам” байдаг ч энэхүү ашиг хүүхдийн сайн сайхны төлөө Засгийн Газрын зорилго, нөхцөлтэй нийцэх ёстой.
Өмнөд Африк	Ашгийн төлөөх заалтыг 2015 онд Бага насны хүүхдийн боловсролын талаарх үндэсний нэгдсэн бодлогод зөвшөөрдөг боловч Төртэй гэрээлэн эмзэг бүлгийнхнийг үйлчилгээгээр хангасан тохиолдолд л Засгийн Газрын дэмжлэгийг авдаг.
Чили	2013 онд тус улсад боловсролд дахин хөрөнгө оруулахын оронд бага, дунд боловсролын салбарт 500 сая ам.долларын төсвийн санхүүжилтийг ашгийн төлөөх Засгийн Газраас хамааралтай хувийн сургуулиудын эзэд хадгалсан байсан. Бүх ашгийн төлөө сургуулиудыг ашгийн төлөө бус статус руу орохыг шаардаж хууль өөрчлөгдсөн. 2018 онд хувийн сургуулиудын 97 хувь нь ашгийн төлөөх бус статус руу шилжсэн.
Хятад	2021 онд албан боловсролын сургуулийн хөтөлбөрийг заадаг пүүсүүдийг капитал босгох, ашиг олохыг хориглосон хууль баталсан. Компаниуд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд ашгийн төлөө бус болох шаардлагатай.

Санхүүжүүлэгчид энэ асуудалд хатуу бодлого боловсруулж эхэлсэн. 12 тэрбум долларын боловсролын багцаас олон улсын санхүүгийн корпораци хувийн сургуулийн сүлжээнүүдийн 15 хувийг байршуулдаг ч иргэний нийгмийн байгууллагын шахалт ёсоор 2019 онд хувийн сургуулиудын төлбөр төлөлтийн хөрөнгө оруулалтуудыг хөлдөөсөн. Боловсролын төлөөх Дэлхийн Түншлэлийн сангаас боловсролын цөм үйлчилгээг ашгийн төлөө байх заалтыг хориглосон. Мөн 2018 онд Европын Парламентын тогтоолоор Европын холбоо олон улсын арилжааны үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулж ашгийн төлөөх боловсролыг санхүүжүүлэхгүй байхаар болсон. Тогтоолд цөм боловсролын ач холбогдлыг цохон тэмдэглэж сургуулийн хангамж, хоол хүнс, тээвэр гэх мэт элементүүд үнэгүй байх ёстой гэж орсон.

Ашгийн төлөөх их сургуулиуд маргаантай

Албан журмын боловсролд ашиг олох тухай санаа зовоосон асуудлуудын ихэнх нь ашгийн төлөө дээд боловсролын үйл ажиллагаатай орнуудын туршлагаас үүдэлтэй. Бразилд ашгийн төлөөх институциудын тал нь дээд боловсролын байгууллага байдаг. Олонх нь олон улсын хамгийн том 10 компанийн ашгийн төлөөх институцийн 60 гаруй хувь дээд боловсролд элсэгчдийн 30 хувиас бүрддэг. Өрсөлдөөний зохицуулалтын газар хоёр дахь том компанийг хамгийн том компани худалдаж авахыг хориглосон бөгөөд энэ нь зах зээлийн төвлөрлийг 30 хувиас дээш нэмэгдүүлэх болно.

АНУ-д ашгийн төлөөх байгууллагууд дээд боловсролын оюутнуудын 5 орчим хувийг эзэлдэг ч өндөр татаастай байдаг; орлогынх нь 90 орчим хувийг холбооны буцалтгүй тусламж, холбооны баталгаатай зээлээс бүрдүүлдэг. Гэсэн хэдий ч ашгийг нэмэгдүүлэх урамшуулал нэмэгдэхийн хэрээр оюутны үр дүн муудаж байгааг олж мэдсэн. Тухайлбал, хувийн өмчит пүүс ашгийн

төлөө байгууллагыг худалдаж авснаар хөрөнгө оруулагчид өндөр өгөөжийг бий болгохын тулд цөм үйлчилгээнээс нэг оюутанд ногдох багшийн тоо, түүнд зарцуулах зардлын эзлэх хувь буурснаар төгсөлтийн хувь хэмжээ, зээлийн эргэн төлөлт, хөдөлмөрийн зах зээлийн орлого буурахад хүргэсэн. Мөн ашгийн төлөөх байгууллагууд хулгайн аргаар ажилд авах, худал хуурмаг маркетингийн стратеги зэрэг бизнесийн заль мэх хийдэг нь тогтоогдсон: Ашгийн төлөөх 10 том компанийн 7-г нь шалгаж, ийм үйлдлийг өөгшүүлсэн нь тогтоогдсон.

Олон нийтэд таваар зарж буй мэт арилждаг дээд боловсролын конгломератууд³⁶ хүчтэй лобби хийх эрх мэдэлтэй байдаг. Улс төрчид ашгийн төлөөх дээд боловсролын компаниудаас өгөөмөр хандив авч хууль, тогмоомжид зохисгүй заалтуудыг оруулж ирдэг. Канадын их сургуулийн багш нарын холбоо ашгийн төлөө корпорацийн салбарийн удирдах зөвлөлийн гишүүдийн өсөн нэмэгдэж буй оршихуйн үр дүнд их дээд сургуулиуд корпорацийн менежмент рүү шилжиж буй санаа зовниж буйгаа илэрхийлсэн.

Дундаж орлоготой орнуудын чанарын баталгаажуулалтын механизм нь ихэвчлэн маргинал бүлгийн хүмүүсийг элсүүлдэг хуурамч, бүртгэлгүй ашгийн төлөөх институцэд төвлөрдөг. Пакистаны дээд боловсролын комисс 2017 онд 153 хууль бус сургууль, зэрэг олгод институцуудын жагсаалтыг олны анхааралд оруулсан. Өмнөд Африкт хуурамч, бүртгэлгүй байгууллагуудын тоо нь засгийн газрыг 2019 онд Үндэсний мэргэшлийн хүрээний нэмэлт өөрчлөлтийн тухай хуулиар залилан мэхлэх, мэргэшсэн байх нь гэмт хэрэг болсныг сурталчилж олон нийтийн дунд компанит ажил өрнүүлэхэд хүргэсэн. Вьетнамд хэд хэдэн их сургуулийн албан тушаалтнууд диплом зарах, хэд хэдэн төрийн авлига болон буруу үйл ажиллагаа явуулсан гэж яллагдаж байна.

Зарчмын асуудал уу эсвэл баримтын асуудал уу?

Хувийн сургууль тэр дундаа боловсролоос ашиг олж байгаа нь гурван гол аргументын маргаан болж байна.

Юун түрүүнд, боловсрол зөвхөн нийтийн сайн сайхны төлөө бус, энэ нь цэвэр хувийн сайн шинж чанартай. Ашгийн төлөөх сургуулиуд чанартай боловсрол, үйлчилгээний шаардлагад нийцүүлэн хүүхэддээ давуу байдал олгохын тулд боловсролд илүү мөнгө зарцуулах чадамж болон хүсэлтэй баян хөрөнгөтэй гэр бүлдүүдэд үйлчилж, чадамжгүй хэсгийг үлдээж, тэгш бус байдлыг хурдасгаж байна.

Хоёрдугаарт, инноваци ашиг олох нь шударга шан харамж юм шиг харагдаж байгаа байх. Гэхдээ инноваци гэж танилцуулсан зүйл нь маркетингийн зорилгоор шалгахад хэцүү бөгөөд магадгүй хэтрүүлсэн байж магадгүй юм. Мөн боловсрол бол үйлдвэрлэгчид бие биенийхээ дээр гарах гэж өрсөлддөг зах зээл биш. Харин шинэ санаа тестлэгдээд батлагдвал бүх сургуулиудад засгийн газрын дэмжлэгийг авах хэрэгтэй. Энэ нь арилжааны

36 А.Х: Conglomerate бол нэг корпорацийн бүлэглэлд хамаарах олон салбартай компани. Конгломератууд нь ихэвчлэн томоохон компани болоод үндэстэн дамнасан байдаг.

нууц байх ёсгүй.

Гуравдугаарт, зарим нь дараах асуултыг гаргаж ирдэг: засгийн газартай гэрээлэн юу хүссэнийг нь хийж байгаа үед хувийн сургуулиуд яагаад ашиг олж болохгүй гэж, өөрөөр хэлбэл, нийтийн сургуулиас илүү үр дүнтэй боловсролын үйлчилгээг үнэгүй үзүүлж байгаа. Энэ нь эргээд өөр асуултыг бий болгодог, энэ үр дүн хаанаас бий болж байгаа вэ? Боловсролын салбарын хамгийн том зардал бол багш нарын цалин. Улс багшид хэт их төлөөд байгаа юм бол энэ нь шийдэх ёстой бодлого байх ёстойгоос биш хангамжийн загварыг өөрчлөх шалтгаан болох ёсгүй. Улсын биш сургуулиуд залуу, туршлагагүй багш нарыг ажиллуулж үнэ-үр ашгаа нэмэгдүүлэх боломжтой гэхдээ энэ тогтвортой шийдэл болж чадахгүй. Ашгийн төлөө үйлчилгээ үзүүлэгчид нь үр дүн нь хэмжигддэг, санхүүжилт нь хамаардаг хичээлүүдэд анхаарлаа төвлөрүүлэх эсвэл ашгийн төлөө дээд боловсролд ажиглагддаг шиг практикт оролцох уруу татагдаж болно. Мөн нийтийн сургуулиуд хүн амд сурахад илүү үнэтэй байх дутагдалтай талыг бий болгох хандлагатай.

Албан боловсрол ашгийн төлөө бус байх ёстой гэсэн байр суурь бодит байдлын хувьд зарчмын асуудал болж байна.

БОЛОВСРОЛЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ: ИРГЭНИЙ НИЙГМИЙН САНАЛ

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс боловсруулсан боловсролыг үзэх хандлага хийгээд саналыг дараах байдлаар тоочжээ:

БОЛОВСРОЛЫГ ҮЗЭХ ХҮМҮҮНЛЭГ ХАНДЛАГА (Humanistic approach)

- Боловсролыг бүх нийтийн баялаг гэж үзэх, боломжийг тэгш хуваарилж нийгмийн тэгш бус байдлыг арилгах үүрэгтэй тул төр хүн бүрийн сурч боловсрох эрхийг хангах, нийгмийн шударга ёс, боловсрол дахь нийтийн ашиг сонирхлыг сахин хамгаалах үүргээ биелүүлэх ёстой;
- Хүний эрхэм чанар, авьяас чадвар, амьдралын сайн сайхан бүхнийг хадгалан бэхжүүлэх зорилготой гэж үзэх;
- Боловсролын гүйцэтгэх үүргийг хүн утга учир дүүрэн, нэр төртэй амьдрахад шаардлагатай ур чадвар бүрдүүлэх гэж үзэх (эдийн засгийн хөгжлийн хэрэгсэл гэж явцуу үзэхгүй байх);
- Хүний амьдрал ба нэр төрийг хүндлэх, тэгш эрх ба нийгмийн шударга ёс, соёлын болон нийгмийн олон янзат байдал, хүн төрөлхтний эв санааны нэгдэл, нийтлэг ирээдүйн төлөөх хамтын хариуцлага зэрэг хүмүүнлэг үнэт чанарууд боловсролын зорилго, түүний үндэс суурь нь болох ёстой;
- Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх (Хүний эрхийн түгээмэл тунхаглал), өөрийн нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын хөгжлийн төлөө суралцах (ЮНЕСКО), хувь хүний хөгжил, идэвхтэй иргэн байх, нийгэмд тэгш хамрагдах, хөдөлмөр эрхлэх/ дасан зохицох гэсэн өргөн хүрээний зорилготой (Европын комисс) гэж үзэх хандлага өнөө үед дэлхийд хүчтэй байна.

САНАЛ: Боловсролын хуулийг хүүхэд, залуус/суралцагч төвтэй буюу тэдний чадамжийг нээж, хөгжүүлэх гол үндсэн зорилгод анхаарч, сурч боловсрох эрхийг эдлүүлэхэд шаардлагатай бүх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор боловсруулж батлах.

НАСАН ТУРШДАА СУРАЛЦАХУЙН ХАНДЛАГА (Lifelong learning approach)

- Хүний амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн боловсролын тогтолцоог зохион байгуулах зарчим;
- Хүн төрөхөд эхэлж, амьдралын туршид болон гэр бүл, ажил, чөлөөт цаг гэх мэт амьдралын бүхий л хүрээнд үргэлжлэх үйл явц, суралцахуй ба амьдралыг нэгтгэн харах үзэл баримтлал;
- Боловсролд олон тооны уян хатан суралцах арга замууд байх, шинээр элсэн орох, дахин элсэх нь аль ч насны хүнд ээлтэй, нээлттэй, албан

ба албан бус бүтцийн хооронд уялдаа холбоотой, тухайлбал албан бус ба амьдрах орчны боловсролоор олж авсан мэдлэг, ур чадвар, цогц чадамжийг албан ёсоор магадлан итгэмжлэхийг багтаасан ойлголт;

- Боловсролыг “Албан боловсрол + Албан бус боловсрол + Амьдралаас суралцах” гэсэн 3 хүрээнд өргөнөөр авч үзэх. Уг 3 хүрээнд суралцах өргөн боломжийг бий болгох, бүгдэд, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийхэнд хүртээмжтэй байлгах;
- Мэдээлэл харилцааны технологийг үр дүнтэй ашиглах, чанартай суралцах арга замуудыг боломжийн үнэтэй, хүртээмжтэй болгох.

САНАЛ: Бүх шатны боловсролд хамрагдаж чадаагүй хүүхэд/ залууст хоёр дахь боломж олгосон, малчдын хүүхдийн бага насны хөгжилд анхаарч, чанартай хүртээмжтэй сургуулийн өмнөх боловсрол олгох, хүүхдэд ээлтэй дотуур байрыг хөгжүүлэх, насанд хүрэгчдийн боловсрол сургалтын эрэлт хэрэгцээг хангах, ажлын байран дээр суралцах өргөн боломжуудыг хуульчлах.

БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ (Inclusive approach)

- Хүмүүс ялгаатай хэдий ч нэг хүмүүн төрөлтөнд хамаардаг тул бие биендээ хандах, боломж олгохдоо зүй зохист хэмжээнд байх гэсэн ёс суртахууны “тэгш байдал” хэмээх үзэл баримтлалаас үүдэлтэй;
- Нийгмийн янз бүрийн нөхцөл байдалд амьдарч байгаагаасаа шалтгаалан, хүүхдүүд (өөрийн сонголт, эсвэл буруугаас биш) эрүүл мэнд, сайн сайхан байдал, ба амьдралын чанарын хувьд мэдэгдэхүйц ялгаатай байх нь энгийнээр хэлэхэд зүй зохист зүйл биш;
- Тэгш боломж дангаар хангалттай биш, эрхийг нь тэгш эдүүлэхэд чиглэсэн бодлогын болон санхүүжилтийн нэмэлт арга хэмжээг зарим бүлгүүдийн хувьд авч хэрэгжүүлэх;
- Тэгш хамруулах боловсрол нь бүх суралцагчдад хүрч ажиллах боловсролын тогтолцооны чадавхыг бэхжүүлэн, тэдэнд учирч буй саад тотгорыг арилгах хариуцлага үүрч, нийгмийн соёл, дадал, заншилд өөрчлөлт, шинэчлэл хийнэ;
- Энэ нь бүх суралцагчдыг ялгаварлан гадуурхалгүйгээр тэдний сургалтын үйл явц дах бүрэн, үр дүнтэй оролцоо, хамралт, хүсэл эрмэлзлэл болон амжилтад төвлөрнө;
- Тэгш хамруулах нь боловсролын хөтөлбөрийн агуулга, сургалтын арга зүй, хандлага, бүтэц болон стратегид хийж буй тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн үйл явц юм;
- Төр, засгийн байгууллагууд тэгш хамруулах үйл явцад шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийн эх үүсвэрүүдийг хангалттай зориулах ёстой.

САНАЛ: Боловсролын салбарт, ялангуяа улсын сургууль, боловсролын байгууллагын хувьд чанар, орчны ялгаатай байдал, хүүхдийн дунд ялгаварлан гадуурхалт үүсгэж байгаа тусгай, лаборатори, олон улсын хөтөлбөрийн гэж хуульчлахгүй, төрийн өмчийн цэцэрлэг, ЕБС нь хөтөлбөр, үйлчилгээгээрээ ялгаатай байхаар хуульчлах, хүүхдийг гэртээ ойрхон сургууль, цэцэрлэгт хамрагдах нөхцөлөөр хангах.

БОЛОВСРОЛЫГ ТӨР, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТАД БАЙЛГАХ

- Боловсролын салбар, үйлчилгээ нь улс төрийн нам, эдийн засаг болон бусад явцуу ашиг сонирхлоос ангид, тогтвортой, тасралтгүй хөгждөг байх;
- Боловсролын агуулга, зорилго хэт нэг талыг барьж, үзэл суртлын зэвсэг болохгүй байхыг баталгаажуулах;
- Боловсролын зорилго, агуулга, хөтөлбөр нь хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс болон үндэсний соёл, үнэт зүйл, өв уламжлалын зохист харьцааг хадгалах, Тогтвортой хөгжлийн зорилго 4: Чанартай боловсрол зэрэг олон улсын хөгжлийн чиг хандлагад тулгуурласан байх;
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын (Алсын хараа 2050) үзэл баримтлалтай уялдах.

САНАЛ: Боловсролын оновчтой засаглал, удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх; боловсролын талаар шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, ил тод, судалгаа, нотолгоонд суурилсан, сайн засаглалын зарчимд нийцсэн байх; боловсролын үйл хэргийг удирдахад төрийн болон нутгийн захиргааны, иргэний нийгмийн байгууллага, гэр бүл, нийгмийн бүх салбарын оролцоонд суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр зохицуулалт нарийвчлан тусгах.

БОЛОВСРОЛЫН ХУУЛИАР ЗОХИЦУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ТУЛГАМДСАН БОЛОН ШИНЭЭР ҮҮССЭН АСУУДЛУУД

- Тэгш хамруулах боловсрол;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол;
- Үндэстний цөөнхийн хос хэлний боловсрол;
- Багш нарын мэргэжлийн байгууллага;
- Боловсролын салбар дахь засаглал, хариуцлагыг сайжруулах;
- Боловсролын төсөв, санхүүжилт;
- Эцэг эхийн оролцоо;
- Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, хяналт;
- Төрийн бус өмчийн боловсрол сургалтын байгууллагуудад төрөөс хийх зохицуулалт;
- Боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал, ялгаварлан гадуурхалт, үе тэнгийнхний дарамтаас урьдчилан сэргийлэх үүрэг;

- Дотуур байран дахь хүүхдийн эрэлт хэрэгцээ зэрэг нарийвчилсан зохицуулалт;
- Сургуулийн түвшний хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломжийг сургуулиудад бий болгох: мэргэжлийн чиг баримжаа, сурлагын хоцрогдол арилгах, нийгэмсэтгэл зүйн өөрчлөлт, зан төлөвийн өөрчлөлттэй, сахилга батын асуудалтай хүүхэдтэй ажиллах гэх мэт хичээлээс гадуур хөтөлбөрүүдтэй байх, хүүхдийн төлөвшил, хөгжилд ижил түвшинд анхаарах боломж олгох.

БОЛОВСРОЛ ДАХЬ ТЭГШ ХАМРУУЛАЛТ НЬ ЗАЙЛШГҮЙ БӨГӨӨД БҮХ НИЙТИЙН ҮЙЛ ХЭРЭГ БОЛОХ НЬ

Технологийн эрс хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, зөрчил мөргөлдөөн, албадан нүүлгэн шилжүүлэлт, КОВИД-19 цар тахал зэрэг дэлхийн улс орнуудад шинэ сорилтыг бий болгосон нөхцөлд шинэ үеийнхэн үл тэвчихүй, үзэн ядалт, тэгш бус байдлаас зайлсхийж, эв нэгдэл, хүндэтгэл, хамтаараа баяр жаргалтай оршин тогтноход бага наснаасаа эхлэн боловсролд тэгш хамран сурсан байх нь хамгаас чухал болохыг олон улсын сүүлийн хэдэн арван жилийн үйл ажиллагаа, хөгжлийн чиг хандлага, судалгаанууд батлан харуулж байна.

Иймд хүүхэд бүрийг тэдний ялгаатай шинж байдал, нийгмийн гарал үүсэл эсвэл чадвараас нь үл хамааран боловсролд тэгш хамруулан сургах зарчмын үндсэн дээр боловсролын багц хуулиудаа боловсруулах хэрэгцээ шаардлага байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮХ НИЙТИЙН БОЛОВСРОЛ БА ХАМТЫН САЙН САЙХАН³⁷

“Боловсрол бол хүний хөгжлийн гайхамшигт нэгэн хөдөлгүүр билээ. Гагцхүү боловсролын ачаар л ард тариачны охин аврагч эмч, борог уурхайчны хүү уурхайн эзэн, эгэл ажилчны үр эх орныхоо ерөнхийлөгч болно. Хүмүүс нэг нэгнээсээ ялгарах, ондооших шаардлага бий аваас тэр нь юу өвлөснөөрөө бус толгойдоо юу олж хийснээрээ байх учиртай.”

Нельсон Мандела

Хүн төрөлхтний марташгүй, давтаж болшгүй түүхэн сургамж, адал балмад Дэлхийн хоёрдугаар дайны дараа буюу одоогоос далан жилийн тэртээ (1948 онд) Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хүний эдэлбэл зохих эрхийн нэг – сурч боловсрох эрхийг гишүүн улс бүр баталгаажуулахаа зөвшөөрч, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлдээ боловсролын зорилгыг **“бие хүний өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болох..., аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах...”** хэмээн тодорхойлсон юм.

Хожим 1968 онд, одоогоос тавин жилийн тэртээ Гэрээг биелүүлэх ёстой (Pacta sunt servanda) гэсэн зарчмын дагуу баталсан баримт бичгийн 13 дугаар зүйлд **“өөрийнхөө хүн гэсэн эрхэм чанараа бүрэн дүүрэн мэдрэх мэдрэмжийг хөгжүүлэх”**-ийг нарийвчлан заажээ. Удалгүй 1972 онд Эдгар Фор тэргүүтэй нөхөд *Хүн болохын тулд суралцах нь: Одоогийн болон цаашдын боловсролын ертөнц* тайландаа “насан туршдаа суралцах нь хүний хөгжилд амин чухал” гэсэн санааг илэрхийлжээ.

Жак Делор 1996 онд бичсэн *Суралцахуй: Түүнд нуугдсан эрдэнэс* тайландаа “боловсрол нь хувь хүний төдийгүй хүй олны хөгжлийн амин зүрх бөгөөд хүн нэг бүр өөрийн авьяасаа бүрэн хөгжүүлэх, цаашилбал амьдралаа хариуцан авч явах, өмнөө тавьсан зорилгодоо хүрэх зэргээр өөрт байгаа бүтээлч потенциалгаа танин мэдэх” гэж цохон тэмдэглэж, суралцахуйн дөрвөн баганыг үг, үзэл санаагаар босгосон нь эдүгээ цагт сүндэрлэсээр байна.

Аливаа хүн амьдралынхаа турш боловсрол олж авдаг. Ийнхүү суралцахдаа дээр дурдсан “дөрвөн багана” гэх алхам заавал байх ёстой ажээ:

³⁷ Хүний эрхийн шинжээч Б.Болорсайханы илтгэл, нийтлэл, лекцээс тоймлон бэлдэв.

**БУСАДТАЙ ХАМТРАН АМЬДРАХЫН
ТУЛД СУРАЛЦАХ:**

Нийгмийн ур чадвар, үнэт зүйлсээ хөгжүүлэх, хорвоо ертөнцийн ялгаатай байдлыг таашаах

**ХҮНИЙ ЁСООР ОРШИХЫН ТУЛД
СУРАЛЦАХ:**

Өөрийгөө бие даан хөгжүүлэх, бие дааж нийгэмдээ бүтээлчээр хувь нэмрээ оруулах

**СУРАЛЦАХУЙН
ДӨРВӨН БАГАНА**

ХИЙХИЙН ТУЛД СУРАЛЦАХ:

Ур чадвараа хөгжүүлэх, асуудлаа шийдвэрлэх, мэдлэгээ таашаах чадавхтай байх

МЭДЭХИЙН ТУЛД СУРАЛЦАХ:

Анхаарлаа төвлөрүүлэх, мэдээллийг хадгалах, бодох, мэдлэгээ хөгжүүлэх чадавхтай байх

Төрийн түшээдийн эрхэмлэж буй цэрэгжилт чухал гэж үзвэл Мьянмарын (хуучнаар Бирм) төрийн төдийгүй хувийн хэвшил, тэр дундаа үнэт чулуу, хар тамхи, газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийг гартаа авсан эрх мэдэл, мөнгөөр сагаж буй цэргийн эрхтэн дархтны дарангуйллыг; хэл, соёл, үндэс угсаа нэгт Солонгос 1950 оноос хойш хоёр хуваагдаж, Зүүн Азид зэвсэглэлээр хөөцөлдсөн бүс нутагт аюул заналхийлж байгааг; эзлэн түрэмгийлэх цэрэгжсэн бодлогын үрээр асар их хохирол амссан Японыг; Энэтхэг, Пакистаны зөрчилдөөн, мөргөлдөөнийг эргэн харвал зохино.

Байгалиа дээдэлдэг, эх оронч хүнийг математик, монгол хэл, монгол бичиг, уран зохиол, хими, физик, биологи, эрүүл мэнд, газарзүй, түүх, нийгэм судлал, хөгжим, дүрслэх урлаг, гадаад хэл, иргэний боловсрол, хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар бэлдэж, үнэт зүйлсийг суулгаж болно.

Цаашилбал хүндээ үнэт зүйлсийг суулгаж өгөхийн тулд үүнээс гадна шинэ боловсролын санаачилга байгааг цухас дурдвал:

Боловсролын санаачилга	Суралцахуйн зорилгыг илэрхийлэх мөн чанар
Энх тайвны боловсрол	Зөрчилдөөнийг шийдвэрлэх, энх тайванч байх, эвлэрэн найрамдах, хүлцэн тэвчих, хүний эрх, иргэний оролцоог хүндэтгэх
Харилцан нэгнээ ойлгох боловсрол	Нийгмийн эв эе, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, хүн бүрийг тэгш хамруулсан үндэсний амин чанарыг хөхиүлэн дэмжих
Олон хэв шинжит соёлын / Соёл хоорондын боловсрол	Ялгаатай байдлыг хүндэтгэх, хүлцэн тэвчих, арьс үндсээр алагчлахгүй байх, үл ялгаварлан гадуурхах

Хүний эрхийн боловсрол	Хүний эрх, хариуцлагад хүндэтгэлтэй хандах, нийгэмд гадуурхагдсан, сул дорой, эрх мэдэлгүй охид, эмэгтэйчүүд, цөөнхийн эрхийг хүндэтгэх, хүлцэн тэвчих, үл ялгаварлах, дарамт шахалт, хүчирхийллээс ангид байх, иргэний оролцоог хөхиүлэн дэмжих
Амьдрах ур чадварын / Эрүүл мэндийн боловсрол	Хорт зуршлаас ангид, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хүндэтгэх, хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх
Иргэний боловсрол	Иргэний/улс төрийн амьдралд идэвхтэй, хариуцлагатай оролцох, ардчилал, хүний эрхийг хүндэтгэх, хүлцэн тэвчих
Тогтвортой хөгжлийн боловсрол	Хүрээлэн буй орчны тогтвортой байдал, хүн бүрийн эдлэх эрх, тэдний сайн сайхан байдлыг эн тэргүүнд анхаарч, хүндэтгэх
Дэлхийн иргэний боловсрол	Нийгмийн болон дэлхийн аль ч өнцөгт бусадтай зэрэгцэн амьдрах, идэвхтэй улс орноо удирдах залах, хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсээ хөхиүлэн дэмжих
Хүмүүнлэгийн боловсрол	Дайн, онц байдал, гамшигт нөхцөл байдлын үед даган мөрдөх хүмүүнлэгийн хэм хэмжээ, хүмүүнлэгийн үйлдлийг хүндэтгэх, үл ялгаварладаг байх
Үнэт зүйлсийн боловсрол	Энх тайвныг эрхэмлэх, бусдыг хүндэтгэх, анхаарч ойлгох үнэт зүйлсийг хувь хүнд суулгах

Бид нэг нэгнээ нутгийн аялгаар өөнтөглөх, ахуйтайгаа холбоотой үгийн сангаар нь шоглох, “Тува”, “Казах”, “Буриад”, “Дөрвөд” хэмээн сэтэр зүүх, жалга дов, нутгаараа талцах, түүнийг нь эрх мэдэл, мөнгөөр улам дэвэргэх, тухайн үйлдлийг дагаж саймшрах, эв эегүй бусдыгаа хүчирхийлж санаа амрах, хүн гэсэн эрхэм чанарыг нь уландаа гишгэж үл тоох, нас, хүйс, угсаа гарвал, нийгмийн байдал, оршин суугаа газар гээд төрөл бүрээр ялгаварлан гадуурхах үйлдэл түгээмэл байгаа нь боловсролын зорилгоо “тогтолцооны эрэг шураг/ажиллах хүч бэлдэх” гэж явцуу тодорхойлсоор байгаагийн хор уршиг билээ.³⁸

Энэ дундаас хүний эрхийн болон иргэний боловсрол ямар байгааг хүүхэд, эмэгтэйчүүдэд хэрхэн хандаж байгаагаар тухайн улс орныг тодорхойлон харах боломжтой байдаг.

“Хүний эрх гэж ярьж байснаа яагаад хүүхдийн эрх гэж тусдаа ярих болчихов оо?” хэмээн олон хүн гайхширдаг. Заримдаа “Хүүхдийн эрх дэндлээ, үүрэг ярих болсон. Барууны үзэл дэлгэрлээ” гэх хүн ч бий. Гэтэл ийнхүү ярих насанд хүрэгчид, заримдаа хүүхдийн итгэлийг дааж явсан хүмүүс хүүхдийг үл тоож, нас, хүйс, туршлагаар ялгаварлан гадуурхаж, зүй бус авирладаг.

Хүчирхийлэл бол зөвхөн нударгаар цохих, хөх няц үлдээх биш, бүр хүүхдээ анхаарахгүй байх, хайраар дутаах, итгэлийг нь мохоох, доромжлох,

38 Б.Болорсайхан, “Хүний эрхийн нэгэн асуудал – Боловсролын зорилго” нийтлэл. (2018 оны 6-р сар) Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://jargaldefacto.com/article/khunii-erkhiin-negen-asuudal-bolovsroliin-zorilgo>

дарамтлах, айлгах, цочоох, хаалгаар мөрлөөд урдуур нь орох гээд маш олон хэлбэртэй байдгийг тэр бүр томчууд мэддэггүй. Заримдаа багаасаа тийм таатай орчинд өсөөгүй тул хүүхэд аюулгүй, айдсаас ангид, баяр хөөртэй “Таатай нөхцөлд амьдрах ёстой” гэдгийг бүр төсөөлөхгүй үе байдаг.

Хүний эрхийн Үндэсний Комисс, Гүүд Нэйборс олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран 2016 онд хийсэн Хүүхдийн эрх ба хамгаалал үндэсний судалгаанд хамрагдсан 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэг байдлаар хүчирхийлэлд өртсөн, түүнээс 2 хүүхэд тутмын 1 нь бие махбодын хүчирхийлэлд, 4 хүүхэд тутмын 3 нь сэтгэл санааны хүчирхийлэлд, 3 хүүхэд тутмын 1 нь үл хайхрах хүчирхийлэлд, 8 хүүхэд тутмын 1 нь бэлгийн шинжтэй дарамт, халдлагад өртсөн аж. Давтамжийн хувьд хүүхдүүд бие махбодын хүчирхийлэлд хамгийн их өртдөг бөгөөд энэ нь ихэвчлэн гэр бүл, сургуулийн орчинд гардаг байна.

Хүүхэд насанд ямар хүчирхийлэл тохиож байгааг зонхилох хэлбэрээр харуулсан нь



Эх сурвалж: INSPIRE Хүүхдийг хүчирхийлэхээс сэргийлэх долоон стратеги, 2016 он. 14 дэх тал

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас Зүүн Ази, Номхон далайн бүсэд хүүхэд хэрхэн хүчирхийлүүлж байгааг 2014 онд судлахад Монгол Улсад хүүхдийг хүчирхийлэх нь хэр тархсан, ямар дагавартайг харуулах тоо баримт тэр бүр нарийвчлалтай байхгүй ажээ. Тус бүс нутгийн хэмжээнд 5-14 насны хүүхдүүдийн хувьд гол төлөв 10 хүүхэд тутмын 1 нь хөдөлмөрлөж байсан бол манай улсад 3 хүүхэд тутмын 1 нь (дунджаар 3 хөвгүүний 1, 4 охины 1) байжээ. Мөн 2-14 насны нийт хүүхдийн 46 хувь буюу бараг 2 хүүхдийн 1 нь сэтгэл санааны дарамт, бие махбодын шийтгэл зэрэг хэрцгий аргаар хүмүүжиж байх жишээтэй. Цаашилбал 4 хүүхэд тутмын 1 нь хүүхэд насандаа ямарваа нэгэн тааламжгүй туршлага (гэр бүлийн таагүй орчин, хүчирхийлэл, үе тэнгийн дарамт, шахалт гэх мэт) хуримтлуулсан байна.

Дээрх судалгаанаас нэгтгэн харвал хүүхдийг хүчирхийлэх нь дан хувь хүнээс хамаарахгүй гэр бүл, хамт олон, үе тэнгийнхэн, нийгэм, соёл, хүрээлэн

буй орчин гээд маш өргөн хүрээг хамарсан, харилцан адилгүй нийгмийн тогтолцоо, байгууламж, бодлого хүртэл шууд нөлөөлдөг онцлогтой. Хүчирхийлэл нь олон хэсгээс бүрдэх тул салбар хоорондын төрөл бүрийн оролцогч талуудыг оролцуулан анхаарах ёстой. Эрүүл мэнд, шим тэжээл, боловсрол, санхүүжилт, нийгмийн болон хүүхэд хамгаалал зэрэг бүх салбар хооронд үр нөлөөтэй, хүчтэй хамтын ажиллагаа амин чухал. Үүнтэй уялдан хүүхдийн хүчирхийллийг таслан зогсооход гэмт этгээдийг цаазлах бус, нийгэм-экологийн загварыг ашиглан бодлого шийдвэрээ хүний эрхэд суурилсан, илүү оновчтой, алсыг харсан байдлаар боловсруулах, түвшин бүрт тохирсон шийдвэр гаргаж хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хүүхэд, өсвөр насныхныг хүчирхийлж байгааг ойлгох нийгэм-экологийн загвар



Эх сурвалж: Матерновска, Фрай нарын 2015 онд боловсруулсан “Хүчирхийллийг ойлгох нийгэм-экологийн загвар”-г тулгуурлан сайжруулсан загвар

Хүүхэд бол нас биед хүртлээ бусдаас дэмжлэг, туслалцаа авч, насанд хүрэгчдээс шууд хамааралтай өсөж өндийдөг боловч бусдын адил хүний төрлийг олж төрсний хувьд хүндэтгэл хүлээхүйц эрхэм чанартай, өөрийн гэсэн үзэл бодолтой, туршлагатай, авсан мэдээлэлдээ тулгуурлаж шийдвэр гаргадаг, эрх эдэлдэг этгээд юм. Иймээс хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, хүчирхийллээс ангид өсгөх нөхцлийг бүрдүүлэхэд олон талын оролцоо чухал төдийгүй төр, хувийн хэвшил, орон нутаг дахь салбар бүр тусгайлан анхаарах ёстой. Аливаа хүчирхийллээс ангид байх нь хүүхэд төдийгүй хүн бүрийн өөрийн эрхээ бүрэн дүүрэн эдлэх, сайн сайн амьдрахын суурь билээ.³⁹

39 Б.Болорсайхан, “Хүүхдийн эрхийн нэгэн асуудал – Хүчирхийлэл” нийтлэл. (2018 оны 6-р сар) Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://www.jargaldefacto.com/article/khuukhdiin-erkhiin-negen-asuudal-khuchirkhiilel>

Хүүхдийг хүчирхийлэхээс урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх стратеги, хандлага, салбар⁴⁰

СТРАТЕГИ	Хандлага, арга зүй	Салбар	Салбар хоорондын үйл ажиллагаа
Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сахиулах	<ul style="list-style-type: none"> Эцэг эх, багш, бусад халамжлагчийн зүгээс хүүхдийг хэрцгий хэлбэрээр шийтгэхийг хориглосон хууль Хүүхэдтэй хийх бэлгийн зүй бус үйлдэл, мөлжлөгийг гэмт хэрэгт тооцсон хууль Согтууруулах ундааг зүй бусаар хэрэглэхээс урьдчилан сэргийлэх тухай хууль Залуучууд галт болон бусад зэвсэг хялбар авах боломжийг хязгаарласан хууль 	Шүүх	Харилцан адилгүй салбарт авах арга хэмжээ, үнэлгээ
Хэм хэмжээ, үнэт зүйлс	<ul style="list-style-type: none"> Хор хөнөөлт, сөрөг жендэрийн болон нийгмийн хэм хэмжээг өөрчлөх Хамт олныг дайчлах хөтөлбөр Хөндлөнгөөс ажигладаг хүмүүст нөлөөлөх 	Эрүүл мэнд, боловсрол нийгмийн халамж	
Аюулгүй орчин	<ul style="list-style-type: none"> Хүчирхийллийг бууруулах Хүчирхийллийг гааруулахгүй таслан зогсоох хамтын таатай орчин бий болгох 	Дотоод төлөвлөлт	
Эцэг эх, халамжлагчийн дэмжлэг	<ul style="list-style-type: none"> Гэртээ ирэх Хамт олны хүрээнд бүлгээр хүрэх Цогц хөтөлбөрөөр дэмжих 	Нийгмийн халамж, эрүүл мэнд	
Орлого, эдийн засгийн баталгаа	<ul style="list-style-type: none"> Бэлэн мөнгө шилжүүлэх Хамтын хадгаламж, зээлийг жендэрийн эрх тэгш байдалтай холбож заах Бичил санхүүгийн хичээлийг жендэрийн хэм хэмжээтэй хослуулах 	Санхүү хөдөлмөр	Мониторинг, үнэлгээ
Хариу үйлдэл үзүүлэх, дэмжих үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Зөвлөх, сэтгэл засах үйлчилгээ Хөндлөнгөөс оролцохдоо давхар хянах Гэмт хэрэгт холбогдсон, шийтгэгдсэн хүүхдэд чиглэсэн хөтөлбөр Нийгмийн халамжаар уялдсан хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ 	Эрүүл мэнд, шүүх, халамж	
Боловсрол, амьдрах ур чадвар	<ul style="list-style-type: none"> Сургуулийн өмнөх боловсрол эзэмших, сургуульд элсэн сурахыг нэмэгдүүлэх Аюулгүй, таатай сургуулийн орчныг бий болгох Бэлгийн зүй бус үйлдлийн талаар хүүхдийн ойлголтыг нэмэгдүүлж, өөрийгөө хэрхэн хамгаалах талаар заах, Нийгмийн болон амьдрах ур чадварын сургалт Ойр дотно харилцалцаатай өсвөр насныхны дунд хүчирхийлэл гарахаас сэргийлэх хөтөлбөр 	Боловсрол	

[1] Хүүхдийг хүчирхийлэхээс сэргийлэх долоон стратеги, 2016 он.

40 НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг, Хүүхдийг хүчирхийлэхээс сэргийлэх долоон стратеги, 2016 он.

Сурч боловсрох эрх нь зөвхөн хүүхдийг сургуульд хамруулах, боловсролтой болгохоор хязгаарлахгүй чанартай боловсрол эзэмших эрхийг багтааж ойлгодог. Тэгвэл “чанар” гэдгийг хэрхэн харах ёстой вэ? Боловсролын салбарт ажилладаг, боловсролын талаар сонирхон судалдаг бүх, ялангуяа эцэг, эх бид юу анхаарах вэ? Олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс боловсролыг чанартай байлгах талаар ямагт анхаарч, олон баримт бичигт тусгайлан зааж, зорилт, хөтөлбөрийн агуулгад тусгасаар ирсэн.

Жишээ нь:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал;
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт;
- Хүүхдийн эрхийн тухай конвенц;
- Боловсролыг бүх нийтэд олгох тухай дэлхийн тунхаглал;
- Мянганы тунхаглал;
- Дакарын үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Мянганы хөгжлийн зорилт;
- Тогтвортой хөгжлийн зорилго зэргийг нэрлэж болно.

Тэр дундаа 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалд ард түмэн, тив, хил, хэл үл харгалзан сурч боловсрох эрх, боловсролын зорилго юу болохыг олон улсын гэрээний хүрээнд анхлан тогтоосноор боловсролын агуулга, багшлах, суралцах үйл явц, материал, суралцах орчин, сургалтын үр дүнг дэвшүүлж заасан нь өдийг хүртэл нөлөөтэй байна.

Мөн Боловсролыг бүх нийтэд олгох тухай 1990 оны Жомтейны тунхаглалд чанар муутай боловсролыг хэрхэн сайжруулах, хүн бүрд хэрхэн хүртээмжтэй болгох, хоорондоо яаж холбоо уялдаатай байдлаар олгох, тэгш боломжоор хүмүүсийг хангах зэрэг нь урьдач нөхцөл болж чанарт хамаарна гэдгийг хүлээн зөвшөөрсөн ажээ. Арван жилийн дараа 2000 онд баталсан Дакарын үйл ажиллагааны төлөвлөгөөнд чанартай боловсролын хүртээмжийг хангах нь хүүхдийн эдэлбэл зохих эрх гэж цохон тэмдэглэсэн бөгөөд “Чанар бол боловсролын зүрх. Энэ нь сурагч юу сурах, хэрхэн сурах, өөрийн боловсролоос тухайн суралцагч ямар үр ашиг хүртэхийг тодорхойлдог” гэж онцолжээ. Тодруулбал, чанар нь:

- суралцагчдад байх онцлог шинж чанар (эрүүл, сэдэлжсэн сурагч);
- үйл явц (сурган хүмүүжүүлэх идэвхтэй арга зүй ашигладаг чадавхтай багш);
- агуулга (холбоо хамаарал бүхий сургалтын хөтөлбөр);
- тогтолцоо (сайн засаглал, тэгш боломжийг бүрдүүлэхүйц нөөцийн хуваарилалт) зэргээс бүрдэнэ гэж өргөнөөр тодорхойлсон.

“Боловсролыг бүх нийтэд: Дэлхийн хяналт үнэлгээний 2005 оны тайлан”-д боловсролын чанарт зарчмын хувьд хоёр тодорхойлолт өгчээ:

Боловсролын бүх тогтолцоон дахь хамгийн чухал зорилт нь суралцагчдын танин мэдэхүйн хөгжил болно;

Хариуцлагатай иргэний үнэт зүйл, хандлагыг хөхиүлэн дэмжих, бүтээлч болон сэтгэл хөдлөлийн хөгжлийг бүрдүүлэхэд боловсролын гүйцэтгэх үүрэг чухал.

Үүнээс харвал хүүхэд хэр хэмжээгээр, хэр сайн суралцсан, тухайн хувь хүнд, нийгэмд, хөгжилд ямар үр ашигтай байгаагаар боловсролыг тодорхойлж болох юм. Багшлах, суралцах үйл явцаас сургалтын хөтөлбөр амьдралд бууж, анги, танхим, суралцах орчинд хүмүүс хэрхэн харилцаж, нэг нэгнээсээ суралцаж байгаагаар суралцах үйл явцын үр дүнг тогтоох боломжтой ажээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26-р зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 13(1)-р зүйл, Хүүхдийн эрхийн тухай конвенцын 29(1)-р зүйл, мөн тус конвенцын 2001 оны Боловсролын зорилгын талаарх Нэгдүгээр ерөнхий зөвлөмж зэрэг хүний эрхийн олон улсын хэм хэмжээний баримт бичигт тоо тоолол, бичиг үсэг тайлахаас өргөн хүрээтэй буюу хувийн хүний онцлог шинж, авьяас, ур чадвараа бүрэн дүүрэн нээх, хөгжүүлэх, нийгэмдээ сэтгэл хангалуун, дүүрэн амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээр боловсролын зорилгыг заажээ.

Сурч боловсрох эрхийг эдлүүлэхдээ төрийн зүгээс “4А схем” (4-As scheme – making education available, accessible, acceptable and adaptable) гэж олноо танигдсан шалгуураар харахын хамт боловсролын тогтолцоог шинэчлэхдээ “6А бүрэлдэхүүн” (assessment; autonomy; accountability; attention to teachers; attention to early childhood development; and attention to culture) -ийг харгалзаж үзэхийг судлаач, шинжээчид зөвлөдөг.

Төр сурч боловсрох эрхийг эдлүүлэх өөрийн үүргээ биелүүлэхийн тулд боловсролыг дараах байдлаар баталгаажуулж, хангана:


1. ХҮРЭЛЦЭЭТЭЙ – Төсөв хангалттай хуваарилсан байх, сургуулийн насны хүүхдийн тоонд харгалзсан сургуультай байх буюу нэг ангид ялгаатай 20-25 хүүхэд суралцах нөхцөл бүрдүүлэх, багш хангалттай байх (академик эрх чөлөө, мэргэжлийн хариуцлага, боловсролын зэрэг, давтан сургалт, ажилд авах шударга үйл явц, хөдөлмөрлөх эрх, үйлдвэрчний эвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан байх);
2. ХҮРТЭЭМЖТЭЙ – Хууль зүйн, захиргааны шинжтэй ямарваа нэгэн зохиомол саадгүй байх, санхүүгийн хүндрэлээс ангид байх, суралцахад ялгаварлан гадуурхсан шинжтэй саад учрахгүй байх (хэлний болон хөгжлийн бэрхшээл, дэд бүтэц, дотуур байрны орны тоо, хүүхдийн суудал, ангийн даац, “сугалаа” гэх мэт), заавал хамрагдахад саадгүй байх байх (төлбөр, хураамж, газар зүйн байрлал, цагийн хуваарь, ээлж гэх мэт);
3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН – Эцэг эх өөрийн хүүхдэдээ сургууль сонгох, наад захын шаардлага хангасан байх (аюулгүй байдал, эрүүл мэнд, орчин, чанар гэх мэт), зааварчилгааны хэл, ялгаатай байдлыг хүндэтгэх, хүүхдийг эрх агуулагч, хувь хүн гэж харах, чөлөөтэй хөгжих, үгээ хэлэх, өөрийгөө илэрхийлэх боломжийг хүлээн зөвшөөрсөн суралцах орчинтой байх;

4. ЦАГ ҮЕТЭЙГЭЭ ЗОХИЦСОН БАЙХ – Цөөнх, уугуул, малчин, хөгжлийн бэрхшээлтэй, дүрвэсэн, цагаачилсан, дайжсан, шилжин суурьшсан хүүхдэд хүртэл хүрч ажиллах, тэдний хэрэгцээтэй уялдах, хуульд заасан насанд нь тохирсон агуулгыг хүргэх, хүүхдийг гэрлүүлэх, хөдөлмөрлүүлэх, цэрэг болгохоос ангид байх, хүүхэд нэг бүрийн тусгай хэрэгцээг харгалзах, хангах зэрэг болно.

Боловсролын тогтолцоог шинэчлэхдээ төрийн зүгээс эн тэргүүнд дараах бүрэлдэхүүн хэсгийг анхаарч ажиллавал зохино:

- ҮНЭЛГЭЭ – Хэмжүүр, түүнд суурилсан үнэлгээг хийснээр боловсролын төлөвлөлт, шинэчлэл хийх сууриа бэлдэнэ. Өнөөгийн боловсролын тогтолцоогоо хаана байгааг хэмжиж, үнэлж чадахгүй тохиолдолд юуг сайжруулахаар зорих нь өрөөсгөл билээ.
- БИЕ ДААСАН БАЙДАЛ – Сургууль өөрөө чадавхжих нь чанарт эерэг нөлөөтэй. Сургуулиуд өөрийн гэсэн шинж, өөриймсөг байдлаа хамт олон, иргэд нь хадгалсан, нөөцөө дундаасаа бүрдүүлсэн, асуудлын талаар хамтын дуу хоолойтой байх нь эгэх хариуцлагын механизмыг сайжруулах, иргэдийн оролцоонд суурилах, суралцагчдын онцлог хэрэгцээг эн тэргүүнд хангах давуу талтай.
- ЭГЭХ ХАРИУЦЛАГА – Үүрэг даалгавар, академик амжилтыг заасан хугацаанд гаргах боломж бүрддэг. Шийдвэр гаргах эрх мэдлийг босоо бус, хэвтээ болгож өөрчилснөөр сургуулийн хамт олон, эцэг эх, багш, бусад ажилтан, суралцагчид хамтрах, шинэ чиг үүрэг, хариуцлага хүлээж ажиллах, нөөцөө хуваарилах, үйл ажиллагаа зохион байгуулах хэлбэр илүү үр өгөөжтэй болно. Сургуулийн удирдлага нь шууд эцэг эх, орон нутгийн иргэд, удирдлагын өмнө ажлаа тайлагнаж, үнэлүүлж эхэлнэ. Орон нутгийн удирдлагаас санхүүгийн захиран зарцуулах мэдэл шилжсэнээр суралцах орчин, сургалтын үр дүнд ахиц, дэвшил гарна.
- БАГШИД ТАВИХ АНХААРАЛ – Сайн багшаас суралцах үйл явц шууд нөлөөлөх тул суралцагчдад гарах сургалтын үр дүн шууд хамаарна. Багшийг шилдэг сурган хүмүүжүүлэгч хэвээр хадгалахын тулд ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, зохист хэлбэрээр тэдний хэрэгцээнд нийцүүлэн сургаж байх ёстой.
- БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД ТАВИХ АНХААРАЛ – Бага наснаас эхлэн хүүхдэд хөрөнгө оруулснаар боловсролын чанарт үнэтэй хувь нэмэр оруулна. Хүүхдэд зориулсан 1 ам.долларын ашиг тус 7-12 дахин өсөж, үр өгөөжөө өгдөг. Нас биед хүрсэн хойноо биеэ дааж, халамжаас хамааралгүй амьдрах учир төрд дарамт хүндрэл учруулах нь эрс буурна.
- СОЁЛД ТАВИХ АНХААРАЛ – Соёл чухал хэдий ч үл тоож ирсэн. Зааварчилгаанд эх хэл ашиглах, шашны үнэт зүйлсийг хүндэтгэх, угсаатны болон нийгмийн ялгаатай байдалд хүлээцтэй байх, нөөцийг ялгаатай хэрэгцээнд харгалзаж хуваарилах, зарцуулах ёстой.

Ийнхүү боловсролын чанарт нөлөөлдөг бүтэц болон тогтолцооны шинжтэй хүчин зүйлсийг харгалзаж, цогцоор нь бүхэл байдлаар харж шийдвэрлэвэл зохино.



Хүүхэд байхаас нас биед хүрэх хугацаанд боловсролын ямар тогтолцоогоор бид хэрхэн бэлтгэгдсэн бэ гэдгийг харьцуулан үзэж болох юм. **Боловсролын чанарыг дээрх зурган дээрх бүх асуулт эерэг байсан гэж хариулсан тохиолдолд та, бид, таны хүүхэд чанартай боловсрол эзэмшжээ гэж харах нь зүйтэй.**⁴¹

Ямар улс төрийн хүчин төрийн эрх барьж байгаагаас үл хамааран асар хурдацтай хувиран өөрчлөгдөж байгаа өнөөгийн ертөнцөд боловсролын үндсэн зорилго нь хүний нэр төр, эрхэм чанар, өөрийн нөөц, боломж боллоцоо, хүрээлэн байгаа орчныг нэгэн зэрэг хүндэтгэх, хамгаалах, хөхиүлэн дэмжихтэй шууд уялдана. Өнөөдөр амьдарч байгаа өнгөрсөн, одоо цагийг эрхшээх төлөөлөлд төдийгүй ирээдүй үеийн боломж, боллоцоог үрэн тарах хийх, үгүйсгэх, үл тоох ямарваа нэгэн бодлоготой байхыг улс орнууд хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж эхэлсэн билээ. Тэр дундаа хүнийг нийгмээс адалдаг, ялгаварладаг, тогтолцооны эрэг шураг эсвэл мөнгө, санхүүгийн

41 Б.Болорсайхан, “Боловсролын чанар, түүний эргэн тойронд” нийтлэл (2019 оны 6-р сар). Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://ikon.mn/opinion/1m0t>

урсгал хэмээн хүн бишээр шошголж хардаг, хүнлэг бус харьцааг өөгшүүлж, цөөнхийг үл тоож, эрх мэдэл, хөрөнгө чинээ, санхүүгийн чадавхаар нийгмээ хагалдаг, заагладаг байж болохгүй. Харин боловсролын үрслүүлэн түгээх үнэт зүйлсэд хүний туулсан амьдралыг хүндэтгэх, нэр төрийг дээдлэх, эрх тэгш байдал, нийгмийн шударга ёс, хүмүүсийн олон янзын бүлэг, хамтын эв санааны нэгдэл, ирээдүйн төлөөх үүрэх ачаа – хариуцлага томоохон байр суурь эзэлнэ, ийнхүү олговол зохино.

Одоогийн ирээдүй тодорхойгүй, шийдвэрлэхэд бүрхэг цаг үеийг туулахад хүн нэг бүрд гэрэлт ирээдүй бүтээхэд боловсрол нь гагцхүү төрийн хариуцсан, дангаар олгодог нийтийн сайн сайхан биш болжээ. Тухайн хувь хүн нийгмийн ямар бүлэгт хамаарах, аль түвшинд орших, өөрийн төрөлх эх нутагтаа өөдлөн дэвших, сайн сайхан амьдрахад боловсрол чухал нөлөөтэй гэсэн итгэл, найдвар төрүүлэхэд ч урьд хожид байгаагүй ач холбогдолтой болов. Нийтийн сайн сайхан гэсэн ойлголтыг нийгмийн/олон нийтийн баялаг хэмээн орчуулж, гагцхүү эдийн засгийн өнцгөөс тайлбарлах хандлага олон арваны турш хүчтэй явж ирсэн. Тэр дундаа олон нийтэд зориулсан бараа, үйлчилгээ (public good) гэсэн утгаа ч мөн чанараар нь хэрэгжүүлж чадаагүй. Тодруулбал, төр дангаар хариуцах нийтэд зориулсан бараа, үйлчилгээнд тавих шалгуурыг харвал:

- Үл гадуурхах (нэг хэрэглэгч тухайн бараа, үйлчилгээг өөр хэрэглэгч хэрэглэхийг зогсоож болохгүй);
- Үл дайсагнах (нэг хэрэглэгч тухайн бараа, үйлчилгээг хэрэглэснээр өөр хэрэглэгч хэрэглэхийг зогсоож болохгүй);
- Аливаа этгээдэд хамаатай (бүх хэрэглэгч хэрэглэнэ);
- Үл татгалзах (хэрэглэхээс татгалзах боломжгүй байна).

Гудамжны гэрэлтүүлэг, аюулгүй байдал, дэд бүтэц, нийтэд зориулсан цэцэрлэг, амралтын хүрээлэн, цоргоор гоожих ундны ус, ариун цэврийн байгууламж, нийтийн халуун ус, цэвэр агаар хүртэл багтана. Үндэсний болон олон улсын байгууллагын харилцан адилгүй судалгаагаар хувь хүний аюулгүй байдал, халдашгүй байдал, хувь хүний эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, боловсролын хүртээмж, хүрээлэн буй орчны бохирдол нь хүний эрхийн зөрчилд тооцохуйц ноцтой байгааг мэднэ. Үүний зэрэгцээ ямарваа нэгэн хувь этгээд гагцхүү ашиг, орлого хүртэж байхыг нийтийн баялагт тооцдоггүй туршлагатай. Манай цаг үед буюу 2015 онд Уэлман гэх эрдэмтний одоогийн бид нар “19-р зууны сургалтын хөтөлбөртэй, 20-р зууны бодлого зохион байгуулалттай байгаа нь 21-р зууны иргэдийн ирээдүйг гэрэл гэгээтэй байлгана гэдэг худлаа” гэж хэлсэнчлэн мэдлэгийг хэн нэгэн дангаар өмчлөн, хүн төрөлхтний хамтын бүтээл, өв хэмээн харахгүй байх маш харалган явдал юм⁴².

42 “Өглөөний хүн” ярилцлага, Б.Болорсайхан: “Боловсролын тэгш боломж нь ардчиллын суурь гэдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой” (2019.04.11). Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://ikon.mn/lr/1job.html>

Боловсролын бүх салбарт хувьчлал явуулснаар боловсролтой болох боломж, бололцоо улам ялгарч, тэгш бус байдал гаарахын хамт төрийн зүгээс нийтийн баялаг гэж чухалчлан үздэг өөрийн үүргээс татгалзах хандлага улам түгэв. Эргэн харвал “олонх аз жаргалтай байвал цөөнхийн зовлон, шаналал хамаагүй” гэсэн утилитар, мөн “ашиг, орлого олж байвал боловсролыг бараа, бүтээгдэхүүн, арилжаанд тооцох” эдийн засгийн загвараас илүүтэйгээр тухайн улс дахь хүн ард, цаашилбал бүс нутаг, хэддээ дэлхий дахины хүн төрөлхтний гэр бүлийн гишүүн нэг бүрд хамтын хэл, хөрс, үндэс, үнэт зүйлс түгээх алсын харааны цаана боловсролын зорилго, чанарыг олон улсын хамтын нийгэмлэг ярьж ирлээ. Нэг талаас илүү гуманист шинжтэй, утилитар хандлагын эсрэг хамтын сайн сайхан цогцлоох гэсэн алсын харааг агуулсан төдийгүй хувь хүний харах өнцгөөс илүүтэй тухайн нийгмийн/хамтач хөгжил, нийтийн ашиг сонирхлыг хадгалахаа илэрхийлдэг хэв шинж бол боловсролыг нийтийн баялагт тооцох үзэлд бий. Хүний эрхэд суурилсан хандлагын үүднээс төр санхүүжүүлэх, боломж, бололцоог бүрдүүлэх, бодлого боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зохицуулах үүргээ сайтар биелүүлэх ёстой.

Нөгөө талаас эртний Ромын эрх зүйгээс үүдэлтэй “хамтын”, “дундын” (res communes) гэсэн ойлголтод амьсгалах агаар, урсах ус, үржил шимт сав газар, далай, гол мөрний ай саваас гадна хүн төрөлхтний биет болон биет бус хамтын бүтээл, өв, соёл болсон шинжлэх ухааны ололт, амжилт, ард түмний уламжлалт туршлага, цаашилбал нэгэн гарагт эв найртайгаар амьдрах хамтын амьдрал, түүнийгээ сайн сайхан өнгөрүүлэх тухай хүрээг хамран өргөжсөн байна.

Иймд боловсролыг бараа, бүтээгдэхүүн, арилжаа хэмээн харахаас илүүтэйгээр төр үүрэг хүлээгчийн хувиар хариуцлагатай гардан авч явах, хүн нэг бүрд чанартай хүрэхийн хамт нийгэм, эдийн засаг төдийгүй иргэний, соёлын мөн чанарыг ч харгалзан, ил тод, нээлттэй, шударга, эрх тэгш байдлаар түгээх баялаг, айдас, гачигдал, дарамт, ялгаварлалгүй хамтын сайн сайхан амьдралын урьдач нөхцөл ажээ.

ЕРӨНХИЙ АСУУДАЛ БА ШИЙДЭЛ

Энэ сэтгүүлийн бүлэг тус бүрд боловсролын асуудлыг тодорхойлж, шийдлийг жич жичээр санал болгосон. Үүний үр дүнд буюу том зургаар харвал бид ямар асуудалтай байгаа болон түүнийг шийдэх шаардлагатай байгаа тухай ерөнхий зураглалыг тоймлон хүргэж байна. Үүнд:

- Монгол Улсад 1992 оноос хойш хувийн хэвшлийн боловсрол сургалтын байгууллага байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж ирсэн боловч төрөөс баримтлах бодлого, зохицуулалт дутмаг, хөндлөнгийн хяналт харилцан адилгүй үр нөлөөтэй байгааг ижил түвшинд хүргэх, төрийн хяналт, зохицуулалтыг сайжруулах;
- Нийгмийн тэгш бус байдлыг боловсрол улам тэлдэг болов. Хувийн боловсролын байгууллагыг шууд хязгаарлахгүй, харин үе шатлах, төрийн зүгээс зохицуулах, боловсролоор ашиг олох буюу арилжааны шинж, зорилготой байхыг хориглох;
- Хувийн байгууллага гэдэг ашгийн бус ба ашгийн төлөө гэсэн 2 зорилготой. Боловсрол, эрүүл мэнд зэрэг нийтийн үйлчилгээг төр хүргэх үүрэгтэй. Боловсролын үйлчилгээ ашгийн төлөө байвал үр дагавар нь системийн ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлыг гааруулдаг тул боловсролыг ашгийн төлөө байхыг хориглох заалт Боловсролын ерөнхий хуульд тусгах;
- Аливаа улс орон боловсролын салбартаа нэг философи, нэг зорилго, нэг чиг, нэг тогтолцоо байх жишгийг чанд дагах;
- Ялгаатай хөтөлбөрүүдээр хичээллэж, Монгол Улсын хууль үйлчилдэггүй сургуулиудыг цэгцлэх, нэгдмэл стандарт хөтөлбөрөөр хичээллэх, хөтөлбөрийн хувьд ялгарах тохируулга хийхээр уян хатан байх;
- Минимум хөтөлбөрийн шаардлагатай байх, иргэн бүр үзэх ёстой агуулга байх;
- Үнэ төлбөргүй, заавал эзэмших түвшний боловсролын байгууллагыг ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглох;
- Боловсрол бараа, бүтээгдэхүүн болдог тул боловсролын салбарыг зах зээлийн өрсөлдөөний зарчмаас татгалзах тухай тусгах;
- Хувийн хэвшлийн боловсрол сургалтын байгууллагуудад төсвөөс санхүүжилт авсны хувьд үүрэг хүлээлгэх, ил тод, нээлттэй, эрх тэгш, хууль дээдлэн ажиллах, тэгш бус байдалд нөлөөлөхгүй байх талаар хариуцлага үүрүүлэх;
- Хувийн сургууль, цэцэрлэгүүд суудал хадгалах зорилгоор гэрээ байгуулаагүй ч төлбөрийн 50 хувийг урьдчилан авдаг. Гэрээ байгуулахад гэрээний нэг тал болсон эцэг эхчүүд эрх мэдэлгүй харилцдаг муу туршлага байна. Хуулиар эцэг эхчүүдэд эрх мэдлийг тэнцвэржүүлж өгөх;
- Бүх нийтэд боловсрол олгох, боловсролын салбар дахь хувийн хэвшлийн оролцоог зохицуулах тухай улсуудын хүлээх хүний эрхийн үүргийн

талаарх суурь зарчмуудыг бодлого боловсруулагчид судалж, ашиглах шаардлагатай.

- Нийгмийн цөөнх бүлэг (Казах, Тува зэрэг үндэстний цөөнх, сонсголын бэрхшээлтэй иргэд, олон соёлт гэр бүлд төрсөн хүүхэд гэх мэт) болон харилцан адилгүй чадвартай хүн бүрийг харгалзаж хоёр болон олон хэлийг бага ангиас нийгмийн бүлгийн соёлд ээлтэйгээр заах, түүнчлэн хоёр хэлээрээ бусад хичээлээ заах боловсролын хөтөлбөрийг эрчимжүүлэх;
- Бүх нийтийн ерөнхий боловсрол буюу 12 жилийн сургалт нь үнэ төлбөргүй байх ёстой. Үүнийг төр хариуцах бөгөөд үүнд харшлах, тэгш бус байдлыг улам даамжруулах элитист сургуулиудыг ердийн сургууль болгохоор хуульчлах;
- Дээд боловсрол нь хөрөнгө чинээ зэрэг ямарваа нэгэн гадуурхал үүсгэж болохгүй. Тухайн их дээд сургуулийн суралцагчид тавих шалгуурыг хангасан тохиолдолд сургалтын төлбөр нь гагцхүү суралцахад анхаарахуйц уян хатан, хүчрэхүйц, тэтгэлэг, дэмжлэгтэй байх;
- Ерөнхий боловсролыг зөвхөн жилийн эцсийн шалгалтаар үнэлэх; хямд муу барилгын материалаар сургууль босгох; хувийн жижиг сургуульд багш ажилд ирээгүй гэсэн шалтгаанаар хичээллэдэггүй гэх мэт асуудал түгээмэл ба боловсролын чанарт нөлөөлж байдаг. Иймд хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн олгож буй боловсролын чанарын талаарх мэргэжлийн хяналт шалгалттай болох ёстой. Хуулийн хэрэгжилтийг хянах үүднээс төрийн зүгээс болон боловсролын үр шимийг хүртэгч тал бүхий оролцогчийн зүгээс Хяналт мониторингийн механизм ажиллуулах ёстой.

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ

Тус хуулийн 18.3-т заасан “Боловсролын байгууллага нь ашгийн төлөө бус эсвэл ашгийн төлөө байж болно” гэснийг “Боловсролын байгууллага нь ашгийн төлөө бус байна гэж өөрчлөх” нь зүйтэй.

Боловсролын байгууллагын гол зорилго ашиг олох, хуримтлал үүсгэх байж яагаад ч болохгүй. Хүүхдийн боловсрол, хөгжил, төлөвшлөөр ашиг олохыг зөвшөөрөх ёсгүй. Сурч боловсрох эрхийн чиглэлээрх хүний эрхийн гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх учиртай.

Боловсрол ба ашгийн тухайд бид Абижаны зарчмыг зайлшгүй баримтлах шаардлагатай. **Бүх нийтэд боловсрол олгох, боловсролын салбар дахь хувийн хэвшлийн оролцоог зохицуулах тухай улсуудын хүлээх хүний эрхийн үүргийн талаарх суурь зарчмууд болох Абижаны зарчимд:** Боловсролд боломжит бүх нөөцөө дээд зэргээр зориулахдаа Улс орнууд сурч боловсрох эрхийг үр дүнтэй, нэн даруй хэрэгжлүүлэхдээ зохистой санхүүгийн болон бусад нөөцийг хуваарилах замаар үнэ төлбөргүй, бүх нийтийн, чанартай боловсрол олгохоо чухалчлах ёстой. Улсууд боловсролын төсвөө ямар нэгэн байдлаар бусад хэсэгт дахин хуваарилах, эсвэл зарцуулах нь үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролыг олгоход саад болохгүй байх ёстой гэжээ.

АБИЖАНЫ ЗАРЧМУУД

БҮХ НИЙТЭД БОЛОВСРОЛ ОЛГОХ, БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ УЛС ОРНУУДЫН ХҮЛЭЭХ ХҮНИЙ ЭРХИЙН ҮҮРГИЙН ТАЛААРХ СУУРЬ ЗАРЧМУУД (АБИЖАНЫ ЗАРЧМУУД)⁴³

Хураангуй

Арван тулгуур зарчим

Бүх нийтэд боловсрол олгох, боловсролын салбар дахь хувийн хэвшлийн оролцоог зохицуулах тухай улсын хүлээх хүний эрхийн үүргийн талаарх суурь зарчмууд нь 97 суурь зарчмаас бүрдэнэ. Энэхүү суурь зарчмуудын зэрэгцээ тулгуур шинжтэй 10 зарчмаас Абижаны зарчмын ерөнхий тойм, үзэл санааг харах боломжтой. Тус 10 зарчмыг Абижаны зарчмын бүрэлдэхүүн хэмээн харж, суурь зарчмуудтай нэгэн бүхэл хэмээн үзвэл зохино.

Нэгдүгээр тулгуур зарчим. Улс орнууд нь өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрийн сурч боловсрох эрхийг эрх тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийн хамт хүндэтгэж, хамгаалж, хангах ёстой.

Хоёрдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрд хүрч болох хамгийн дээд түвшний чанартайгаар үнэ төлбөргүй нийтийн боловсролыг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай боломжит бүх нөөцөө дээд зэргээр зориулан олгох ёстой.

Гуравдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь эцэг, эх эсвэл хууль ёсны асран хамгаалагчийн өөрийн хүүхдэд улсын боловсролын байгууллагаас өөр боловсролын байгууллага сонгох, мөн хувь хүн, этгээдийн зүгээс хүний эрхийн олон улсын эрх зүйн хүрээнд улс орнуудын хүлээсэн үүргийн дагуу тогтоосон стандартыг мөрдөж ажиллахыг шаарддаг хувийн боловсролын байгууллага байгуулах, удирдах эрх чөлөөг хүндэтгэх ёстой.

Дөрөвдүгээр тулгуур зарчим. Улс орнууд нь боловсролын салбарт хувийн хэвшлийн этгээд оролцож байгаа тохиолдолд сурч боловсрох эрхийн биелэлтийг хангах зорилгоор үр дүнтэй зохицуулалтыг батлах, мөрдөх зэрэг бүхий л зайлшгүй арга хэмжээг авах ёстой.

Тавдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь чанартай, үнэ төлбөргүй, бүх нийтэд зориулсан боловсролыг санхүүжүүлэх, хангахаа эн тэргүүнд эрэмбэлэх ёстой. Гагцхүү хүний эрхийн хэм хэмжээ, жишигтэй нийцэж байгаа тохиолдолд аливаа заавал биелүүлэх, журамласан, үйл ажиллагааны шаардлагыг хангасан үед л хууль ёсны хувийн шинжтэй хичээл заадаг боловсролын байгууллагыг

43 The guiding principles on the human rights obligations of states to provide public education and to regulate the private sector's involvement in education (Abidjan principles)

Дэлхийн өнцөг булан бүрээс мэргэшсэн шинжээчдийн ажлын хэсэг 2018 онд ажиллаж, тус зарчмыг 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Зааны Ясан Эрэг Улсын Абижан хотноо баталсан юм.

www.AbidjanPrinciples.org #AbidjanPrinciples линкээс дэлгэрэнгүйг үзнэ үү.

шууд болон татвараас хөнгөлөх, газар ашиглуулах, олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа зэрэг шууд бус төрөл бүрийн хэлбэрээр санхүүжүүлж болно.

Зургаадугаар тулгуур зарчим. Олон улсын туслалцаа, хамтын ажиллагааг үнэ төлбөргүй, чанартай, улсын буюу бүх нийтэд зориулсан боловсролын тогтолцоогоо бэхжүүлэхэд зориулах бөгөөд хүний эрхэд халдсан хувийн боловсролын байгууллагыг шууд болон шууд бусаар дэмжихийг таслан зогсоох ёстой.

Долоодугаар тулгуур зарчим. Улс орнууд нь сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах өөрийн үүргээ, тэр дундаа боловсролын салбар дахь хувийн хэвшлийн оролцоог зохицуулах үүргээ ч хариуцлагатай биелүүлэхэд чиглэсэн зохистой механизмыг бүрдүүлэх ёстой.

Наймдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь сурч боловсрох эрхийг хэрхэн эдлүүлж, мөн хүний эрхийн зарчимд нийцүүлэн бүхий л бодлогоо боловсруулж, бодитой хэрэгжүүлж байгааг баталгаажуулах үүднээс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагыг тогтмол хянаж үнэлэх ёстой.

Есдүгээр тулгуур зарчим. Улс орнууд нь сурч боловсрох эрх зөрчигдсөн, боловсролын салбар дахь хувийн хэвшлийн этгээдийн зүгээс ямарваа нэгэн хүний эрхийн зөрчил гаргасан тохиолдолд үр дүнтэй байдлаар эрхийг сэргээж, учирсан хохирлыг барагдуулах боломжийг бүрдүүлэх ёстой.

Аравдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь шаардлагатай хууль зүйн болон төсвийн шинэчлэл эхлүүлэх, хийх зэргээр бүхий л арга хэмжээг авч, эдгээр суурь зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлэх үйл явцыг баталгаажуулах ёстой.

БҮХ НИЙТЭД БОЛОВСРОЛ ОЛГОХ, БОЛОВСРОЛЫН
САЛБАР ДАХЬ ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦООГ
ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ УЛС ОРНУУДЫН ХҮЛЭЭХ
ХҮНИЙ ЭРХИЙН ҮҮРГИЙН ТАЛААРХ СУУРЬ
ЗАРЧМУУД (АБИЖАНЫ ЗАРЧМУУД)⁴⁴

Дэлгэрэнгүй

Оршил

Сурч боловсрох эрх нь хүний эрх төдийгүй хүнийг мэдэлжүүлж, боломж, нөхцөлийг улам тэлж, хувирган өөрчилдөг эрх билээ. Тус эрхийн хүрээнд боловсрол олж авах эрх, боловсрол дахь эрх, боловсролоор олж авах эрхийг хөнддөг. Боловсрол хувь хүний бие махбод, сэтгэц, оюун санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд, мөн хүний эрхийг хүндэтгэхийн хамт эцэг, эх, гэр бүл, нийгмийн бүлгүүдийн зүгээс нийгмийн болон соёлын үнэт зүйлсээ дамжуулах, дадуулахад тулгын чулуу мэт үүрэг гүйцэтгэдэг. Үүний зэрэгцээ

44 Хүний эрхийн Үндэсний Комисс; (орч. Хүний эрхийн шинжээч Б.Болорсайхан), Бүх нийтэд боловсрол олгох, боловсролын салбар дахь хувийн хэвшлийн оролцоог зохицуулах тухай улс орнуудын хүлээх хүний эрхийн үүргийн талаарх суурь зарчмууд, Хүний эрх: онол, арга зүйн сэтгүүл. №1 (57). 2021.

боловсролоор дамжуулан нийтийн сайн сайхныг бүрэлдүүлж, эрүүл, нээлттэй, ил тод, хүлээцтэй, шударга, үл ялгаварласан тэгш хамруулсан нийгмийг цогцлоох, хадгалах, тус нийгэм нь эргээд хүний эрхийг эдлүүлэх таатай орчин болж хувирахад хувь нэмэр оруулдаг. Ялангуяа боловсрол нь уугуул, охид, эмэгтэйчүүд, цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл ядуу хүмүүс гэх мэт эмзэг, эрх мэдэлгүй удаан хугацаанд гадуурхагдсан, боломжоос ангид нийгмийн бүлгүүдэд амин чухал хэрэгцээтэй гэж болно.

Хүний эрхийн олон улсын эрх зүйгээр улс орнуудыг чанартай байдлаар бүх нийтэд боловсрол олгохыг шаардахын хамт хувийн хэвшлийн этгээд боловсролын боломжит хувилбар санал болгох боломжийг олгодог. Улс орнуудаас сурч боловсрох эрхийг дордуулахгүйгээр боловсролын салбарт хувийн хэвшил хэрхэн оролцох ёстойг нарийвчлан чанд зохицуулахыг шаарддаг онцлогтой. Хувийн хэвшил боловсрол олгохдоо боловсролын стандартыг хангахын зэрэгцээ боловсрол олгогч этгээд гэсэн төрийн үүргийг өөртөө наах, авах, нэг бол тэгш бус, эсвэл шударга бус явдлыг гааруулахгүй байж, эн тэргүүнд үр шим хүртэгч этгээд нь хувийн хэвшлийн боловсрол олгож байгаа этгээд байна гэдгийг цаг ямагт анхаарвал зохино. Төрийн зүгээс улсын хэмжээнд нийтийн боловсролын тогтолцоог бэхжүүлэх, тэгш бус байдлыг улам өдөөхүйц байдлаар тогтолцоог задлахын эсрэг ажиллах ёстой.

Гэсэн хэдий ч улс орнууд чанартай боловсролыг бүх нийтэд олгох, хувийн хэвшлийн этгээдийн зохицуулахад бэрхшээлтэй тулгарч, заримдаа олон улсын санхүүгийн байгууллагын шахалтын улмаас боловсролын салбар дахь хувийн хэвшлийн оролцоо тэлэх хандлагатай байна.

Боловсролын салбарт оролцож буй хувийн хэвшлийн этгээд бүр харилцан адилгүй. Хувиараа боловсрол олгогч нь итгэл үнэмшилд суурилсан, шашны үнэт зүйлстэй, орон нутгийн жижиг сургуулиас эхлэн улам идэвхтэй оролцож буй үндэстэн дамнасан компаниуд гэх мэт томоохон тоглогчид бий. Түүнчлэн нэмэлт үйлчилгээ, шалгалт, сургалтын хөтөлбөр, боловсрол санхүүжүүлэх үйлчилгээ санал болгодог хувийн хэвшлийн этгээд ч байдаг. Зарим этгээд чанартай, нийтийн боловсрол олгоход төрийг дэмжиж, сурч боловсрох эрхийг эдлүүлэхэд эерэг нөлөөтэй ажилладаг. Бусдын тухайд гол төлөв арилжааны шинжтэй этгээдийн хувьд боловсролыг зах зээлийн бараа бүтээгдэхүүн гэж хардаг, түүгээрээ сурч боловсрох эрхийг эдлүүлэхэд саад болдог ажээ.

Дээр дурдсан бэрхшээлийг даван туулахын тулд хүний эрхийн байгууллага, шүүхээс бодит амьдралд тулгарч буй хүндрэл, саадтай орчин нөхцөлд сурч боловсрох эрхийг хэрхэн биелүүлэх талаар тодорхойлж, тайлбарлаж шийдвэр гаргасан байна. Уг суурь зарчмуудаар дамжуулан хүний эрхийн олон улсын гэрээний агуулгатай нийцүүлэн улс орнууд холбогдох этгээд нөхцөл байдлыг хэрхэн өөртөө нааштай байдлаар залах, ажиллахад туслахыг зорьсон юм. Нэг талаас хууль эрх зүйн хүрээгээ боловсруулахдаа заавал тусган харах байр суурь болохын хамт хүний эрхийн эрх зүйн дагуу сурч боловсрох эрхийг баталгаажуулахын тулд улс орнуудын хүлээж буй үүргийг дахин онцолж

байна. Нөгөө талаас тэгш байдал, хүний эрхэм чанар, нийгмийн шударга ёсыг баталгаажуулдаг чанартай боловсролын тогтолцоог хөхиүлэн дэмжиж байна. Энэхүү баримт бичгийг ямар нэгэн байдлаар боловсрол дахь хувийн хэвшлийн оролцоог сайшаасан, эсвэл боловсрол дахь зүй ёсны эрх чөлөөг нухчин дарсан гэж харахгүй байх нь зүйтэй.

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

а. Хүрээ, тодорхойлолт, хэрэглээ, тайлбар:

Хүрээ

1. Энэхүү суурь зарчмууд нь боловсрол дахь хувийн хэвшлийн этгээдийн оролцоог зохицуулахдаа мөрдөх хүний эрхийн хэм хэмжээ, жишгийг агуулсан болно.

Тодорхойлолт

2. Бүх нийтэд боловсрол олгох тогтолцоо нь улсаасаа хамаарч өөр байна. Тус баримт бичгийн тухайд бүх нийтэд боловсрол олгох байгууллага гэдэгт:

- а. Улсын буюу нийтийн боловсролын байгууллага гэж төрөөс хүлээн зөвшөөрсөн;
- б. Төр эсвэл хүн амын зүй ёсны төлөөллийн зүгээс нийтэд үйлчлэх зорилгоор үр дүнтэй хянаж, удирддаг;
- в. Суралцагчдын сурч боловсрох эрхийг доройтуулахуйц ямарваа нэгэн арилжааны эсвэл шулах, мөлжих ашиг сонирхол агуулсан үйлчилгээ үзүүлдэггүй байхыг ойлгоно.

3. Боловсролын байгууллага нь эдгээр нэгдсэн шинжийг агуулаагүй тохиолдолд “хувийн” гэж тус баримт бичигт тодорхойлно. Үүнд:

- а. Боловсролын үйлчилгээ шууд үзүүлж байгаа хичээл заадаг боловсролын байгууллага, боловсролын үйлчилгээ үзүүлэхдээ хичээл заахгүйгээр боловсролын үүрэг гүйцэтгэдэг хувийн байгууллага;
- б. Арилжааны болон арилжааны бус этгээд.

Хэрэглээ, тайлбар

4. Энэхүү суурь зарчмуудыг улс орнуудын өөрийн нутаг дэвсгэрт төдийгүй нутаг дэвсгэрийн гадна иргэний, соёлын, эдийн засгийн, улс төрийн, нийгмийн зэрэг хүний бүх эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэгтэй уялдуулан хэрэглэж, тайлбарлана.

5. Сурч боловсрох эрхийг хүндэтгэх төрийн үүргийг биелүүлэх нь хүний бусад эрхийг эдлүүлэх үүрэг, мөн олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, олон улсын дүрвэгсдийн эрх зүй, олон улсын эрүүгийн эрх зүй гэх мэтчилэн олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхтэй цогц байдлаар уялдах ёстой.

6. Энэхүү суурь зарчмуудыг олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, жишгээр хүлээн зөвшөөрсөн эрхүүд эсвэл олон улсын хүний эрхийн хэм хэмжээтэй нийцсэн дотоодын хууль тогтоомж, түүгээр баталгаажуулсан

эрхийг хязгаарлах, хорих, бусад байдлаар дордуулах зорилгоор тайлбарлах, эсвэл ашиглах ёсгүй.

7. Олон улсын болон Үндсэн хууль, үндэсний хууль тогтоомж, хэм хэмжээ, нэг бол хүний эрхийн олон улсын хэм хэмжээтэй уялдуулсан жишгийг дотроо агуулсан хүний эрхийн хэм хэмжээ, жишгийн дагуу улс орнууд, олон улсын байгууллага, үндэстэн дамнасан корпораци, бизнесийн бусад байгууллага зэрэг хувийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагыг хязгаарлах, хорих, бусад байдлаар дордуулах зорилгоор суурь зарчмуудын аль нэгэн заалтыг тайлбарлах ёсгүй.

6. Сурч боловсрох эрхийн мөн чанар, хүрээ:

8. Аливаа хэлбэрийн боловсрол нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр баталгаажуулсан боловсролын зорилго, зорилт руу чиглэх ёстой. Үүнд боловсрол хүний хувийн зан чанарыг бүхэлд нь бүрэн хөгжүүлэх, эрхэм чанараа ухамсарлахад чиглэж, хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх хамаарна. Мөн хувь хүн нийгэмдээ идэвхтэй оролцох, хүлээцтэй байх, хамтдаа амьдрах, биеэ дааж өөрийн болон хамтын амьдралын төлөвлөгөөгөө гаргах, хэрэгжүүлэх чадавхтай, шүүн тунгаадаг болоход боловсрол чиглүүлнэ.

9. Сурч боловсрох эрх нь төрсөн цагаас эхлэн амьдралын туршид үргэлжилнэ. Хүн бүр сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсрол, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт, насанд хүрэгчдийн боловсрол, албан болон албан бус боловсрол гэх мэт төрөл бүрийн хэлбэрээр түвшин бүрд хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, цаг үетэйгээ зохицсон насан туршийн боловсрол эзэмших эрхтэй. Үүнд хүний эрхийн олон улсын хэм хэмжээний дагуу төрийн хүлээх үүрэгт тусгайлан зааж, заавал эдлүүлэхийг шаарддаг үнэ төлбөргүй сурч боловсрох эрх ч багтана.

II. БОЛОМЖИТ БҮХ НӨӨЦӨӨ БҮРЭН ДАЙЧЛАХ ЗАМААР СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХ, ХАМГААЛАХ, ХАНГАХ ҮҮРЭГ

Нэгдүгээр тулгуур зарчим. Улс орнууд нь өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрийн сурч боловсрох эрхийг эрх тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийн хамт хүндэтгэж, хамгаалж, хангах ёстой.

A. Сурч боловсрох эрхийг эдлүүлэх үүрэг

10. Улс орнууд нь өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрийн сурч боловсрох эрхийг эрх тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийн хамт хүндэтгэж, хамгаалж, хангах ёстой.

11. Улс орнууд нь боловсролд хувийн хэвшлийн этгээд оролцсон зэрэг аливаа нөхцөлд сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах өөрийн үүргээ хадгална.

12. Онц байдал, зэвсэгт мөргөлдөөний үед ч сурч боловсрох эрхийг баталгаатай эдлүүлнэ.

13. Улс орнууд нь төр, хувийн хэвшлийн гэсэн боловсролын бүх байгууллагын зүгээс хүн бүрийг тэгш хамруулсан, наад зах нь шаардлага

хангасан чанартай байхыг баталгаажуулах ёстой.

14. Аливаа хэлбэрийн бүх түвшний боловсрол нь чанартай боловсролыг бүрэн илэрхийлэхүйц дараах харилцан холбоо бүхий, зайлшгүй байх шинжийг агуулна. Үүнд:

а. Хүрэлцээтэй байх.

- i. Хангалттай тооны үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллага, ашиглахуйц хөтөлбөртэй байх;
- ii. Шаардлагатай ур чадвар, мэргэшил бүхий, сургалтад суусан, дотооддоо өрсөлдөхүйц цалин хөлстэй багшлах болон бусад ажилтан хангалттай тоогоор байх;
- iii. Шаардлага хангасан сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх материал, арга зүй, туршлагатай байх;
- iv. Зохистой ариун цэврийн байгууламжтай байх;
- v. Аюулгүй ундны устай байх;
- vi. Аюулгүй, шаардлага хангасан, байнга засаж торддог дэд бүтэцтэй байх;
- vii. Аюулгүй, хамгаалагдсан суралцах орчинтой байх;
- viii. Боломжтой тохиолдолд номын сан, компьютерын, мэдээллийн технологитой байх;
- ix. Ажилтан бүр зохистой ажлын байр, хөдөлмөрлөх нөхцөл, нийгмийн хамгаалалтай байх.

б. Хүртээмжтэй байх. Боловсролын байгууллага, хөтөлбөр нь тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа хүн нэг бүрд ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүй хүртээмжтэй байна. Хүртээмж гэдэгт материаллаг, эдийн засгийн, мэдээллийн хүртээмж багтана.

в. Хүлээн зөвшөөрөгдсөн байх. Үүнд ялангуяа боловсролын хэлбэр, сургалтын хөтөлбөр, багшлах арга зэрэг бүрэлдэхүүн нь суралцагчид, боломжит нөхцөлд эцэг, эх, асран хамгаалагчид хүлээн зөвшөөрөхүйц байж, олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр баталгаажуулсан зорилго, зорилтыг чиглэвэл зохино. Сургалтын хөтөлбөр нь хэвшмэл ойлголтоос ангид гэх мэт хүний эрхтэй нийцсэн байна.

г. Цаг үетэйгээ зохицсон байх. Боловсрол нь тэр дундаа өөрчлөгдөж буй нийгэм, бүлгийн хэрэгцээг даган өөрчлөхүйц уян хатан байж, ялгаатай нийгэм, соёлын үндэс бүхий бүлгийн суралцагчдын хэрэгцээнд нийцүүлсэн байна.

15. Улс орнууд нь үнэ төлбөргүй, чанартай боловсролыг баталгаажуулан өөрийн боломжит нөөцийг бүрэн дайчлах замаар хуваарилах, үүнтэй зэрэгцэн боловсрол тасралтгүй сайжрах ёстой. Хамгийн боломжит нөөцийг хөгжлийн зорилгод заасан дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь зэрэг дотоодын эсвэл олон улсын боловсролыг санхүүжүүлэх санаачилгад заасан түвшнээс бууруулж болохгүй.

16. Боломжит нөөц гэдэгт төр захиран зарцуулах эсвэл дайчлах боломжтой бүхий л нөөцийг ойлгоно. Үүнд:

- а. Худалдааны, шаталсан татвар, дотоодын бусад орлого бий болгох механизмууд зэрэг гол төлөв дотоодын эх үүсвэр; төсвийн орлогын суурийг тэлэх; төсвийн зардлыг дахин хуваарилах; хориотой санхүүгийн урсгал, авлига, татвараас зайлсхийх, татвараа нуун дарагдуулах явдлыг устгах; татварын болон гадаад валютын нөөц ашиглах; зээлж авч эсвэл авсан зээлийн өрөө дахин хуваах замаар удирдах; зээл авах макро эдийн засгийн хүрээг боловсруулах, батлах;
- б. Олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа.

17. Улс орнууд нь сурч боловсрох эрхийг эдлүүлэх үүргийг хүлээхдээ дараах нөхцөлийг эн тэргүүнд анхаарна. Үүнд:

- а. Үнэ төлбөргүй, чанартай, нийтийн сургуулийн өмнөх боловсролын нөхцөл;
- б. Үнэ төлбөргүй, чанартай, нийтийн суурь, бүрэн боловсролыг хүн бүрд олгох нөхцөл;
- в. Сурч боловсрох хэрэгцээтэй хүүхэд, залуус, ялангуяа өөрийн амьдран буй нийгэмдээ болон хөдөлмөрийн зах зээлд бүрэн дүүрэн, идэвхтэй оролцох хангалттай түвшний чадвар, туршлагагүй хүмүүсийн боловсрол эзэмших боломж;
- г. Ялгаварлан гадуурхалтыг бүрэн устгах, боловсрол дахь чанарын баталгаа, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүн зэрэг үндэслэлээр хэн ч боловсрол эзэмшихгүй гадна үлдэхээс сэргийлж, боломжит хэрэглэгдэхүүнээр баталгааг хангасан байдал;
- д. Заавал эзэмших боловсролын хугацаа багадаа есөн жил байх шаардлага;
- е. Боловсрол дахь хувийн хэвшлийн этгээдийн оролцооны талаарх үр дүнтэй зохицуулалтыг батлах, мөрдөх ажиллагаа;
- ё. Бүх түвшинд үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсрол олгох асуудлыг багтаасан боловсролын талаарх үндэсний стратегиа нарийвчлан батлах, хэрэгжүүлэх ажиллагаа.

18. Улс орнууд наад зах нь гэрээний дагуу хүлээсэн гол үүргээ биелүүлэх ёстой. Тухайн улсын зүгээс боломжит нөөцгүйн улмаас сурч боловсрох эрхийг эдлүүлэх гол үүргээ биелүүлж чадаагүйг нягтлан үздэг байхын тулд нийтэд илээр зарцуулж болох бүх нөөцөө өөрийн гол үүргээ биелүүлэхдээ зарцуулахаар бүх талаар хичээж зүтгэх ёстой.

19. Улс орнууд нь нийтийн алба хэмээн боловсролыг баталгаажуулах ёстой ба хичээл заадаг хувийн боловсролын байгууллагад ч гэсэн нийтийн албаны үүргийг ногдуулна.

20. Улс орнууд нь боловсролын үйлчилгээ, удирдлагадаа хүний эрхэм чанар, оролцоо, тэгш байдал, үл ялгаварлал, тэгш хамрах явдал, ил тод байдал, эгэх хариуцлагын зарчмыг мөрдөх ёстой.

21. Улс орнууд нь бүх түвшинд, бүх насныханд сурч боловсрох эрхийг эдлүүлэхийн тулд боловсролын талаарх үндэсний нарийвчилсан стратегиа боловсруулах, батлах ёстой. Үүнийг шууд биелүүлэх үүрэг хүлээнэ. Боловсролын талаарх үндэсний стратеги нь:

- а. Хамгийн багадаа шалгуур үзүүлэлт, хүрэх зорилт, хэмжүүртэй байх; хүрэхийн тулд санал болгож буй арга зам, зорилтдоо хүрэх цаг хугацааг нарийвчлах; хэрэгжүүлэх гол этгээдийг тодорхойлох; зардлыг тусгаж, төсөвлөсөн байна. Зорилт, хэмжүүр нь өөрийн боломжит нөөцийг бүрэн зарцуулах төрийн үүрэг; гол үүрэг; хүний эрхийн талаарх бусад үүрэгтэй уялдсан байхын хамт олон улсын амлалттай ядаж л нийцсэн байх ёстой;
- б. Ил тод, оролцоог хангасан байдлаар хүүхэд, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, нийгмийн бүлэг, багшлах болон багшилдаггүй ажилтан, боловсролын үйлдвэрчний эвлэл, иргэний нийгмийн бусад байгууллага зэрэг бүх сонирхогч талын бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоонд тулгуурлан боловсруулна;
- в. Нийгэм дэх эмзэг, удаан хугацаанд эрх мэдэлгүй ялгаварлан гадуурхагдсан, боломжоос ангид бүлгийн сурч боловсрох эрхээ эдэлж буй түвшинд үнэлэх, чиглэхэд тусгайлан анхаарал хандуулна;
- г. Жендэрийн мэдрэмжтэй, охид эмэгтэйчүүдийн хэрэгцээнд хариу хандсан, хүн бүрийг хувирган өөрчлөх шинжтэй байна;
- д. Энгийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг тэгш хамруулах зэрэг гадуурхах, тусгаарлахыг эцэслэх, хүн бүрд тэгш хамруулах боловсрол олгох явдлыг баталгаажуулах зорилгоор ямарваа тогтолцооны шинэчлэлийн үйл явцын нэг хэсэг гэж ямар арга хэмжээг харахаа цаг хугацаа, хэмжүүр, шалгуур үзүүлэлтийн хамт нарийвчилна.

Олон улсын байгууллага

22. Олон улсын байгууллагын гишүүний хувиар улс орнууд өөрийн хүний эрхийн талаар хүлээдэг үүрэгтэй холбогдуулан хийж буй үйл ажиллагаагаа хариуцна. Төр олон улсын санхүүгийн байгууллага, дэлхийн сан зэрэг олон улсын байгууллагад ордог эсвэл өөрийн чадамжаа шилжүүлдэг бол тухайн улсын олон улсын хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгтэй нийцүүлж холбогдох байгууллагууд ажиллахыг баталгаажуулахад чиглэсэн бүхий л шаардлагатай арга хэмжээг авах ёстой. Тодруулбал:

- а. Олон улсын байгууллага нь энэхүү зарчимд нийцүүлэн сурч боловсрох эрхийг эдлүүлэлгүй үгүйсгэх эсвэл саад учруулахгүй байгааг баталгаажуулахын тулд түүний бодлого, эс үйлдэхүй, бусад үйлдэл зэргийг цаг ямагт хянан шинжлэх;
- б. Энэхүү зарчимд тусгасан төдийгүй хүний эрхийн бусад хариуцлагаа биелүүлэх хүлээн авагч улсын чадамжийг үгүйсгэх, эсвэл саад учруулахуйц бодлого тулгах, нэг бол санал өгөхийг зогсоох, шаардлагатай тохиолдолд үүнээс зайлсхийхийн тулд шаардлагатай бүх

арга хэмжээг авах;

- в. Тухайн байгууллага дотор үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролын тогтолцоо хөгжүүлэх үүрэг хариуцлага зэрэг энэхүү зарчимд тусгасан хариуцлагыг оролцуулан сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах улс орнуудын хариуцлагатай уялдсан бодлогыг хөхиүлэн дэмжих.

Б. Боловсрол дахь тэгш байдал, үл ялгаварлал

Тэгш байх эрх

23. Улс орнууд сурч боловсрох эрхийг эдлүүлэхдээ тэгш байх эрхийг дараах хэмжигдэхүүнд баталгаатай эдлүүлэх ёстой. Үүнд:

- а. Нийгэм-эдийн засгийн сул талд чиглэсэн шударгаар нөхөн сэргээх хэмжигдэхүүн;
- б. Стигма, хэвшмэл ойлголт, ухвар мөчид төсөөлөл, хүчирхийлэлтэй тэмцэх, хүний эрхэм чанар болон ялгаварлан гадуурхалтын харилцан адилгүй шалтгаанд хамаарах дамнасан нөлөөт байдлыг хүлээн зөвшөөрөх хэмжигдэхүүн;
- в. Ялгааг хүний эрхэм чанарын асуудал хэмээн тодорхойлж, тогтолцоог өөрчлөх нөхцөл бүрдүүлдэг хувирган өөрчлөх хэмжигдэхүүн.

Ялгаварлан гадуурхахгүй байх эрх

24. Улс орнууд сурч боловсрох эрхийг эдлүүлэхдээ нас, төрсөн байдал, каст, өнгө, удам, хөгжлийн бэрхшээл, баримт бичиг, угсаа, иргэний, гэр бүлийн, карьерын байдал, жендэрийн илэрхийлэл, эрүүл мэндийн байдал, эсвэл удамшил, нэг бол бусад өвчнөөр хажиглах, хэл, шилжин суурьшсан байдал, үндэсний эсвэл нийгмийн гарал, иргэний харьяалал, улс төрийн болон бусад байр суурь, эцэг, эх болсон, жирэмсэн, өмч, арьс үндэс, шашин, бэлгийн чиг баримжаа, нийгэм-эдийн засгийн сул тал, харьяалалгүй байх, эсвэл бусад байдал зэрэг ямарваа нэгэн шинжээр ялгаварлан гадуурхахыг арилгах ёстой. Аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох үүрэг гэдэгт шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах, дарамтлах, тохирох хэрэглэгдэхүүнийг үгүйсгэх, мөн хавсарсан, дамнасан нөлөөт, гагцхүү өөрт нь хамаарах шинжээр, нэг бол цочир ялгаварлан гадуурхах хүртэл багтана.

Улс орнуудын үүрэг

25. Улс орнууд өөрийн хууль тогтоомж, бодлого, туршлагадаа боловсролоор шууд эсвэл шууд бусаар ялгаварлан гадуурхахгүй байхыг баталгаажуулах ёстой. Мөн сурч боловсрох эрхэд хамаарах тэгш байх, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийг зөрчсөн бүхий л тохиолдолд улс орнуудын үйлдлээс үүдэлтэй нөхцөл байдал эсэхээс үл хамааран анхаарч ажиллавал зохино. Үүнд доорх нөхцөл ч багтана:

- а. Ядуу эсвэл орон нутагт амьдарч байгаа хүмүүс зэрэг нийгэм дэх зарим бүлэгт харилцан адилгүй боловсрох боломж эсвэл үр дүнг тогтолцоо тэгш бусаар олгох;
- б. Ямарваа нэгэн нөхцөлөөр, тэр дундаа нийгэм-эдийн засгийн сул

талд тулгуурлан ялгаварлан гадуурхаж, боловсролын тогтолцоонд тусгаарлах.

26. Улс орнууд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг арилгах, сэргийлэх, нөөц хуваарилах замаар түүхэн шинжтэй ялгаварлан гадуурхсан, тэгш бус байдал, тогтолцооны шинжтэй, урт удаан үргэлжилсэн сул талыг засах, сурч боловсрох эрхийг эдлүүлэхэд тэгш байдлыг хангахад чиглэсэн эерэг алхам хийх ёстой. Тухайн арга хэмжээ нь үндэслэлтэй, объектив, тохирсон байхын зэрэгцээ:

- а. Ялгаварлан гадуурхсан туршлагыг таних, түүнээс сэргийлэх;
- б. Боловсролын үүрэг гүйцэтгэдэг байгууллага зэрэг гуравдагч этгээдийн зүгээс хувь хүнийг ялгаварлан гадуурхахаас хамгаалах;
- в. Ямарваа нэгэн шинжид тулгуурласан ялгаварлан гадуурхалтгүйгээр чанартай, тэгш хамруулсан боловсролыг тэгш хүртэх боломжийг хүн бүрд баталгаажуулах;
- г. Ялгаварлан гадуурхахаас сэргийлэх, тэгш байдлыг баталгаажуулахаар нийтийн, хувийн байгууллагыг оролцуулан өөрийн боловсролын тогтолцоогоо зохион байгуулах.

27. Боловсрол дахь ялгаварлан гадуурхалт нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд үүнийг улс орнууд аль болох хамгийн хурднаар арилгахын тулд боловсрол болон бусад хамаарах салбарт үр дүнтэй бүх арга хэмжээг даруй авах ёстой. Тус үүргийг төрийн зүгээс шууд ялгаварлан гадуурхаж үйлдсэн эсэхээс үл хамааран гүйцэтгэнэ.

Тохирох хэрэглэгдэхүүн

28. Улс орнууд сургалтын хөтөлбөр, суралцах орчин, анги доторх харилцаа холбоо, заах аргазүйн материал, үнэлгээ зэргийг хамруулан нэг эсвэл олон шинжээр ялгаварлан гадуурхахуйц хувь хүний харилцан адилгүй чадамжид зориулан боловсрол дахь тохирох хэрэглэгдэхүүнийг баталгаажуулах ёстой. Тохирох хэрэглэгдэхүүнийг баталгаажуулж чадаагүйн улмаас ялгаварлан гадуурхалт үүсдэг бөгөөд тохирох хэрэглэгдэхүүнээр хангах үүргээ даруй биелүүлвэл зохино.

Хоёрдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрд хүрч болох хамгийн дээд түвшний чанартайгаар үнэ төлбөргүй нийтийн боловсролыг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай боломжит бүх нөөцөө дээд зэргээр зориулан олгох ёстой.

В. Үнэ төлбөргүй, чанартай, нийтээрээ сурч боловсрох эрх

29. Улс орнууд үнэ төлбөргүй, чанартай, нийтээрээ сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах ёстой. Мөн өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрд хүрч болох хамгийн дээд түвшний чанартайгаар үнэ төлбөргүй нийтийн боловсролыг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай боломжит бүх нөөцөө дээд зэргээр зориулан олгох ёстой. Хувийн боловсролын байгууллагыг оролцуулах нь энэ үүрэгт ямар нэгэн байдлаар нөлөөлөх буюу үгүйсгэхгүй.

30. Нийтийн боловсрол дахь стандарт нь хүрч болох хамгийн дээд түвшний

чанарыг баталгаажуулах, хүний эрхийг хамгаалахуйц шинжтэй, Дөрөвдүгээр зарчимд жагсаасан хичээл заадаг хувийн боловсролын байгууллага ч ашиглах стандарт байна. Улс орнууд боломжит бүх нөөцөө бүрэн дайчлах замаар сурч боловсрох эрхийг дэвшилттэйгээр биелүүлэх өөрийн үүрэг хариуцлагад нийцүүлэн тасралтгүйгээр нийтийн боловсрол дахь стандартыг дээшлүүлнэ.

31. Улс орнууд нийтийн боловсролд тэгш хамруулдаг байх ёстой. Цөөнх, уугуул хүмүүс зэрэг нийгмийн харилцан адилгүй бүлгийн соёлын, хэлний, бусад ялгарах шинжийг аль болох өргөнөөр нийтийн боловсролд багтааж, боловсролын зорилго, олон улсын хүний эрхийн хэм хэмжээний бусад стандарттай зөрчилдөхгүй байвал зохино. Нийтийн боловсрол нь боловсролд олон ургалч байдлыг бүрдүүлэх боломжийг хангах, соёлын хувьд тохиромжтой байх, суралцагч өөрийн хувийн онцлог шинж, соёлын илэрхийллээ хөгжүүлэх, өөрийн харьяалагдаж буй хүй олон, бусад бүлэг, нийгмийн соёлын үнэт зүйлс, туршлагыг ойлгох, сурах боломжтой байх ёстой. Сургалтын хөтөлбөр дэх мэдээлэл эсвэл мэдлэг нь объектив, шүүн тунгаасан, олон ургалч шинжтэй байна.

32. Улс орнууд нь нийтийн боловсролыг эгэх хариуцлагатай, оролцоот, тэгш хамруулсан, ил тод байлгах ёстой. Ялангуяа улс орнууд хүүхэд, бусад суралцагч, эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамт олон, багшлах болон багшилдаггүй ажилтан, боловсролын эвлэл, иргэний нийгмийн бусад байгууллага зэрэг бүх оролцогч талыг оролцуулан засагладаг боловсролын тогтолцоог бий болгох ёстой.

33. Улс орнууд ямарваа нэгэн ялгаварлан гадуурхалт, эсвэл тусгаарлалтгүйгээр хүн бүрийн нийтийн боловсролтой байх адил тэгш эрхийг баталгаажуулахын тулд чанартай нийтийн боловсрол эзэмших хүртээмжийг тодорхойлогч асуудалд чиглэсэн үр дүнтэй бүх арга хэмжээг авах ёстой. Үүнд хөдөлмөрлөх, нийгмийн хамгаалалтай байх, хүнс, орон сууцаар хангагдах, эрүүл мэндээ хамгаалуулах, ус, ариун цэврийн байгууламжтай байх эрх зэрэг эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад чиглэсэн үр дүнтэй бүх арга хэмжээг авах хүртэл багтана. Эдгээр арга хэмжээ нь орон сууцны бодлого; дэд бүтэц төлөвлөлт; зохистой хоол хүнстэй байх боломж; нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэх хөтөлбөр; гэрлэх насны доод хязгаарыг 18 насанд тооцсон хууль тогтоомж; хүүхдийн хөдөлмөрөөс сэргийлсэн бодлого; хэвшмэл ойлголт, ухвар мөчид төсөөлөлд хүргэдэг нийгэм, соёлын загварыг өөрчлөх арга хэмжээ; хүний бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн хүрч болох хамгийн дээд түвшинд хүргэх арга хэмжээ зэргийг улам хүнээ тэгш хамруулсан болгох боломжтой.

Д. Нийтийн боловсролыг санхүүжүүлэх нь

34. Боловсролд боломжит бүх нөөцөө дээд зэргээр зориулахдаа улс орнууд сурч боловсрох эрхийг үр дүнтэй, мөн чадах хэрээр түргэн шуурхай биелүүлэхдээ зохистой санхүүгийн болон бусад нөөцийг хуваарилах замаар чанарын дээд түвшинд үнэ төлбөргүй, нийтийн боловсрол олгохоо чухалчлах ёстой. Улс орнууд өөрийн боловсролын төсвөө ямар нэгэн байдлаар бусад

хэсэгт дахин хуваарилах, эсвэл зарцуулахдаа үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролыг олгоход саад болохгүй байх ёстой.

35. Улс орнууд дотоодын төсвийн хууль тогтоомж, эсвэл бодлогодоо тохирох байдлаар нийтийн боловсролд хүний эрхэд нийцсэн боловсролын санхүүжилтийг оруулах ёстой. Улс орнуудын боловсролын үндэсний стратегиуд нь хүрч болох дээд түвшний чанартайгаар үнэ төлбөргүй, нийтийн боловсролыг олгох өөрийн үүргээ үйл ажиллагаандаа доорх замаар тусгах ёстой. Үүнд:

- а. Нийтийн боловсрол дахь зорилт, хэмжүүр, заасан хугацааны доторх ахиц дэвшлээ нягтлах шалгуур үзүүлэлт зэргийг оролцуулан хангалттай тусгайлсан, тодорхой байх;
- б. Эерэг үйл ажиллагаа зэргийг багтаан чанартай, нийтийн боловсролыг хүн бүрд олгоход тулгарч байгаа хаалт, саад тотгор;
- в. Нийтийн боловсролыг сайжруулахаар тодорхойлсон тэргүүлэх чиглэлээ бүрэн зардлыг тооцох, санхүүжүүлэх.

36. Хүрч болох дээд түвшний чанартайгаар үнэ төлбөргүй, нийтийн боловсролоор хангах өөрийн үүргээ ахиц дэвшилттэйгээр биелүүлэх явцдаа улс орнууд хэн ч төлбөр төлөх боломжгүйн улмаас ямар нэгэн нийтийн боловсролын байгууллагаас гадуурхагдаагүй байхыг баталгаажуулах шаардлагатай алхам хийж, суралцагч, түүний гэр бүлийн байдлын улмаас үүсэх эрсдлээс сэргийлэх үр дүнтэй бүх арга хэмжээг авна.

37. Хязгаарлагдмал нөөцтэй тохиолдолд улс орнууд чанартай, нийтийн боловсролыг үргэлжлүүлэн олгохдоо эн тэргүүнд анхаарах ёстой.

Олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа

38. Боловсролын төлөөх олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа нь хүлээн авагч улсын зүгээс өөрийн хүлээсэн үндсэн үүргээ биелүүлэхийг дэмжихийг чухалчлах ёстой. Ялангуяа үүгээр хүн бүрийн тэр дундаа эмзэг, боломжгүй, гадуурхагдсан бүлгээ онцолж, үнэ төлбөргүй, чанартай, нийтийн сургуулийн өмнөх, бага, дунд боловсролыг чухалчлах, бусад түвшний нийтийн боловсролын байгууллагуудын талаас үнэ төлбөргүй, чанартай боловсролыг үр дүнтэй, чадах хэрээр түргэн шуурхай олгох ёстой.

Нийтийн байгууллагад хувийн нөөцийг олгох нөхцөл

39. Нийтийн боловсролын байгууллага нь сурч боловсрох эрхийг хамруулан хүний эрхийг биелүүлэхэд доорх байдлаар сөргөөр нөлөөлөхгүй нөхцөлд өгсөн нийтийн боловсролыг дэмжих тэтгэлэг зэрэг хувийн нөөцийг хүлээж авч болно. Үүнд:

- а. Байгууллагын засаглал эсвэл боловсролын тогтолцоонд нөлөөлөх;
- б. Сургалтын хөтөлбөр эсвэл заах арга зүйн материалын агуулга, арга зүй, туршлагад нөлөөлөх;
- в. Ялгаварлан гадуурхалтгүйгээр хичээл заадаг боловсролын байгууллагад бүртгүүлэх эрхэд хөндлөнгөөс нөлөөлөх;

- г. Хичээл заадаг боловсролын байгууллагын байранд зар сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагаа, материалтай байх, эсвэл хүүхдэд чиглэсэн байдлаар үйл ажиллагаа, материалыг түгээх зэргээр нийтийн боловсролыг арилжааны шинжтэй болгохоор чиглэх;
- д. Санхүүжүүлэгч, ивээн тэтгэгч төрийн албан тушаалтнаас ямар нэгэн санхүүгийн эсвэл өөр үр ашиг хүртэх, эсвэл ашиг сонирхлын зөрчил үүсгэх.

40. Нийтийн боловсролын байгууллагад зориулсан хамт олны сайн дурын хувь нэмрийг ч дээрх нөхцөл байдалд нийцүүлнэ.

41. Нийтийн боловсролыг дэмжих хувийн санхүүжилт эсвэл тэтгэлэг нь:

- а. Ил тодоор зарцуулах ба бүх зардлыг нийтэд дэлгэх;
- б. Боловсролын тогтолцоог бүхэлд нь бэхжүүлэх ба боловсролын байгууллагуудын хооронд тэгш бус байдлыг үүсгэх ямар нэгэн зүйлгүй байна.

Е. Засаглал

42. Улс орнууд үнэт төлбөргүй, чанартай, нийтийн боловсролтой байх эрхийг биелүүлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй үр нөлөөгүй засаглал, ил тод бус байдал, эгэх хариуцлагагүй байдал, эсвэл авлигад анхаарч, бүх арга хэмжээг даруй авах үүрэг хүлээдэг.

Ё. Үл ухрах

43. Улс боломжит нөөц дутсан учир үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролыг хүн бүрд олгож чадаагүй нөхцөл байдлаа харахын тулд:

- а. Эн тэргүүнд дээрх үүргээ биелүүлэхдээ өөрийн удирдлага дахь бүх нөөцийг хэрэглэсэн бүх оролдлогоо нийтэд ил харуулах;
- б. Байгаа болон байх боломжит бүх нөөцөө тодруулан, чадавхын зөрүүгээ тасралтгүй нийтэд ил дахин үнэлэх;
- в. Хамгийн боломжит богино хугацаанд чадавхын зөрүүд хэрхэн анхаарах, өөрийн үүрэгтэй уялдуулан үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролыг олгох зэргийг үндэсний боловсролын стратегидаа тусгай зорилтын хамт нарийвчилсан он цагийн дарааллыг оруулах ёстой.

44. Хүсэл тэмүүлэлгүй байх нь чадавхгүй байхаас ялгаатай бөгөөд тухайн улсын үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролыг олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүйг зөвтгөх үндэслэл болохгүй.

45. Нийтийн боловсрол эзэмших эрхээ эдлэхтэй холбоотой ухарсан арга хэмжээ авах нь ямар ч тохиолдолд хүлээн зөвшөөрөх ёсгүй гэсэн хүчтэй төсөөлөл бий. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд ухарсан арга хэмжээ авсан байвал улс олон хүний эрхийн хэм хэмжээ, жишигт нийцүүлэн ямарваа нэгэн арга хэмжээг авсан гэдгээ нотолвол зохино. Арга хэмжээнд:

- а. Мөн чанар, үйлчлэлийн хувьд түр зуурын, санхүүгийн хязгаарлагдмал нөхцөл байдал үүсгэсэн хямрал арилах хүртэл хугацааг хязгаарлана;

- б. Ямарваа нэгэн бодлогын хувилбар батлах, арга хэмжээ авч чадахгүй бол эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэхэд улам сөргөөр нөлөөлөх учир бусад боломжит хувилбар нэг бүрийг цогцоор хянан нягтлах боломж олгосон, нөхцөл байдалд заавал шаардлагатай, тохирсон байна;
- в. Үндэслэлтэй байна;
- г. Шууд болон шууд бусаар үл ялгаварлана;
- д. Үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролтой байх эрх зэрэг эмзэг, боломжгүй, гадуурхагдсан хувь хүн, бүлгийн эрхийг тусгайлан анхаарч, ялгавартай нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж ажиллана;
- е. Нийтийн боловсрол эзэмших эрхийн наад захын цөм агуулга, нөлөөнд өртсөн эдийн засаг, нийгэм, соёлын бусад эрхийг тодорхойлж, цаг ямагт цөм агуулгыг хамгаалж ажиллана;
- ё. Санал болгосон арга хэмжээ, хувилбараа нягтлан үзэхдээ хүүхэд, бусад суралцагч зэрэг нөлөөнд өртсөн бүлгийн бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоог хангана;
- ж. Үндэсний түвшинд утга учиртай байдлаар дүрэм журмаа хянан үзэх этгээд байвал зохино.

46. Олон улсын хэмжээнд тусалж, хамтран ажиллаж байгаа улс орнууд нийтийн боловсрол эзэмших эрхтэй холбоотой зөвшөөршгүй ухарсан арга хэмжээ авах, дэмжих, шаардах ёсгүй.

III. ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД СУРЧ, БОЛОВСРОХ ЭРХИЙГ ХҮНДЛЭХ, ХАМГААЛАХ, БҮРДҮҮЛЭХ ҮҮРЭГ

Нийтлэг зарчим 3. Төр нь эцэг, эх, эсвэл хууль ёсны асран хамгаалагчид хүүхдүүддээ төрийн өмчийн боловсролын байгууллагаас бусад боловсролын байгууллагыг сонгох эрх чөлөөг мөн байгууллагуудын хувийн боловсролын байгууллагыг байгуулах, удирдах эрх чөлөөг хүндэтгэх ёстой. Эдгээр боловсролын байгууллагууд нь олон улсын хүний эрхийн хуулиар хүлээсэн үүргийн дагуу төрөөс тогтоосон стандартад нийцсэн байна.

47. Төр нь эцэг, эх, эсвэл хууль ёсны асран хамгаалагчид хүүхэддээ төрийн өмчийн боловсролын байгууллагаас бусад боловсролын байгууллагыг сонгох эрх чөлөөг мөн байгууллагуудын хувийн боловсролын байгууллагыг байгуулах, удирдах эрх чөлөөг хүндэтгэх ёстой. Энэ явцад боловсролын байгууллагууд нь олон улсын хүний эрхийн хуулиар хүлээсэн үүргийн дагуу төрөөс тогтоосон стандартад нийцсэн байна.

48. Эдгээр эрх чөлөөг зөвхөн хуулийн дагуу хязгаарлах бөгөөд зөвхөн ардчилсан нийгэм дэх ерөнхий сайн сайхан байдлыг дэмжих, бусад аливаа хүний эрхийг хэрэгжүүлэх зорилгоор хязгаарлана. Эдгээр хязгаарлалт нь дараах зүйлийг хангаж байвал зөвтгөгдөнө:

- а. хувийн өмчит боловсролын байгууллагууд төрийн өмчит боловсролыг

шахан гаргах эсвэл орлохгүй, харин соёлын олон ургальч байдлыг харгалзан хүн бүрийг сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нэмэлт/нөхөх хэлбэр;

- б. хүүхдийн бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хүндэтгэж мөн эцэг, эх сонголтыг хийхдээ хүүхдийн нас, төлөвшил, тэдний ашиг сонирхолд нийцүүлэхээс гадна хүүхдийн бодолд нь зохих жинг өгнө;
- в. эдгээр эрх чөлөөг хэрэгжүүлэх нь сурч боловсрох эрхэд системчилсэн сөрөг үр дагавар үүсгэхгүй. Үүнд:
 - i. тусгаарлан сургах боловсролын тогтолцоо гэх мэт нийгмийн зарим бүлгүүдийн боловсролын боломж, үр дүнгийн зөрүү рүү хөтлөх буюу хадгалах, үүнээс үүдэн нийгмийн тэгш байдал, ялгаварлан гадуурхагдахгүй байх зарчмыг үгүйсгэдэг эсвэл хөнддөг;
 - ii. төрийн үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсрол эзэмших эрхийг хэрэгжүүлэх чадавхид сөргөөр нөлөөлөх буюу урьдчилан харах боломжтой сөрөг нөлөөний эрсдлийг бий болгох;
 - iii. боловсролыг арилжаалах замаар олон улсын хүний эрхийн хуулиар баталгаажуулсан боловсролын аливаа зорилгыг сулруулах;
 - iv. ил тод байдал, хууль дээдлэх, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх, боловсролын салбарт бүрэн, үр дүнтэй оролцоход сөргөөр нөлөөлөх;
 - v. бусад аливаа хүний эрх, ялангуяа боловсролын байгууллагад ажиллагсдын эрх ашгийг хүчингүй болгох, эсхүл ашиглах эрхийг нь доройтуулах.

49. Хувийн секторын оролцогчид сурч, боловсрох эрх, боловсролын бусад хүний эрхийг хүндэтгэх үүрэгтэй. Үүнд:

- а. сурч, боловсрох эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг өөрсдийн үйл ажиллагаагаар үүсгэхээс мөн хувь нэмэр оруулахаас зайлсхийх, ийм нөлөөлөл гарсан тохиолдолд шийдвэрлэх, засах;
- б. боловсролын үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх сөрөг нөлөөллийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээтэйгээ шууд холбоотой бол тэдгээр нөлөөлөлд шууд нөлөөлөөгүй байсан ч урьдчилан сэргийлэх, бууруулахыг эрмэлзэх.

50. Боловсролыг хувийн хэвслээр хангах нь үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын хүртээмжгүй байдлын үр дагавар юм бол төр үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын бүх нийтийн хүртээмжийг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай боловсруулж хөгжүүлэхийн тулд бүх үр дүнтэй арга хэмжээг авах ёстой. Ингэхдээ тэд хувийн сургалтын байгууллагуудаас төрөөс тогтоосон хамгийн бага стандартыг хангаж байхыг шаардаж, мөрдүүлэх, эсхүл зохих журмын дагуу эдгээр стандартаас доогуур байгаа хувийн сургалтын байгууллагуудыг хаах ёстой.

Нийтлэг зарчим 4. Төр боловсрол эзэмшихэд хувийн сектор оролцож байгаа газарт сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг хангахын тулд үр дүнтэй зохицуулалтын арга хэмжээ зэрэг бүх боломжит арга хэмжээг

авах ёстой.

51. Төр боловсрол эзэмшихэд хувийн сектор оролцож байгаа газарт сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг хангахын тулд үр дүнтэй зохицуулалтын арга хэмжээ зэрэг бүх боломжит арга хэмжээг авах ёстой. Үүнд хувийн оролцогчид ямар нэгэн төрийн оролцоо, хяналтгүйгээр үйл ажиллагаагаа явуулдаг, албан бус болон хууль бусаар үйл ажиллагаа явуулдаг нөхцөл байдал орно.

52. Төр сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулсныг баталгаажуулахын тулд боловсрол эзэмшүүлж буй хувийн оролцогчдод төрийн үйлчилгээний үүрэг хүлээлгэх ёстой. Үүнд:

- а. байгууллагын түвшинд бүх хувийн сургалтын байгууллагуудад олгогддог боловсрол нь хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, сурч боловсрох эрхтэй холбоотой стандартуудтай нийцэж байх; болон
- б. системийн түвшинд хувийн боловсролын байгууллагууд сурч боловсрох эрхээ эдлэхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх.

53. Улс орон хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, стандартад нийцсэн хувийн боловсролын байгууллагуудын үр дүнтэй зохицуулалтыг бий болгох ёстой. Ийм зохицуулалт нь доорх Удирдах зарчим 54-57-д заасны дагуу тогтоосон хамгийн бага/минимум стандартыг дагаж мөрдөхийг баталгаажуулах бөгөөд үүн дотроос дараах зүйлийг баталгаажуулах ёстой. Үүнд:

- а. ямарч хувийн боловсролын байгууллага, хувийн хэвшлийн боловсролын байгууллагуудын зохион байгуулалттай бүлэг нь боловсролын системд зүй бусаар нөлөөлөх, тэр дундаа шаардлагатай тохиолдолд хувийн сургалтын байгууллагуудын тоог хязгаарлах эсвэл хувийн сургалтын байгууллагыг сонгох, байгуулах эрх чөлөөнд нөлөөлөх хэмжээнд хувь эзлэхгүй байх;
- б. Боловсролд оролцож буй хувийн оролцогчдод нөлөөлөх байр суурьтай төрийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил байхгүй байх;
- в. хувийн боловсролын байгууллагуудын маркетинг, сурталчилгаа эсвэл бусад практик үйл ажиллагаа нь төөрөгдөл үүсгэхгүй байх.

Хувийн сургалтын боловсролын байгууллагуудад хамааралтай хамгийн бага/минимум стандарт

54. Сурч боловсрох эрхийг хамгаалах зохицуулалтын ажлын хүрээнд Төр хувийн сургалтын байгууллагуудад хамааралтай хамгийн бага стандартыг тодорхойлж, мөрдүүлэх ёстой. Эдгээр стандартыг хүүхдүүд, бусад суралцагчид, эцэг, эхчүүд эсвэл хууль ёсны асран хамгаалагчид, олон нийт, багшлах болон багш биш ажилтнууд, боловсролын үйлдвэрчний эвлэлүүд, иргэний нийгмийн бусад байгууллагууд, хувийн сургалтын байгууллагууд зэрэг бүх оролцогч талуудыг хамарсан тэдний оролцоотойгоор боловсруулж батлах ёстой. Эдгээр стандартыг сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэгтэй харшлах зорилгоор ашиглаж болохгүй.

55. Хамгийн бага стандарт нь дараах хэмжээсийг хангасан байх ёстой. Үүнд:

- а. хувийн сургалтын байгууллагын засаглал. Үүнд:
 - i. бүртгэл, лиценз олгох үйл явц, тэдгээрийг буцаан татах нөхцөл;
 - ii. санхүүгийн болон үйл ажиллагааны эсвэл чанарын мэдээлэл зэрэг улсад тайлагнах шаардлага;
 - iii. хүүхдүүд болон бусад суралцагчид, эцэг, эх эсвэл хууль ёсны асран хамгаалагч, хүй олон, багшлах болон багш биш ажилтнууд, боловсролын үйлдвэрчний эвлэл, бусад иргэний нийгмийн байгууллагуудын бүрэн, үр дүнтэй оролцоо;
 - iv. боловсролын нөөцийн менежмент;
 - v. шаардлагатай тохиолдолд төлбөрийн хэмжээ болон бусад шууд ба шууд бус зардал, ялангуяа хэт их өртэй болох эрсдэлд анхаарлаа хандуулах, мөн төрөөс боловсролын хүртээмжтэй байдлыг хангах талаар төрөөс хүлээх үүрэг;
 - vi. дотоодын болон шаардлагатай тохиолдолд олон улсын захиргаа, санхүүгийн бүтцийг багтаасан хувийн сургалтын боловсролын байгууллагуудын тухай ил тод байдал, мэдээлэл авах; суралцагчдад учирч болзошгүй бүх сургалтын хөтөлбөр ба бусад төлбөр; боловсролын нөөцийн ашиглалт; хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүй, дадлага; элсэлтийн нөхцөл; байгууллагын эрх зүйн байдал, гарал үүсэл; болон байгууллагуудын бусад бодлого; болон
 - vii. суралцагчдын гэрчилгээжүүлэх нөхцөл, ил тод байдал.
- б. эрдэм шинжилгээний болон сурган хүмүүжүүлэх эрх чөлөөг хүндэтгэх;
- в. суралцагчдын эвлэлдэн нэгдэх, үг хэлэх эрх чөлөөг хамгаалах;
- г. сурч боловсрох эрхийг эдлэхдээ ялгаварлан гадуурхах бүх хэлбэрээс суралцагчдыг хамгаалах, элсэлт, суралцах нөхцөл шууд болон дам байдлаар ялгаварлан гадуурхахгүй байхыг баталгаажуулах замаар бүх суралцагчдын тэгш байдал, хүртээмжтэй боловсролыг баталгаажуулах; мөн тэдний эмзэг, гадуурхагдсан, эмзэг бүлгийн хүмүүсийн тэгш байдал, ялгаварлан гадуурхах эрхэд үзүүлэх нөлөөнд онцгой анхаарал хандуулах. Ийм хамгаалалт нь жирэмсэн охид, залуу эхчүүд, гэрлэсэн 18-аас доош насны охидод сургуульдаа үлдэх эсвэл саадгүй буцаж сургуульд хамруулах, шинээр элсэхийг баталгаажуулах ёстой;
- д. ажилтнуудын мэргэжлийн минимум ур чадвар; сургалт; хөдөлмөрийн эрх, үүнд хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн гэрээний нөхцөл, цалин хөлс, эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр хийх эрх чөлөө; боловсролын сургалтын байгууллагын удирдагч, багш, бусад ажилтны статус нь дор хаяж хүний эрхийн холбогдох хууль, стандартад нийцсэн байх ёстой; хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, стандарт, ялангуяа бодол, ухамсар, шашины эрх, цөөнх, уугуул иргэдийн эрх, соёлын эрх, эрдэм шинжилгээний болон сурган хүмүүжүүлэх эрх чөлөөг зохих ёсоор

- харгалзан сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүй, дадалд тусган харгалзан үзсэн байх. Боловсролын хэлбэр, мөн чанар нь хүлээн зөвшөөрөгдөхүйц, дасан зохицох чадвартай, Удирдах зарчим 8-д заасан боловсролын зорилгод нийцсэн байх ёстой. Төр ялангуяа хүүхдэд сургалтын хөтөлбөрийн хүрээнд сурах, оролцох үүнд ерөнхий соёл, бие бялдар, урлагийн үйл ажиллагааны зэрэгцээ хүүхдийн амрах, чөлөөт цагаа өнгөрөөх, тоглох, идэвхтэй амралтад холбогдолтой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүндэтгэж тэднийг бий болгох зохих цаг хугацаа, мэргэжлийн ур чадварыг хуваарилсан байх ёстой;
- е. суралцагчдыг түдгэлзүүлэх, хөөх явцад хатуу хязгаарлалт тогтоох, зохих журмыг хангасан эсэхийг баталгаажуулж, ийм түдгэлзүүлэх, хөөх явц нь тайлбарлаж болохуйц пропорциональ байх;
 - ё. сахилга бат ба бие махбодийн шийтгэлийг хориглох;
 - ж. төлбөрийг төлөөгүй эсвэл саатсантай холбогдуулан суралцагчдын эрхийг хамгаалах;
 - з. сурах орон зайн хэмжээ, засвар үйлчилгээ, ариун цэврийн болон гал тогооны өрөөний тоноглол, тавилга, тоног төхөөрөмж, гамшиг эрсдэлийн удирдлага мөн түүнчлэн сурах бичиг, сургалтын болон сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг хүчин зүйлийг харгалзан охид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зэрэг бүх суралцагчдад тохирсон аюулгүй сургалтын орчин, дэд бүтцийн стандарт;
 - и. хүртээмжтэй холбоотой наад захын шаардлага, үүнд боломжийн байрны баталгааны үүргийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нэвтрэх, байгууллагууд аливаа суралцагчаас шууд болон шууд бусаар нэмэлт төлбөр авахгүй байхыг баталгаажуулах;
 - й. суралцагчдын бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдал, түүний дотор нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх стандартыг хангах; эрүүл мэнд, эрүүл ахуй; суралцагчдыг хүчирхийлэл, бэлгийн дарамтаас хамгаалах;
 - к. суралцагчид болон тэдний гэр бүлийнхнийг заналхийлэх, ичээх, дээрэлхэхээс хамгаалах, ялангуяа тухайн байгууллагын хүлээгдэж буй академик/эрдэм шинжилгээний стандартад нийцэхгүй байж болох болон тухайн байгууллагад асуудал үүсгэж болзошгүй хүмүүсийг хамгаалах;
 - л. суралцагчид, ялангуяа хүүхдийг элссэн байгууллагынх нь хэт их сурталчилгаанаас хамгаалах;
 - м. нууцлал ба мэдээллийн хамгаалалт, ялангуяа хувийн мэдээллийн талаар хууль, ёс зүйн хэм хэмжээг хүндэтгэх дээдлэх. Төр, хувийн, түүний дотор биометрийн өгөгдлийг зөвшөөрөлгүйгээр цуглуулах, хадгалах, эсвэл шууд зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдтэй хуваалцах, боловсролоос бусад зорилгоор, үүнд арилжаа, цагаачлал, аюулгүй байдлын зорилгоор ашиглахгүй байхыг баталгаажуулах ёстой;

н. чанартай боловсролыг хангах үүднээс багш/суралцагчийн хүлээн зөвшөөрөгдөх хамгийн дээд харьцаа;

о. хүний эрхийг хамгаалахад шаардлагатай бусад стандарт.

56. Төр боловсрол эзэмших эрхийг дэвшилтэйгээр хэрэгжүүлэх үүргийнхээ дагуу хувийн сургалтын байгууллагуудад тавигдах хамгийн бага/минимум стандартад заасан шаардлагыг үе шаттайгаар дээшлүүлэх ёстой.

57. Хамгийн бага/минимум стандарт нь төр эргэлт буцалтгүй зарчмуудтай байхтай холбоотой үүрэг хүлээнэ.

Сургалтын бус болон боловсролын бус хувийн тоглогчид

58. Төр суралцах байрны үйлчилгээ эрхлэгчид, боловсролын зээл олгож буй санхүүгийн байгууллагууд, нийтийн байгууллагуудад орон зай олгох газар өмчлөгчид гэх мэт сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд нөлөөлж болох сургалтын бус болон боловсролын бус хувийн оролцогчдыг зохицуулах ёстой. Тэдний үйл ажиллагаа нь сурч боловсрох эрхийг хүчингүй болгох, доройтуулахад хүргэхгүй байхыг баталгаажуулах.

59. Төрийн болон хувийн сургалтын байгууллагуудад арилжааны сурталчилгаа, маркетинг хориглож, сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүй, практик үйл ажиллагаанд арилжааны ашиг сонирхол нөлөөлөхгүй байхыг баталгаажуулах ёстой.

Хэрэгжүүлэлт

60. Хувийн боловсролын байгууллагууд холбогдох стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд төр үүнийг хамгийн богино хугацаанд хэрэгжүүлэхийг шаардах ёстой. Төр зохих зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх хэрэгсэл, менежментийн тусламж үзүүлэх гэх мэт арга хэмжээ авах замаар эсхүл үл нийцэл үргэлжлэх тохиолдолд шийтгэлийг ноогдуулах замаар дагаж мөрдөхийг дэмжих ёстой. Ийм арга хэмжээ авсны дараа хувийн боловсролын байгууллагууд стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөх боломжгүй эсвэл хүсэхгүй байгаа тохиолдолд төр зохих журмын дагуу эдгээр байгууллагыг дараах журмаар хаах ёстой. Үүнд:

- а. боловсролын байгууллагуудад эдгээр стандартыг дагаж мөрдөх хангалттай мэдэгдэл, боломжийг олгосон;
- б. нөлөөлөлд өртсөн бүх суралцагчдын сурч боловсрох эрхийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжийг баталгаажуулсан байхад анхаарах.

Газар нутгийн гадна хэрэглээ

61. Төр зохицуулах боломжтой нөхцөлд боловсролд оролцдог хувийн оролцогчид үйл ажиллагаа явуулж буй газар бүртээ сурч боловсрох эрхийг хүчингүй болгохгүй эсвэл сулруулахгүй байх тал дээр бүх л үр дүнтэй арга хэмжээг авах ёстой. Энэ арга хэмжээнд захиргааны, хууль эрх зүйн, мөрдөн байцаах, шүүх, бусад аливаа арга хэмжээг багтааж болно.

62. Сурч боловсрох эрхийг хамгаалах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм болон олон улсын ерөнхий хууль тогтоомжийн дагуу

боловсролд оролцож буй хувийн оролцогчдод нөлөөлөх байр суурьтай улс орнууд ийм зохицуулалтын эрхгүй ч гэсэн тухайлбал төрийн худалдан авах ажиллагааны систем эсвэл олон улсын дипломат ажиллагаагаар дамжуулан ийм нөлөөг хэрэгжүүлэх ёстой.

63. Сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай тохиолдолд олон улсын туслалцаа, боловсролын хамтын ажиллагаа нь хүлээн авагч улс орнуудын хүний эрхийн үүргийн дагуу боловсролд оролцож буй хувийн оролцогчдын зохицуулалтыг бэхжүүлэхэд чиглэгдэх ёстой.

IV. САНХҮҮЖИЛТ

Нийтлэг зарчим 5. Төр үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын санхүүжилт, хангамжийг нэн тэргүүнд тавих ёстой бөгөөд зөвхөн шууд болон шууд бус хэлбэрээр, үүнд татварын хөнгөлөлт, газрын хөнгөлөлт, олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа, бусад хэлбэрээр эрх бүхий хувийн сургалтын байгууллагуудыг санхүүжүүлэх боломжтой. Тэдгээр нь хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, стандартыг дагаж мөрдөж, доор тодорхойлсон бүх бодит, процедурын болон үйл ажиллагааны шаардлагыг чандлан мөрдөж байх ёстой.

64. Сурч боловсрох эрх нь төрөөс хувийн сургалтын байгууллагыг санхүүжүүлэх үүрэг хүлээлгэхгүй. Төр үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын санхүүжилт, хангамжийг нэн тэргүүнд тавих ёстой бөгөөд зөвхөн шууд болон шууд бус хэлбэрээр, үүнд татварын хөнгөлөлт, газрын хөнгөлөлт, олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа, бусад хэлбэрээр эрх бүхий хувийн сургалтын байгууллагуудыг санхүүжүүлэх боломжтой. Тэдгээр нь хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, стандартыг дагаж мөрдөж, доор тодорхойлсон бүх бодит, процедурын болон үйл ажиллагааны шаардлагыг чандлан мөрдөж байх ёстой.

Бодит шаардлага

65. Эрх бүхий хувийн сургалтын байгууллагад төрөөс олгож болзошгүй аливаа санхүүжилт дараах бүх шаардлагыг хангасан байна. Үүнд:

- a. энэ нь цаг хугацааны хязгаарлалттай арга хэмжээ бөгөөд тухайн улс тухайн нөхцөл байдалд сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг урагшлуулах цорын ганц үр дүнтэй хувилбар болохыг олон нийтэд харуулсан байх:
 - i. төр нь үнэ төлбөргүй, чанартай сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх өөр ямар нэгэн сонголт байхгүйг олон нийтэд харуулсан тохиолдолд боловсрол эзэмших богино хугацааны хүртээмжийг хувь хүмүүс хангах;
 - ii. соёлын олон талт байдлыг хүндэтгэхийг дэмжиж, хүртээмжтэй боловсрол эзэмших эрхийн дагуу соёлын эрхийн хэрэгжилтийг хангах;
 - iii. өмнө нь бие даан үйл ажиллагаа явуулж байсан хувийн сургалтын байгууллагуудын нийтийн боловсролын тогтолцоонд шилжих

интеграцийг дэмжих;

- iv. төр нь олон нийтийн боловсролын байгууллагуудад хурдан хугацаанд хэрэгжих боломжгүй гэдгийг олон нийтэд харуулсан сурган хүмүүжүүлэх, агуулгын олон ургальч чиг хандлагын эрэлт хэрэгцээнд эсвэл туршиж үзэх шаардлагад хариу барих.
- б. Сурч боловсрох эрхээ дээд зэргээр хэрэгжүүлэх үүргээ биелүүлэх үүргийн дагуу хүртээмжтэй, чанартай олон нийтийн үнэ төлбөргүй боловсролын тогтолцоог хамгийн дээд түвшинд хамгийн үр дүнтэй бөгөөд хурдан хамгийн боломжит нөөцөөр хөгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх, хойшлуулахыг урьдчилан харах боломжтой эрсдэлийг бий болгодоггүй байх;
- в. энэ нь хүлээн зөвшөөрөх боломжгүй ухраах арга хэмжээ ялангуяа олон нийтийн боловсролын систем дэх стандартыг бууруулахтай холбоотой олон нийтийн нөөцийг сарниулаагүй байх;
- г. энэ нь боловсролын тогтолцоог арилжааны шинж чанартай болгоход хувь нэмэр оруулаагүй байх;
- д. санхүүжүүлсэн хувийн сургалтын байгууллага нь боловсролын системд зүй бусаар нөлөөлөх, эсвэл боловсролын тогтолцооны үлэмж хэсгийг эзэлж, сурч боловсрох эрхийг алдагдуулах урьдчилан таамаглан харж болохоор эрсдлийг үүсгэдэггүй байх;
- е. ялгаварлан гадуурхахгүй байх, эрх тэгш байдал, ялгаварлан тусгаарлахгүй байхтай холбоотой үүрэгт онцгой анхаарал хандуулж, боловсрол эзэмших эрхэнд бусад системчилсэн нөлөөллийн урьдчилан харж болохоор эрсдлийг бий болгоогүй байх.

Процедурын шаардлага

6б. Төсвийн санхүүжилтийг эрх бүхий хувийн сургалтын байгууллагад хуваарилахад дараах журмын бүх шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- а. санхүүжилтийг авч үзэхээс өмнө ийм санхүүжилтийг зохицуулах зохих үйл явц, журам, дүрэм гэх мэт тогтолцоо хүрээ бий болгох, үүнд доор байгаа б-с d хүртэлх зохицуулалтыг багтаасан байна;
- б. санхүүжилтийг тодорхойлохоос өмнө:
 - i. бүх оролцогч талууд, үүнд хүүхдүүд болон бусад суралцагчид, эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчид, багшлах болон багш биш ажилтнууд, боловсролын холбоод, иргэний нийгмийн бусад байгууллагуудын бүрэн, үр дүнтэй утга учиртай оролцоог чухалчилсан оролцоотой, хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай зөвлөлдөх үйл явцтай байх;
 - ii. төрийн ийм санхүүжилт нь материаллаг, процедурын болон бусад бүх шаардлагыг хангаж байгааг олон нийтэд ил тод харуулсан байх;
 - iii. төр хувийн хэвшлийн боловсролын сургалтын байгууллагын холбогдох стандартыг хангах чадварыг тасралтгүй хянах, зохицуулах

- чадавх, хүсэл эрмэлзлэлээ үнэлж, олон нийтэд харуулах;
- в. санхүүжилт хуваарилах үйл явц нь ил тод, ялгаварлан гадуурхахгүй байх;
 - г. санхүүжилтийг бодит байдал дээр эргүүлэн өөрчлөх эсвэл хувийн сургалтын боловсролын байгууллагуудын үүргийг төрд шилжүүлэх боломжтой байхаар тохируулсан байх.

Үйл ажиллагааны шаардлага

67. Хэрэв шаардлага хангасан хувийн сургалтын боловсролын байгууллага нь төрийн санхүүжилт авсан бол тухайн байгууллагад мөрдөгдөж буй стандарт, журам нь дор хаяж төрийн боловсролын байгууллагад ногдуулсан боловсролын, хөдөлмөрийн болон бусад холбогдох стандартыг тусгасан, түүний дотор хөдөлмөрийн нөхцөл, ажил эрхлэлт, хөдөлмөрлөх эрх, эвлэлдэн нэгдэх эрхийг үр дүнтэй хамгаалсан байх ёстой.

68. Төрөөс хувийн сургалтын байгууллагыг санхүүжүүлэх үндэслэл болсон боловсролын үйлчилгээ үзүүлэх аливаа асуудлыг хүргэх, удирдах чадваргүй байдлыг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай арилгахын тулд бүх үр дүнтэй арга хэмжээг авах ёстой. Ингэхдээ улс орнууд сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхийн тулд тогтмол санхүүжилтийг бэхжүүлж, улсын чадавхийг харгалзан дахин үнэлж байх ёстой. Үүнд анх байгуулагдсан цагаасаа эхлэн энэхүү санхүүжилтийг зөвтгөсөн төрийн чадваргүй байдлыг арилгах үед санхүүжилтийг үе шаттайгаар зогсоох төлөвлөгөө багтсан байх ёстой.

69. Эрх бүхий хувийн сургалтын байгууллагын төрийн аливаа санхүүжилт нь хүний эрхэнд үзүүлэх нөлөөллийн өмнөх, явцын, дараах үнэлгээний дүн шинжилгээнд хамрагдах ёстой бөгөөд эдгээрийг олон нийтэд мэдээлж, санхүүжилтийн сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг байнга дахин үнэлэх ёстой бөгөөд шаардлагатай бол санхүүжилтийг өөрчлөх, зогсоох. Үнэлгээ нь байгууллага тус бүрийн болон системийн үр нөлөөг богино болон урт хугацаанд хэмжих ёстой бөгөөд үүнд хүүхэд, бусад суралцагчид, эцэг, эх эсвэл хууль ёсны асран хамгаалагч, олон нийт, багшлах болон багш биш ажилтнууд, боловсролын холбоод, иргэний нийгмийн бусад байгууллагуудыг оролцуулах ёстой.

70. Төр санхүүжилтийг үргэлжлүүлэн хангах нөхцөлөөр шаардагдах стандартыг биелүүлэх шаардлагыг оруулах, стандартын шаардлагыг хангаагүй тохиолдолд төр хохиролгүйгээр санхүүжилтээс гарахыг бүх гэрээнд зөвшөөрч, гэхдээ сурч боловсрох эрхийг үргэлжлүүлэн эдлэхийг баталгаажуулах ёстой. Санхүүжилтийн үр нөлөө нь сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тэр дундаа олон нийтийн боловсролын тогтолцооны хөгжлийг үлэмж хэмжээнд үгүйсгэх эсвэл сулруулахад чиглэсэн байвал төрийн аливаа санхүүжилтийг буцааж татах ёстой.

71. Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ, зохицуулалт болон төрд тавигдах бусад шаардлагын зардлыг санхүүжилтийн зохицуулалтын зардлын үнэлгээний нэг хэсэг гэж үзэн, төрөөс бүх боломжит нөөцийг дээд зэргээр

ашиглаж хамгийн дээд түвшний боловсрол эзэмшүүлэх үүргийг зохих ёсоор нь харгалзан үзнэ.

72. Төрийн санхүүжилт авсан бүх хувийн сургалтын байгууллагууд боловсролын системийг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулах боломжтой бүх материалыг хууль тогтоомжоор тогтоосон боломжийн хугацаанд холбогдох төрийн байгууллагуудад өгөхийг баталгаажуулах ёстой. Үүнд анги танхимд ашигладаг технологи, удирдлагын систем хоёулаа багтана. Энэ нь хувийн нууцыг хамгаалах, ялангуяа суралцагч, багш нарын хувийн эрхийг хамгаалах, хүндэтгэх хүрээнд хийгдэх. Энэ нь тэдний зохиосон шинжлэх ухаан, бичгийн, урлагийн аливаа бүтээлийн үр дүнд бий болсон ёс суртахууны болон материаллаг ашиг сонирхлыг хамгаалах хүн бүрийн ашиг хүртэх эрхийг хүндэтгэх үүднээс хийгдэх ёстой.

Эрхгүй байгууллага

73. Төр дараах хувийн сургалтын боловсролын байгууллагыг шууд болон шууд бус хэлбэрээр санхүүжүүлэх, дэмжих ёсгүй. Үүнд:

- а. тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийг зөрчсөн, түүний дотор сонгон шалгаруулсан байдлаар ашигласан; эсвэл суралцагчдыг нийгэм, эдийн засгийн сул тал, суралцагч, гэр бүл, хамт олон, хүйс, хөгжлийн бэрхшээл, бусад хориглосон үндэслэлээр шууд болон дам байдлаар хөөх, ангилах;
- б. арилжааны шинжтэй бөгөөд хувийн ашиг сонирхлоо хэт их хөөдөг;
- в. боловсролын хүртээмжийг ихээхэн доройтуулсан төлбөр хураамж авдаг;
- г. хувийн боловсролын сургалтын байгууллагад хамаарах хамгийн бага стандарт, эсвэл хүний эрхийн бусад холбогдох хууль тогтоомж, стандартад нийцээгүй, эсвэл чанарын шаардлага хангахгүй байх;
- д. дотоодын болон олон улсын санхүүгийн бүх үүргээ биелүүлдэггүй; е. боловсрол эзэмших эрхийг эдлэхэд системчилсэн сөрөг нөлөөлөлд хувь нэмэр оруулах эсвэл хүний эрхийг бусад хэлбэрээр хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлдөг.

Сургалтын бус боловсролын хувийн байгууллагууд

74. Аливаа хувийн сургалтын бус боловсролын байгууллагуудтай гэрээ байгуулах нь сурч боловсрох эрхээ эдлэхэд сөргөөр нөлөөлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд худалдан авалтыг зохицуулах журам, холбогдох бусад журмыг хүндэтгэх ёстой.

Нийтлэг зарчим 6. Олон улсын туслалцаа, хамтын ажиллагааны тохиолдолд холбогдох эрх эзэмшигчидтэй зөвлөлдөж, хүлээн авагч улстай хамтран үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын тогтолцоог бэхжүүлж, хувийн боловсролын байгууллагуудыг хүний эрхэд харшлах шууд болон шууд бус хэлбэрээр дэмжихээс татгалзах ёстой.

75. Олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа нь дэмжлэг үзүүлсэн тохиолдолд холбогдох эрх эзэмшигчидтэй зөвлөлдөж, хүлээн авагч улстай

хамтран үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын тогтолцоог бэхжүүлэх ёстой. Хүний эрхийг дээдлэх, хамгаалах, биелүүлэхийн тулд хөгжлийн төслийн үе шат бүрт бүхий л хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Үүний тулд хөндлөнгийн, хараат бус байдлаар үнэлэх үйл явцыг зохион байгуулах ёстой.

76. Боловсролын чиглэлээр олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа явуулж буй улс орнууд болон холбогдох олон улсын байгууллагууд хувийн боловсролын байгууллагуудыг хүний эрхэд харшлах шууд болон шууд бус хэлбэрээр дэмжихээс татгалзах ёстой.

77. Хувийн оролцогчид боловсрол эзэмших эрхийг хүчингүй болгох, эсвэл доройтуулах үйлдлээс татгалзах үүрэгтэй. Боловсролд туслалцаа үзүүлж буй хүмүүс нь үзүүлж буй дэмжлэг нь холбогдох хүний эрхийн хууль тогтоомж, стандарт, түүний дотор хүүхэд хамгааллын бодлоготой нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах үүрэгтэй. Төр хувийн оролцогчдоос өөрсдийн харьяаллын хүрээнд үзүүлж буй боловсролын туслалцаа нь хүний эрхийн хэрэгжилтийг хүчингүй болгох эсвэл сулруулах нөхцөлийг бүрдүүлэхийн эсрэг тэдгээрийг зохицуулах ёстой.

78. Хэрэв төр, олон улсын байгууллагууд эсвэл бусад оролцогчид олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа эсвэл бусад хэлбэрээр тусламж үзүүлэх замаар өмнө нь хүлээн авагч улсыг тухайн улсын хүний эрхийн үүрэгт үл нийцэх үйлдэл хийх, үүнд төлбөртэй болгох эсвэл төлбөрийг нэмэх эсвэл нийтийн үнэгүй боловсролын санхүүжилтгүй болгох зэргээр зөвшөөрөгдөөгүй алхмуудыг хийхийг уриалсан, хувь нэмэр оруулсан эсвэл албадсан бол энэ байдлыг хамгийн богино хугацаанд арилгахыг эрмэлзэх ёстой.

79. Хэрэв хүлээн авагч оронд хувийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх нь сурч боловсрох эрхээ эдлэхэд сөрөг нөлөө үзүүлж байгаа бол тухайн хүлээн авагч улсад олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа үзүүлж буй улс орнууд нөхцөл байдлыг засах бүх үр дүнтэй арга хэмжээг авах ёстой. Үүнд хүлээн авагч улсад үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын хүртээмжийг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай боловсруулж хөгжүүлэх, сэргээн босгох арга хэмжээг багтааж болох бөгөөд тухайн улсад хүний эрхийн хууль, стандартын дагуу боловсролын салбарт хувийн оролцоотой холбоотой стандарт, журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Энэ нь хүлээн авагч улсын дотооддоо боловсрол эзэмших эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүргийг хөндөхгүй.

V. ЭГЭХ ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТ, ЗАЛРУУЛАХ АРГА ЗАМ

Нийтлэг зарчим 7. Төр сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх, үүнд хувийн секторын оролцогчдыг боловсролд хамруулахтай холбогдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь хариуцлага хүлээлгэх хангалттай механизмыг бүрдүүлэх ёстой.

80. Төр сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх, үүнд хувийн секторын оролцогчдыг боловсролд хамруулахтай холбогдсон үүрэг

хариуцлагаа биелүүлэхэд нь хариуцлага хүлээлгэх хангалттай механизмыг бүрдүүлэх ёстой. Хариуцлагыг дараах байдлаар хангах ёстой. Үүнд:

- а. үндэсний, бүс нутгийн эсвэл дэлхийн түвшинд эрүүгийн, иргэний, захиргааны хариуцлага хүлээлгэх, албадан гүйцэтгэх ажиллагааг багтаасан шүүхийн арга хэрэгсэл;
- б. парламентын хяналт, Парисын зарчмын дагуу үйл ажиллагаа явуулж буй Хүний эрхийн үндэсний байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд эсвэл бусад дотоодын, хүний эрхэд нийцсэн хагас-шүүхийн механизм зэрэг хагас-шүүхийн болон шүүхийн бус хянах арга хэрэгсэл.

Нийтлэг зарчим 8. Төр улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудын сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, энэ эрхтэй холбоотой төрийн бүхий л бодлого, үйл ажиллагаа хүний эрхийн зарчимд нийцэж байгааг баталгаажуулах ёстой.

81. Төр сурч боловсрох эрх, үүнд оролцоо, ил тод байдал, мэдээлэл олж авах, хүртээмжтэй байдал, ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг хүний эрхийн зарчмуудыг дагаж мөрдөж байгааг тогтмол хянах ёстой.

82. Ийм хяналт шинжилгээний үр дүн нь олон нийтийн хүртээл байх ёстой бөгөөд хүний эрхийг хангах талын зөрүү дутагдалыг тогтоосон тохиолдолд хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай.

Олон нийтийн боловсролын хяналт

83. Төр олон нийтийн боловсролыг хүний эрхийн дотоодын болон олон улсын үүрэгт нийцэж байгаа эсэхийг үнэлэх, үүнд үр дүнтэй, хараат бус, хангалттай нөөцтэй хяналтын системийг бий болгох замаар үнэлэх ёстой. Тэд мөн олон нийтийн боловсролын үйл ажиллагааны ил тод байдалд болон шийдвэр гаргахад бүрэн, үр дүнтэй оролцоог хангахын тулд шаардлагатай мэдээллийг олон нийтэд хүргэх ёстой.

Хувийн оролцооны хүрээнд хяналт тавих

84. Боловсролд оролцдог хувийн оролцогчдыг холбогдох стандарт, дүрэм журам, үүнд 54-77 дугаар Удирдах зарчмуудад заасан хамгийн минимум/бага стандартыг дагаж мөрдөж, сурч боловсрох эрхийн үүргийг биелүүлэхийн тулд төр үр дүнтэй хяналт болон хэрэгжүүлэх механизмыг бий болгох, сахих, зохих эх үүсвэрээр хангах ёстой.

85. Хяналтынхаа хүрээнд төр, хувийн боловсролын сургалтын байгууллагуудын сурч боловсрох эрхийг эдлэхэд үзүүлж буй нөлөөллийг үнэлэх зорилгоор тогтмол мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх ёстой. Ийм үнэлгээ нь дараах хоёр зүйлийг хэмжих ёстой. Үүнд:

- а. сурч боловсрох эрхийг эдлэхэд бодит болон нөлөөлж болзошгүй нөлөөллийг үнэлэх, богино болон урт хугацааны хувийн боловсролын сургалтын байгууллагуудын системийн үр нөлөө;
- б. хувийн сургалтын байгууллагууд үйл ажиллагаагаараа дамжуулан үүсгэж болох эсвэл хувь нэмэр оруулж болох хүний эрхийн

хэрэгжүүлэлтэд үзүүлэх нөлөө.

86. Үнэлгээ нь дараах байдлаар байх ёстой. Үүнд:

- а. хувийн боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа, үйл ажиллагааны нөхцөл байдал өөрчлөгдөж хөгжихийн хэрээр сурч, боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд үзүүлэх нөлөөлөл цаг хугацааны явцад өөрчлөгдөж болохыг хүлээн зөвшөөрч тогтмол байх;
- б. олон нийтийн оролцоотой бөгөөд бүх оролцогч талууд, үүнд хүүхдүүд болон бусад суралцагчид, эцэг, эхчүүд эсвэл хууль ёсны асран хамгаалагчид, хүй олон, багшлах болон багш- биш ажилтнууд, боловсролын үйлдвэрчний эвлэлүүд, бусад иргэний нийгмийн байгууллагууд орно;
- в. олон нийтэд нээлттэй.

87. Энэхүү үнэлгээний үр дүн нь хувийн сургалтын байгууллагуудын оролцоо нь сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг дэмжиж, сулруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс төрөөс баримталж буй бодлого, зохицуулалтанд тусгагдах ёстой. Төр сөрөг үр дагаврыг хэрхэн шийдвэрлэсэн эсвэл шийдвэрлэх талаар тогтмол тайлан нийтэлж байх ёстой.

Ерөнхий зарчим 9. Төр сурч, боловсрох эрхийг зөрчсөн, боловсролын хувийн секторын тоглогчид хүний эрхийг зөрчсөн тохиолдолд үр дүнтэй залруулах арга хэмжээ авах боломжоор хангах ёстой.

88. Төр боловсрол эзэмших эрхийг зөрчсөн тохиолдолд үр дүнтэй залруулах арга хэмжээ авах боломжоор хангах ёстой, үүнд мөн төр бүтэлгүйтсэн тохиолдол багтана. Үүнд:

- а. олон нийтэд үнэ төлбөргүй, чанартай боловсрол олгох үүргээ биелүүлэх;
- б. хувийн секторын оролцогчид сурч боловсрох эрхээ эдлэхэд саад учруулахаас урьдчилан сэргийлэх.

89. Төр аливаа эрх бүхий этгээд, эсвэл боломжтой бол бусад холбогдох оролцогч талууд болох нийтийн ашиг сонирхлын бүлгүүд боловсролд оролцож буй хувийн оролцогчийн зүгээс аливаа хүний эрхийг зөрчсөн тохиолдолд түүнийг арилгах арга хэрэгслийг эрэлхийлэх, эрхээ шаардах чадвартай байх боломжийг бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд шүүх арга хэмжээг багтаасан өргөдөл гомдлыг барагдуулах, хянах механизмыг шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй, процедурын дагуу шударга, хараат бус байлгах механизмыг бэлэн байлгах ёстой. Тэд эдгээр гомдол, хянан шийдвэрлэх механизмыг хувийн эрх бүхий этгээд болон төр хоёул өөрсдийн эрх мэдлийн хүрээнд хангаж байх ёстой. Боловсрол эзэмших эрхийг урвуулан ашигласан хувийн секторын оролцогчдыг нөхөн төлбөрт хувь нэмэр оруулахыг шаардах ёстой.

90. Боловсролд хувийн секторын оролцогчдыг татан оролцуулахаас үүсэх сөрөг үр дагавар гарах, төр эдгээр асуудлыг зохих ёсоор өөрөө шийдвэрлэж чадахгүй байгаа тохиолдолд төрийн эсрэг гомдол гаргах боломжтой засах арга хэрэгсэлийг баталгаажуулах ёстой.

VI. УДИРДАХ ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Нийтлэг зарчим 10. Улс орнууд эдгээр Удирдах зарчмуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэрэгслээр хэрэгжүүлэх замаар баталгаажуулах ёстой, үүнд шаардлагатай тохиолдолд хууль эрх зүй, төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэх.

91. Хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглалыг багтаасан салбарууд эдгээр Удирдах зарчмуудыг бүх шаардлагатай арга хэрэгслээр үр дүнтэй хэрэгжүүлэх ёстой бөгөөд үүнд шаардлагатай тохиолдолд хууль эрх зүй, төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэх. Төр дотоодын, бүс нутгийн, дэлхийн хэмжээний боловсрол, хөгжлийн төлөвлөгөө, хууль, бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхдээ эдгээр Удирдах зарчмуудыг тусгаж, хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний, техникийн болон санхүүгийн нөөцийг зориулах ёстой.

92. Төр сурч, боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтынхаа хүрээнд эдгээр Удирдах зарчмуудыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй эгэх хариуцлагын механизмыг хянаж, бий болгох ёстой.

93. Төр эдгээр Удирдах зарчмуудыг холбогдох бүх эрх бүхий байгууллагууд, ялангуяа боловсролын байгууллагуудад бүх холбогдох хэл, форматаар түгээж, хүртээмж, хэрэгжилтийг хөнгөвчлөх ёстой. Төр шаардлагатай бол холбогдох албан тушаалтнууд болон боловсролын байгууллагуудад зорилтот сургалтыг өгөх ёстой.

94. Төр Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын үндсэн үүргийг хүлээн зөвшөөрч, хамтран ажиллаж, сурталчлах ёстой, үндэсний байгууллагуудын статустай холбоотой Нэгдсэн Үндэстний Байгууллагын зарчимд нийцүүлэн ажиллах, эдгээр Удирдах зарчмуудын хэрэгжилт, түгээлтэд хяналт тавих.

95. Төр сурч, боловсрох эрхээ эдлэхэд нөлөөлөх бодлогын талбаруудын уялдаа холбоог хангах, ялангуяа боловсролын бодлогод үүрэг гүйцэтгэдэг бүх шатны төрийн байгууллагууд, агентлагууд болон төрийн бусад байгууллагууд тус тусын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн хүний эрхийн үүрэг болон эдгээр Удирдах зарчимуудыг мэддэг, дагаж мөрддөг байх ёстой.

Олон улсын байгууллагууд

96. Олон улсын байгууллагууд бусад олон улсын ерөнхий хууль, олон улсын гэрээнд заасны дагуу боловсрол эзэмших эрхтэй холбоотой үүргээ биелүүлэх ёстой. Тухайн байгууллага өөрсдийн зан үйлийг эдгээр Удирдах зарчимтай уялдуулж байгаа эсэхийг баталгаажуулах ёстой.

97. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд, бүс нутгийн байгууллагууд болон хөгжлийн бусад оролцогчид эдгээр Удирдах зарчмуудыг хэрэгжүүлэхэд нь олон улсын хүний эрхийн хуулиар хүлээх хүний эрхийн үүргээс гадна дэмжлэг үзүүлэхийг уриалж байна. Ийм дэмжлэгт техникийн хамтын ажиллагаа, санхүүгийн туслалцаа, байгууллагын чадавхийг хөгжүүлэх, мэдлэг хуваалцах зэрэг орно (Хүний эрхийн Үндэсний Комисс, 2021).

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл. (2018). Хувийн сургуулиудыг төрөөс зохицуулах шаардлага . Улаанбаатар.
- “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл. (2021). Боловсролын салбарын төсөв санхүүжилтэд үзүүлэх Монгол Улсын нийт өрийн нөлөө.
- “Бүх нийтийн боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл. (2021). Боловсролын хуулийн шинэчлэл: Иргэний нийгмийн санал. Улаанбаатар.
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2002 оны May 3). Боловсролын тухай. <https://legalinfo.mn/mn/detail/9020-ээс> Гаргасан
- Хүний эрхийн Үндэсний Комисс. (2021). Хүний эрх: онол, арга зүй. Улаанбаатар.
- Хүүхдийг Ивээх Сан. (2020). Монгол Улс дахь Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ . Улаанбаатар.
- Үндэсний Статистикийн Хороо; Дэлхийн Банк. (2020). Ядуурлын дүр төрх 2018. Улаанбаатар.
- Тунгалаг, Д. (2022 оны November 23). [Urug.mn. https://fb.watch/f7ZZhLZuL-N/-ээс](https://fb.watch/f7ZZhLZuL-N/) Гаргасан
- ЮНЕСКО-ийн Боловсролын салбар. (2019). Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ.
- Хишигтөгс, А. (2020). Хүнийсэл: Өөртөө хөөгдсөн хүн. Улаанбаатар.
- Түмэннаст, Г. (2020 оны September 2). Боловсролын тэгш бус байдал ардчиллын хувь заяатай холбоотой. [Gogo.mn: https://gogo.mn/r/x0w6m-ээс](https://gogo.mn/r/x0w6m-ээс) Гаргасан
- Althusser, L. (2014). On the Reproduction of Capitalism: Ideology and Ideological State Apparatuses.
- Department for International Development. (2014). The role and impact of private schools in developing. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/439702/private-schools-full-report.pdf-ээс Гаргасан
- Global Campaign for Education. (2017). Public good over private profit.
- Global Education Monitoring Report (GEMR). (2021/2). Non-state actors in education: Who chooses? Who loses? Paris: UNESCO.
- Human Rights Council. (2015). Report of the Special Rapporteur on the right to education: Protecting the right to education against commercialization. A/HRC/29/30-ээс Гаргасан
- Verger, A., Fontdevila, C., & Zancajo, A. (2017). Multiple paths towards education privatization in a globalizing world: a cultural political economy review. *Journal of Education Policy*, <https://www.tandfonline.com/doi/full/10.1080/02680939.2017.1318453>.
- Yonhap News Agency. (2019 оны November 7). S. Korea to turn key elite schools into general ones by 2025. <https://en.yna.co.kr/view/AEN20191107010200315-ээс> Гаргасан

Талархал

“Стратегийн судалгаа” сэтгүүлийн энэхүү дугаарыг бэлтгэн хэвлүүлэхэд бүх талаар дэмжлэг үзүүлсэн “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн хамт олонд талархал илэрхийлье.

СТРАТЕГИ АКАДЕМИ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН